

Өмнөх үг

Монгол Улсын нийгэм-эдийн засгийн шинэ нөхцөлд газрын харилцааны эрх зүйн орчны шинэтгэлийн хүрээнд гарсан Газрын тухай багц хуулиудаар газрын харилцааны зохицуулалт улам бүр боловсронгуй болж газрын үр өгөөжийг зөвхөн ашиглах бус, хамгаалах, нөхөн сэргээх, газрын харилцаанд оролцогчдод тэгш шударга байдлыг хангасан эрх, үүргийн харьцааг тэнцвэржүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл бүрдсэн.

Газар нь байгаль, дэлхийн үүсэл хөгжлийн дүнд бий болсон сав шимийн ертөнц учраас түүний ашиглалтын хэм хэмжээ өөрийнх нь унаган чадавхиар тодорхойлогддог. Ийм практик Монгол Улсын хувьд нилээд шинэлэг асуудлын нэг юм. Харин дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн үндэс нь газар болоод газраас үндэстэй байгалийн баялгийг зөв зохистой ашиглан нийгэм-эдийн засгаа хөгжүүлэх зарчимд тулгуурласан байдаг бөгөөд монгол оронд үүнийг хэрэгжүүлэх гол механизм нь улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө юм. Хуулийн хүрээнд газар зохион байгуулалтыг газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрын кадастр эрхлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавхи, нөөцийг нэмэгдүүлэх, газарзүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх зорилготой цогцолбор арга хэмжээ гэж тодорхойлжээ.

Газрын тухай багц хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Орхон аймгийн Даргын Тамгын Газрын захиалгаар Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг газрын судалгааны мэргэжлийн байгууллага “Газар сервис” ХХК, “Ланрес” ХХК 2004 онд “Газар сервис” ХХК-ний зөвлөх мэргэжилтэн Ц.Бадам, газар зохион байгуулагч инженер Д.Мөнхцэцэг, Р.Алтанзул, хөрс судлагч Б.Мөнхбат, эдийн засагч Д.Баясгалант, төслийн удирдагч “Ланрес” ХХК-ний захирал, доктор Г.Пүрэвцэрэн, бэлчээр судлаач П.Мягмарцэрэн, геоморфологич-хот суурингийн экологич доктор Ч.Батсайхан, цаг уурын инженер М.Баясгалан, ургамал судлаач-агрохимич Д.Цэцгээ, туслах ажилтан Ш.Ариунаа, Б.Алтанцэцэг, С.Батболд, Я.Ичинхорлоо, Г.Жаргал нарын бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэв.

Орхон аймгийн газар ашиглалтын одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг газрын менежментийн бодлогоор дэмжин экологийн болоод эрх зүйн тогтвортой ашиглалтын үндсийг хангахад энэхүү төлөвлөгөөний гол ач холбогдол оршиж байна.

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1 Онол - аргагүйн үндэслэл

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа Орхон аймгийн байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийг тодорхойлох, нийгэм эдийн засгийн хөгжлийн өнөөгийн ба хэтийн чиглэл дүн шинжилгээ хийх зорилгоор доорхи суурь судалгааг явууллаа. Үүнд:

- Уур амьсгал
- Газрын гадаргуу
- Хөрсөн бүрхэвч
- Ургамлан нөмрөг
- Нийгэм-Эдийн засагийн нөхцөл
- Газар ашиглалтын өнөөгийн байдал г.м

Суурь судалгаа нь газар ашиглалтын эрчимжилт, нутаг дэвсгэрийн хамрах хүрээнээс нь шалтгаалан өөр өөр байсан боловч Монгол улсад хийгдэж буй том масштабын анхны иж бүрэн судалгаа зураглалын ажил гэж үзэж болох юм.

Газрын гадарга болон бүрхэвчийн судалгаа болон газар ашиглалтын өнөөгийн байдлын судалгааг 1:25 000, хот суурин, үйлдвэр уурхайн газрын судалгааг 1: 2 000 масштабын нарийвчлалаар явуулсан ба зураглал боловсруулалтын ажилд “ASTER” хиймэл дагуулын мэдээг ашигласан болно. Мэдээлэл боловсруулалтанд газарзүйн мэдээллийн системийн ArcView 3.2 , Arc INFO 3.5 болон зураглалын AutoCad 2000 зэрэг программуудыг ашиглаж бүх мэдээллийг тоон хэлбэрт шилжүүлэв.

Аймгийн нийгэм-эдийн засгийн нөхцлийн судалгаанд SWOT харьцуулалт-шинжилгээний аргыг ашиглан хөгжлийн цаашдын хандлагыг төлөвлөлтийн үе шатуудаар тодорхойллоо.

Орхон аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн зарчим нь байгаль нутаг дэвсгэрийн нөхцөл, нөөцийн боломжид тулгуурласан газрын менежментийн бодлогын бүсүүдийг тодорхойлж бүс тус бүрийн ашиглалтын горимыг илрүүлэх, газрын нэгдмэл сангийн шилжилт, улмаар эдийн засгийн үр ашигтай газар ашиглалтын төрлүүдийг бүрдүүлэхэд тулгуурласан юм.

1.2. Байгаль - нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөл, нөөцийн үнэлгээ

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн үндэс нь тухайн газар нутгийн байгалийн нөхцөл, нөхцөл нөөцийн чадавхийн үнэлгээ бөгөөд үүнд газрын гадаргуугийн хотгор, гүдгэр, уур амьсгал, усан хангамж ба ус зүй, хөрс ба ургамлан бүрхэвч багтдаг ба үүнд зохицсон экологийн хохиролгүй, эдийн засгийн хувьд нэмүү ашигтай газар ашиглалтын хэлбэрийг илрүүлэн төлөвлөх явдал болно.


1.2.1. Уур амьсгал

Орхон аймгийн нутаг дэвсгэр нь Хангайн Их уулархаг мужийн төв хэсэгт байрлах ба уур амьсгалын хувьд илүү чийглэг-сэрүүн бүсэд оршино. Цаг уурын ажиглалтын олон жилийн дундажаас харвал жилийн дундаж температур нь -0,8 хэм буюу жилийн хамгийн хүйтэн 1-р сард цельсийн хасах 15 хэмээс хасах 40 хэм зарим тохилдолд хасах 50 хэм, хамгийн халуун VII сард дундаж нь +15- 25 хэм, хамгийн их утга нь 35 - 43 хэм хүрдэг тохиолдол ажиглагджээ. Идэвхтэй дулааны нийлбэр 1000 - 1700 хэм, хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 90- 100 хоног байгаа нь ургамлын ургах үеийн дулаан тийм бага бишийг нотолно.


Нийгэм-эдийн засгийн хөгжилд ихээхэн нөлөөтэй уур амьсгалын үзүүлэлт нь агаарын температурын хоногийн ба жилийн явц бөгөөд түүний илрэл сүүлийн 2 жилд орхон аймгийн хэмжээнд ямар байсныг дараахи хүснэгтэд харуулав. / Хүснэгт 1 /

Хүснэгт 1. Сар жилийн агаарын температур / °C /

Сарууд	2002 он			2003 он		
	I арав хоног	II арав хоног	III арав хоног	I арав хоног	II арав хоног	III арав хоног
1	-7,4	-12,5	-14,8	-16,4	-10,9	-16,5
2	-10,8	-7,0	-8,6	-14,3	-10,1	-10,4
3	-4,7	-2,7	-0,3	-11,4	-9,0	0,0
4	-2,1	1,9	5,3	1,6	-2,3	-8,4
5	3,6	11,2	15,1	8,1	6,7	12,0
6	16,0	17,6	19,3	16,0	19,0	14,8
7	19,9	17,7	24,3	16,6	19,8	15,8
8	17,3	24,0	16,7	14,5	12,2	13,5
9	12,4	19,7	11,3	10,3	9,9	7,3
10	1,6	3,3	-8,4	0,4	-0,6	3,3
11	-6,0	-14,8	-10,2	-11,1	-9,2	-15,1
12	-15,1	-15,9	-21,1	-19,8	-13,8	-10,6
Жилийн дундаж	-0.6	-1.04	-1.2	-1.3	-0.9	-1.3



Диаграмм 1. Агаарын температурын хоногийн явц 2002 он



Диаграмм 2. Агаарын температурын хоногийн явц 2003 он

Дээрхи хүснэгт болон графикаас харвал 2002 ба 2003 оны хүйтний улирлын температурын хувиарлалт тодорхой тогтолцоогүй ихээхэн хэлбэлзэлтэй байгаа нь харагдаж байна. Жишээ нь 2002 оны 1-р сард температурын бууралт жигд байсан бол 2003 онд хэлбэлзсэн тогтворгүй байна. 3-р сарын хувьд 2003

оны эхний 2 арав хоногийн температурыг 2002 оныхтой харьцуулахад хүйтэрсэн байхад сүүлийн арав хоногт эрс дулаарч 0 °С болжээ. Ер нь аль аль оны 3-р сард тогтвортой дулааралт ажиглагджээ. Гэтэл 4-р сарын хувьд 2002 онд дулааралт байсан бол 2003 онд хүйтэрч III арав хоногт - 8,4 °С болтлоо буурсан байна. Аль аль оны 5-р сард эрс дулааралт ажиглагдаж байна. Ялангуяа 2003 оны 4-р сарын сүүлийн 10 хоногийн дундаж температур -8,4 байсан бол 5-р сарын эхний 10 хоногт 8,1 болон өсч бараг 16,5 градусаар дулаарсан байна. 2002 оны 6-р сарын хувьд температурын өсөлт тогтвортой байгаа бол 2003 оны 6-р сард температур хэлбэлзэж II арав хоногт өссөн бол III арав хоногт эргэж унасан байна. Харин 7-р сард аль аль оны хувьд температур хэлбэлзсэн байдал ажиглагдсан хэдий ч 2002 оны 7-р сарын III арав хоногийн температур 2003 оныхоос эрс өндөр байна. 2002 оны 8 сар 2003 оныхыг бодвол мөн л харьцангуй дулаан байгаа бөгөөд ялангуяа II арав хоногуудын температуруудын зөрөө маш их байна. / бараг 12 хэм / . Харин 9-р сард аль аль онуудад температурын уналт ажиглагдаж байна. 2002 оны 10-р сард температурын уналт илт ажиглагдаж байгаа ч 2003 онд байдал өөр байгаа бөгөөд III арав хоногт л гэхэд дулаарал ажиглагдаж байна. Аль аль оны 11-р сард температурын тогтвортой хэлбэлзэл ажиглагдаж байна. Харин 2002 оны 12 сард температурын бууралт ажиглагдаж байгаа бол 2003 оны хувьд эсрэгээр дулаарч байна.

Эдгээрээс харвал тус аймгийн агаарын температурын хэлбэлзэл улирлын зааг саруудад хэт хэлбэлзэж дундаж саруудад харьцангй тогтвортой байна. Энэ нь ялангуяа 1,2,3,6,7 - р саруудад тодорхой ажиглагдана.

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд яригдах болсон уур амьсгалын дулааралтын байдлыг тогтоох зорилгоор сүүлийн 10 жилийн агаарын дундаж температурын утгыг 2003 оны агаарын дундаж температуртай харьцуулахад 0,3 хэмээр хүйтэрсэн нь уур амьсгалын эрс өөрчлөлтийг нотлохгүй байна.

Чийгийн хангамжаар Орхон аймгийн нутаг дэвсгэр нь монгол орны хувьд харьцангуй сайн бүсэд тооцогдоно. Жилд дундажаар 350- 400 мм тунадас унадаг ба 2003 онд 598.4 мм тунадас унасан нь нилээд чийглэг байсныг харуулна. Хур тунадасны 50-70 хувь нь дулааны улиралд унадаг. Голдуу жилд 131 өдөр хур тунадастай байна. Өвлийн улиралд цасан бүрхүүлийн зузаан ууландаа 12 см, тал газартаа 20 см, хонхор, гуу жалгандаа 25 см-ээс дээш байдаг.

Ургамлын ургах үеийн чийгшилтийн үзүүлэлт 0,25 - 0,35. Хэдийгээр хур тунадас бага биш боловч нэг жилийн доторхи хуваарилалт өөр өөр ургамлын ургах үеийн эхний хагаст / 5,6 сард / хур тунадас ховор, хуурайвтар, салхины хүч ихсэж температур түргэн нэмэгддэгээс ууршуулж ялангуяа тариалангийн хөрс элэгдэж эвдрэх, мөн Эрэдэнт үйлдвэрийн хаягдлын аж ахуйн тоосны хэмжээ ихсэх шалтгаан болно.

Жилийн дундаж салхины хүч 4 м/сек бөгөөд зонхилох чиглэл нь баруун болон баруун хойт зүг юм. Салхины хамгийн сул хүч 6-р сард, эрчимжилт ихтэй үе нь 4,5 сарууд байна.

Цаг агаарын аюултай үзэгдлүүдээс нилээд түгээмэл тааралддаг нь цасан ба шороон шуурга, хэт халуун /30 хэмээс дээш/-ы үзэгдлүүд бөгөөд тэдгээрийн илрэл нутаг дэвсгэрийн болоод цаг хугацааны дотор харилцан адилгүй байна.

Ер нь цаг агаарын аюултай үзэгдлийн давтамж 4 - 5 сард хамгийн их, 3 ба 12 сард хамгийн бага тохиолдож бүх гамшгуудын дотроос шороон шуурга дийлэнхийг эзэлж байна. /Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор үнэлгээ” суурь судалгааны тайлангаас

Уур амьсгалын дээрхи нөхцлүүдийн илэрцийн хэмжээ газрын гадаргуугийн өндөржилт, зүг зовхис, хөрс ургамлан нөмрөгийн онцлогоосоо шалтгаалан өөр байдаг бөгөөд тус аймгийн хувьд гэрэл, дулааны нөхцлөөрөө Хангалын сав болон Улаантолгой сав газрууд илүү тааламжтай байна.

1.2.2. Ус зүй ба усан хангамж

Орхон аймгийн нутаг дэвсгэрт гадаргын уст цэг 44 байгаагаас гол горхи 10 буюу 20.2 хувь, рашаан 3, булаг 25 буюу 60.3 хувь, жижиг нуурууд 6 буюу 19.5 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээрээс хамгийн томоохон нь Хангал ба Чингэлийн голууд ба хүн малын ундны хэрэгцээнд өргөн ашиглагдана

Хангал голын ус хураах ай савын хэмжээ 1029,6 хавтгай дөрвөлжин км бөгөөд Орхон аймгийн баруун хойноос зүүн урагш урсаж Орхон голд нийлнэ. Түүний баруун гараас нь Эрдэнэтийн гол / $S = 103 \text{ км}^2$ / , Даристын гол / $S = 20 \text{ км}^2$ / , Уртын гол / $S = 84,4 \text{ км}^2$ / Хуурай гол / $S = 48,1 \text{ км}^2$ / зэрэг жижиг гол горхи цутгана.

Ай савын 40,8 хувь буюу 419,7 км² нь зүүн гар талд буюу Орхон аймгийн нутагт ноогдож байна. Хотгор гүдгэрийн нөхцлөөс шалтгаалж ус зүйн сүлжээний нягтшил харилцан адилгүй 0,5 - 2,0 км/ км² хооронд хэлбэлзэж сав газрын дундаж нь 0,15 км / км² байна.

Сүлжээний нягтшилын их хэмжээ нь усны хагалбар Дарист, Согоот, Бөхөнгийн салбар уулст байдаг бол бага хэмжээ нь Шувуут, Хөшөөт, Дулаанхаан зэрэг уулсын өвөр хажуу, бэлийн хэсэгт ноогдож сүлжээний нягтшил 0,5 - 1,0 км/км² буюу түүнээс ч бага байна.

Хангал голын савд цутгах байнгын усан урсгалтай гол горхи булаг шандны уртын 65,9 хувийг Хангал голын эхний цутгал Говил, Зуны гол, Хуурай, Даристын голууд бүрдүүлнэ.

Сүүлийн жилүүдэд тохиолдож буй уур амьсгалын хэт дулаарал, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс 9 булаг, 2 нуур ширгэж, 8 гол горхины эх нь газар доогуур шургасан байна.

Хангал голд цутгаж байсан Согоотын гол, Шувуутын голууд тасарсан ба Хангал голын дагуу газар тариалангийн усалгаанд зориулж суваг олноор татсанаас голын усны хэмжээ багасчээ. Нийт 3 рашаан тоологдсоноос Хүрэнбулаг, Бортын

амны рашаанууд азот, хүхрийн найрлагатай, хүчиллэг орчинтой бөгөөд Хөөврийн рашаан нь эрдэс бодистой тул эмчилгээний зориулалтаар нутгийн иргэд ашигладаг.

Судалгаанаас үзэхэд ерөнхийдээ энэ аймгийн нутагт гадаргын ус зүйн сүлжээ харьцангуй сайн хөгжсөн боловч гол горхины эхийг ойжуулах, хамгаалалтын зурвас байгуулах, булаг, шанд, рашаануудыг хамгаалал танд авч тохижуулах ажлуудыг зохион байгуулан хэрэгжүүлэх нь чухал байна.

Орхон аймгийн гадаргын ус зүйн сүлжээг үзүүлэв. / Зураг.1 /

1.2.3. Газрын гадарга

Орхон аймгийн газрын гадарга нь бүхэлдээ Хангайн уулт орны Бүрэнгийн нурууны баруун - өмнөд салбарт хамаарагдах ба дундаж өндөр уулсын хотгор гүдгэрийн хэв шинжтэй байна. Гадаргын үнэмлэхүй өндөр нь далайн түвшнээс дээш 961 – 1771 метрийн хооронд хэлбэлзэнэ. Энд хотгор гүдгэрийн өндөржилтийн хэлбэлзлийн зөрүү 810 метр буюу төдийлэн их биш байгаа нь энэ нутаг дэвсгэр нь рельефийн энерги багатай болохыг гэрчилж байна.

Нутгийн хамгийн өндөр цэг нь Согоот уул 1711 метр, хамгийн нам цэг нь Айрагийн даваанаас баруун урагш 2 км орчимд орших 961 метрийн буурц хотгорт байршжээ.

Хангал голын сав нутаг нь тектоник структурын мужлалаар хойд Монголын атриат системийн Жидийн бүсийн зүүн өмнөд төгсгөлд хамрагдах бөгөөд Сэлэнгийн сав нутгийн төвийн янз бүрийн хэмжээний ам хөндий, хотос болон урсгал буюу түр урсгалтай гол горхийн хөндийгөөр зааглагдсан нам ба бэсрэг уулсын ерөнхий төрхтэй байна.

Энэ нутгийн газрын гадаргыг рельефийнх нь дотоод бүтэц, морфометрийн үндсэн үзүүлэлтүүд болон нутаг дэвсгэрийн үнэмлэхүй өндөр ба өндөржилт зэргийг үндэслэн дараах морфогенетик хэв шинжүүдэд хувааж үзэж болох юм. Үүнд :

1. Дундаж өндөр уулсын хэв шинжийн хотгор гүдгэр.

Энд Хангалын сав нутгийн ус хагалбарын шугамыг үүсгэж байгаа 1500 м - ээс дээш өргөгдсөн Баян өндөр, Цагаан чулуут, Баруун залаат уул, Согоот, Их Залаат уул, Бөхөн, шувуут, Бор өндөр, Даристын нурууны төв хэсэг хамрагдана.

Уулс нь харьцангуй гүн хэрчсэн нугачаат хэлбэрийн тогтоцтой ба уулын оройн өвөр талын эгц хажуу нь сэвсгэр хурдсаар маш нимгэн хучигдах ба уулсын оройн хэсэгт ил гарсан хад чулуу бараг байхгүй, голдуу хөрс ургамлаар нилээд сайн хучигдсан бөмбөгөр хавтгай байх нь элбэг. 1300- 1711 метрийн өндөртэй эдгээр хэв шинжийн уулс нь 100 метр хүртэл хэрчигдлийн гүнтэй түр зуурын ба байнгын урсацтай хөндий болон сайруудаар зүсэгджээ.

2. Хуурай сайр, түр зуурын урсгал усанд хэрчигдсэн нам уулсын хэв шинжийн хотгор гүдгэр

Хуурай сайр, түр зуурын урсгал усанд хэрчигдсэн куэст хэлбэрийн эдгээр нам уулсын хэв шинжийн хотгор гүдгэрт Шувуут, Бөхөн, Даристын нурууны захын салбар уулс, Арцат зэрэг үнэмлэхүй өндөр нь 1200- 1300 метр хүрэх уулс

хамрагдана. Уулсын оройн хэсэг гол төлөв бөмбөгөрдүү, эх чулуулаг ил гарах боловч сэрдийж харагдах нь бага.

Уулсын оройн хэсгээс хажуу бэлийг дагаж сэвсгэр хурдас зузаарч байгаа бөгөөд цас борооны усанд эдэгдэж гүн жалгуудаар хэрчигдсэн байна. Түүнчлэн түр урсацтай гол горхины усанд нэгэн адил ухагдаж хэрчигдсэн байдаг тул жалгын хэлбэр хэмжээ харилцан адилгүй нэг хэсэг нь 35- 40 градус налуу бүхий эгц хажуутай хавчиг ёроолтой, ойролцоогоор 50 метр хүртэл гүн хэрчигдэлтэй, 1 км хүртэл өргөнтэй байна.

3. Түр зуурын урсгал усанд идэгдсэн бэл хормойн хурдаст ухаа гүвээ бүхий нам уулсын хэв шинжийн хотгор гүдгэр

Энэ хэв шинжийн хотгор гүдгэрийн үнэмлэхүй өндөр нь 1100 – 1200 метр байна. Энэ ангилгаанд гол төлөв хоёр дахь хэв шинжийн хотгор гүдгэрийн захын нам уулсууд хамрагдана. Эдгээр нам уулс нь Хангал гол руу түрж орж ирэх буюу бэл хормойн хурдсын хүрээлэн оршино. Эдгээр нам уул нь битүүдээ сэвсгэр хурдсаар хучаастай, харьцангуй сайн ургамлан бүрхэвчтэй болно

4. Тогтмол буюу түр зуурын урсацтай голын хөндий болон уулс хоорондын хөндий маягийн хотгорын хэв шинж

Энэ хэв шинжийн хотгор гүдгэрт Хангал түүний цутгал болон түр урсгалтай гол горхи, уулс хоорондын ам хөндий тэдгээрийг хүрээлэн орших хормойн хурдаст өргөн бэлүүд хамрагдана. Түр урсацтай гол, горхи, голын хөндийн нарийн зурвас хэсэгт гарал үүслийн хувьд холбоотой гуравдагч, дөрөвдөгчийн галавт явагдсан тектоник хөдөлгөөний эрчимжилтийн үр дүнд үүссэн аллювийн хурдас наас тогтоно. Энэ хэв шинжийн гадарга нь аль ч төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд ашиглагдах боломжтой юм.

Тус аймгийн газрын гадаргын аж ахуйн үйл ажиллагаанд тохиромжтой байдлаар нь ангилан хүснэгт болон зургаар харуулав. /Хүснэгт 2, зураг 2/

Хүснэгт.2. Газрын гадаргын үнэлгээ

Газрын гадаргын үзүүлэлт	Эдийн засгийн салбарууд				
	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь	Газар тариалан	Зам тээвэр	Барилга	Мал аж ахуй
Гадаргын налуу/ град/					
11 - 20	44.0	Тохиромж муутай	Ихээхэн бартаатай	Боломжгүй	Тохиромж муутай
6 - 11	24.0	Бага зэрэг тохиромжтой	Бартаатай	Тусгай хамгаалалт хийнэ	Тохиромжтой
2 - 6	32.0	Дунд зэрэг тохиромжтой	Анхны ба дунд зэргийн бартаатай	Гадаргыг засах шаардлагатай.	Нэн тохиромжтой

Гадаргын хэрчигдлийн шигүү/ км /					
0,5 -1	28	Тохиромжгүй	Бартаат	Нэн тохиромж-гүй	Дунд зэрэг тохиромжтой
1 - 2	42	Дунд зэрэг тохиромжтой	Дунд бартаат	Тохиромж муутай	Бага зэрэг тохиромжтой
2- 4	30	Бага зэрэг Тохиромжтой	Бага бартаат	Тохиромж-той	Тохиромжтой
Гүний хэрчигдэл/ м /					
50 -100	44.2	Тохиромжгүй	Нэн бартаат	Боломжгүй	Тохиромж бага
25 - 50	24.0	Бага зэрэг тохиромжтой	Дунд бартаат	Дунд зэрэг хязгаартай	Тохиромжтой
0 - 25	31.8	тохиромжтой	Бага бартаат	Бага зэрэг хязгаартай	Нэн тохиромжтой

Аймаг нь олон жилийн цэвдэг алаг цоог тархсан бүслүүрт байрлах ба уулын ар хажууд 1450 -1600 м - ийн үнэмлэхүй өндөрт 5- 10 м -ийн зузаан тархсан бол харин 1450 м-ээс бага өндөртэй уулсын хажуу, хуурай хээр тал, хөндийд олон жилийн цэвдэг тархаагүй байна.

Энэ нутагт янз бүрийн гаралтай дөрөвдөгчийн сэвсгэр хурдас болох хайрга, элс, элсэнцэр, шавранцар гэх мэтийн ул хөрс түгээмэл тархаж дундажаар 2,4-4,0 метр зузаантай хөлддөг ба элсэнцэрт 3,1 - 3,4 м , өмнөт хажууд 2,0 -2,5 м, голын хөндийн хайргатай элсэнцэр ул хөрсөнд 2,5 -3,0 м, суурь чулуулагт 4,0 - 5,0 метрт тус тус ажиглагджээ. /ГЗЦСХ-ийн бүтээлээс/ Харин улирлын цэвдгийн үр дагавар болох жижиг дов сондуул, бичил хонхорууд үүссэн байх нь олонтоо байна.

Дээрхи байдлаас дүгнэвэд Орхон аймгийн газрын гадарга нь ерөнхийдөө уулархаг зэрэглэлд орох боловч уул хоорондын өргөн хотсууд эдийн засгийн ямар ч салбарыг хөгжүүлэхэд харьцангуй тааламжтай байна.

1.2.4. Хөрс, хөрсөн бүрхэвч

Тус аймгийн хөрсөн бүрхэвч үндсэндээ доор дурьдсан хөрс үүсгэгч эх чулуулаг дээр үүсэн тогтжээ.

- Делювийн дунд шавранцар хурдас- Д
- Делювийн хөнгөн шавранцар хурдас- Д
- Элюви-делювийн хөнгөн шаварлаг хурдас- ЭД
- Эртний аллювийн дунд шаварлаг хурдас- А
- Эртний аллювийн хүнд шаварлаг хурдас- А

Э- Эллювийн хурдас нь өгөрших үйл явцад орж ан цав гарч хагарсан хурц ирмэг бүхий хад чулуу бөгөөд анхны үүссэн байрандаа үлддэг ба үүнд уулын орой, хяраар тохиолдох чулуулаг хамрагдана.

Д- Эллювийн хурдас халуун, хүйтэн, ус, чийгийн нөлөөгөөр хагаран бутарч, салхи усаар зөөгдөн байраа өөрчилсөн хурц ирмэг бүхий жижиг үйрмэг чулуулгийг делювийн хурдас гэх бөгөөд уулын хажуу налуу болон бэлээр тархана.

А- Өгөршилд орсон уулын чулуулгууд усны нөлөөнд хүчтэй орж, чулууны хурц ирмэгүүд нь мөлийж аллювийн хурдсыг үүсгэдэг энэ нь голын хөндий, нам хотсуудаар тархана. Аллювийн хурдас нь эртний галавын уламжлалтай учраас голдуу шаварлаг бүтэцтэй болжээ.

Аймгийн нутаг дэвсгэр нь хөрс-цаг уурын мужлалаар Хангай нурууны уулт хээрийн бүсийн хүрэн хөрсний тойрогт багтах бөгөөд түүний тогтоцод газрын гадаргын нөлөө чухал байр эзэлнэ. Эндэхийн хөрсний гарал үүсэл эх газрын эрс тэс уур амьсгал, тачир сийрэгдүү ургамлан нөмрөг, уулын чулуулгийн геологийн тогтоцтой салшгүй холбоотой ба хөрсний тархалтын байдлыг зураг 3-т, бүтцийг хүснэгт 3-аар тус тус харууллаа.

Хүснэгт 3. Орхон аймагт тархсан хөрсний бүтэц

Хөрсний индекс	Хөрсний нэр	Механик бүрэлдэхүүн	Хөрс үүсгэгч эх чулуулаг	Хөрсий тархалтын гадрага	Талбай	
					га	хувь
А.Уулын хөрс						
1	Уулын сулавтар хөгжилтэй хар шороон хөрс	Хөнгөн шавранцар	ЭД	Уулын орой хяр	584.9	0.7
2	Уулын хар шороон хөрс	Хөнгөн шавранцар	ЭД	Уулын ар хажуу	541.5	0.6
3	Уулын сулавтар хөгжилтэй хар хүрэн хөрс	Хөнгөн шавранцар	ЭД	Уулын орой хяр	4049.2	4.7
4	Уулын хар хүрэн хөрс	Хөнгөн шавранцар	ЭД	Уулын хажуу бэлээр	8419.9	9.7
5	Уулын сулавтар хөгжилтэй хүрэн хөрс	Хөнгөн шавранцар	ЭД	Уулын орой хяр	1760.03	2.0
6	Уулын хүрэн хөрс	Хөнгөн шавранцар	ЭД	Уулын хажуу хормой бэл	6373.89	7.3
7	Уулын нугын хөрс	Хөнгөн шавранцар	Д	Уулсын хоорондох нарийн ам	678.5	0.8
8	Уулын ойн бараан өнгийн хөрс	Хөнгөн шавранцар	ЭД	Ой дотор , ойн доод бэл	27695.03	31.8
Б.Талын хөндийн хөрс						
9	Зузаан бараан өнгийн хөрс	Дунд шавранцар	Д	Уулс хоорондын хөндийн ёроол	1108.58	1.3
10	Дунд зэргийн зузаан бараан өнгийн хөрс	Дунд шавранцар	Д	Уулсын хоорондох хөндий	215.1	0.2
11	Нимгэн бараан өнгийн хөрс	Дунд шавранцар	Д	Хангал голын дэнжээр	1393.02	1.6
12	Зузаан хар хүрэн хөрс	Дунд шавранцар	Д	Уулсын хоорондох хөндий	4013	4.6

13	Дунд зэргийн зузаан хар хүрэн хөрс	Дунд шавранцар	Д	Уулсын хоорондох хөндий	5303.88	6.1
14	Нимгэн хар хүрэн хөрс	Дунд шавранцар	Д	Уулсын хоорондох хөндий	4438.82	5.1
15	Дунд зэргийн зузаан хүрэн хөрс	Дунд шавранцар	Д	Уулсын хоорондох хөндийн налуу	325.7	0.4
16	Дунд зэргийн зузаан хүрэн хөрс	Хөнгөн шавранцар	Д	Уулсын хоорондох хөндий ухаа гүвээт толгодоор	2999.9	3.4
17	Нимгэн үүрмэг чулуутай хүрэн хөрс	Хөнгөн шавранцар	Д	Уулсын хоорондох хөндий, налуу	3690.7	4.2
18	Нимгэн хүрэн бага зэрэг чулуулаг хөрс	Хөнгөн шавранцар	Д	Уулсын хоорондох өргөн хөндий гүвээ толгодоор	5870.3	6.7
19	Угаагдсан хүрэн хөрс	Хөнгөн шавранцар	Д	Уулсын хоорондох хөндий	1207.78	1.4
20	Нугын хөрс	Дунд шавранцар	Д	Уулсын хоорондох нарийн ам	2612.6	3.0
21	Аллювийн нугын хөрс	Дунд шавранцар	А	Голын сав	1621.5	1.9
22	Аллювийн нуга намгийн улирлын цэвдэгт хөрс	Дунд шавранцар	А	Голын сав	1593.1	1.8
23	Гуу жалга	Дунд шавранцар		Гуу жалга	472.0	0.5
Бүгд					86968.8	100.0

Хөрсний гарал үүсэл, шинж чанарын талаар газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд 1:25 000 нарийвчлалаар хийгдсэн хөрсний суурь судалгааны тайланд дэлгэрэнгүй туссан тул товчлон хөрсний агроүйлдвэрлэлийн шинж чанарыг харуулав. /Хүснэгт 4/

Хүснэгт 4. Хөрсний агроүйлдвэрлэлийн бүлэглэл

Агроүйлдвэрлэлийн группын дугаар	Хөрсний агроүйлдвэрлэлийн бүлэглэлд хамрагдаж буй хөрсний нэр, тархалт	Хамрагдах хөрсний индекс	Хамрагдах нийт талбай га	Хөрс сайжруулах болон зохистой ашиглах арга хэмжээний зөвлөмж
	Тариаланд тохиромжтой сайн чанарын хөрс.			

I	Уулсын хоорондох хөндий, Хангал голын саваар тархах шавранцар механикийн бүрэлдэхүүнтэй бараан өнгийн болон нугын хөрс, зузаан ба дунд зэргийн зузаан хүрэн хөрс, зузаан ба нимгэн хар хүрэн хөрсний төрлүүд	9,10,11,12,13,14,15,16,	18610.1	Хөрсийг эвдрэлд орохоос урьдчилан сэргийлэх энгийн арга хэмжээ авах, хавж хагалах, гуурсанд тариалах зонхилох, салхины хөндлөн чиглэлд зурваслан хагалах, түүний өргөн нь 100 м байх. Мөн энэ хөрсөнд нутагшсан сортын үр тариалахыг зөвлөж байна.
Тариаланд тохиромжтой дунд чанарын хөрс.				
II	Уулсын хоорондох хөндий, намхан ухаа гүвээ толгодоор тархах шавранцар механикийн бүрэлдэхүүнтэй дунд зэргийн зузаан, бага зэргийн үйрмэг чулуутай, мөн нимгэн бага зэрэг үйрмэг чулуутай хүрэн хөрс дангаараа болон бүрдэлээр	17,18,19,20	12907.7	Хөрсний эвдрэлд оруулахгүйн тулд хавж хагалах, гуурсанд тариалах зонхилох, салхины хөндлөн чиглэлд зурваслан хагалах, зурвасны өргөн нь 100 м Энэ хөрсөнд үр тариа, үр тариа-тэжээл тариалах
Тариаланд тохиромжтой доод чанарын хөрс.				
III	Уулсын хоорондох өргөн хөндий ухаа гүвээ толгодоор тархах шавранцар ба элсэнцэр механикийн бүрэлдэхүүнтэй дунд зэргийн зузаан хүрэн ба нимгэн хүрэн хөрс 20-30%-ийн бүрдэл	20,21	3393.9	Энэ хөрсийг үр тарианд ашиглахдаа салхины эвдрэлээс хамгаалах арга хэмжээг дэс дараатайгаар авах, цомхотгосон технологи хэрэглэх, ойн зурвас байгуулах
Хадланд тохиромжтой сайн чанарын хөрс				
IV	Уулын ойн бараан өнгийн хөрс, болон уулын нугын, уулын хар хүрэн, хүрэн, зузаан хүрэн, хар хүрэн хөрс бүхий уулс хоорондын өргөн нарийн ам хөндий, голын хөндий	7,9,10	2574.5	Жил бүр хадаж болох боловч, бууц бордоо цацах, хашиж хамгаалах арга хэмжээ авах
Хадланд тохиромжтой доод чанарын хөрс.				
V	Уулын хар хүрэн, хүрэн, тал хөндийн дунд зэргийн зузаан, хөнгөн шавранцар хар хүрэн ба хүрэн хөрс, голын сав газрын хөрс /алювийн нугын/ хөрсний төрлүүд	4,6	11139.0	Жил өнжиж хадаж ашиглах ба өвлийн цагт цас тогтоох, бууц цацах, услах, бордох ажлыг хийх их чухал
VI	Бэлчээрт тохиромжтой сайн чанарын хөрс.			

	Уулын хар шороон ба хар хүрэн, хүрэн, нугын бараан өнгийн хөрсний төрлүүд	4,2	2284.7	Бэлчээрт тохиромжтой хөрсийг жилийн аль ч улиралд ашиглаж болно. Гэхдээ хуваарьтай ашиглах нь ирээдүйд хэрэгтэй. Алс холын бэлчээрийг ашиглахдаа худаг ус гаргах
VII	Бэлчээрт тохиромжтой доод чанарын хөрс.			
	Хангал, Чингэлийн голын хөндийн зун намрын бэлчээрт ашиглагддаг уулын ойн бараан өнгийн хөрс, уулын сулавтар хөгжилтэй хар шороон, хар хүрэн, хүрэн уулын нугын, гуу жалгын болон тал хөндийн талхлагдсан газрын хөрс	1,3,5, 19,22	7876.4	Энэ төрлийн бэлчээрийг хамгийн түрүүнд хуваарьтай ашиглах, сэлгээ хийх нь чухал юм. Сэлгээ хийхгүй бол хөрс үржил шимээ алдаж улаан элс болно гэдгийг анхаарах ёстой
VIII	Ойн хөрс			
	Ойн хөрс	8	27695.0	Ойн бэлчээрийг хязгаарлагдмал байдлаар хавар намар бэлчээрийн эдэлбэр, хадланд ашиглана
IX	Нүцгэн газар			
	Гуу сайр- хад чулуу	23	487.5	Ашиглахад тохиромжгүй

1.2.5. Ургамал- ургамлан бүрхэвчийн онцлог

Хангай нурууны чийглэг сэрүүн уур амьсгал, өндрийн бүс бүслүүрийн ялгааны нөлөөгөөр Орхон аймгийн ургамлан бүрхэвч дундаж уулнаас нам хотос хүртэл нилээд ялгавартайгаар бүрэлдсэн бөгөөд ерөнхий зүй тогтлоороо нугархаг хээрийн ургамалжилтанд хамрагдаж байна. Ургамлын бүтэц бүрэлдэхүүн баялаг, нөмрөг нь өтгөн байна. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн ургамлан нөмрөгийн судалгаагаар тус аймгийн нутаг дэвсгэрийн ургамалжилт, төрх байдлыг улсын хэмжээнд мөрдөж буй бэлчээр хадлангийн ангилгаагаар ангилахад дундаж өндөр болон нам бэсрэг уулын бэлчээр - У, уул хоорондын нарийн хөндийн - УХ, тал хээрийн -Х, голын хөндий, нам хотосын нугын -Н гэсэн бэлчээр 4 ерөнхий хэв шинжид хамруулж 7 анги, 14 бүлэг төрөл, 61 төрөлд хуваажээ. Мөн ашиглалтын улмаас талхлагдсан 25 үндсэн төрлийн өөрчлөлтийг 32 хувилбараар ангилж байршлыг нь зурагт харуулав. \ зураг 4\ .

Уулын бэлчээр- У: Уулын бэлчээр судалгаанд хамрагдсан нийт газрын 41,9 % буюу 22033 га талбайг хамрах ба нугархаг хээр, хуурай хээрийн ургамалжилттай байна. Нутгийн хойд болон өмнөд хэсгээр орших д.т.д. 1200-1700 м өргөгдсөн дундаж өндөр болон нам уулсын орой, энгэр хажуугаар уулын нугархаг хээрийн бэлчээр тархах ба ургамалжилтын хувьд хялгана-алаг өвст, зүр өвс-алаг өвст, биелэг өвс-алаг өвст, ботууль-улалж--алаг өвст төрөл зонхилно. Харин уулын энгэрээр нь ботууль-алаг өвст, сөөг бүхий алаг өвс-үетэнт, жижиг

дэгнүүлт үетэн-алаг өвст төрлүүд голлоно тархжээ. Ургамалжилтын ийм байдал Шувуутын даваа \1629 м\, Уртын нуруу , Даристын нуруу \1665 м\, Дэл уул \1310 м\ зэрэг уулсын орчимд ажиглагдана.

Хялгана-алаг өвст төрөл нь харьцангуй хуурайвтар газраар нилээд түгээмэл тархах бөгөөд ургамлын ерөнхий бүрхэц 60-65 %, крыловын хялгана 30-35%-ийн бүрхэцтэй ургах ба үетэнээс дааган сүүл, улаан ботууль, туужууны биелэг оролцож алаг өвснөөс хоёр ишт бэриш, түмэн навчит ортууз, яргуй, сибирийн дурсгал цэцэг зэрэг алаг өвс 15-20 %-ийн бүрхэцтэйгээр тус тус ургана. Ургамлын дундаж өндөр 15-20см, зуны дундаж ургац 5.7ц\га, 100кг тэжээлд нь 52.9 тэжээлийн нэгж агуулагдана. Энэ төрөл нь улирлын чанартай бэлчээрт ашиглагдана.

Зүр өвс-алаг өвст бэлчээр нь чулуурхаг бэсрэг уулс тэдгээрийн хажуугаар тохиолдоно. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд сибирийн зүр өвс, шивээт хялгана, дааган сүүл, улаан ботууль, туужууны биелэг алаг өвснөөс хоёр ишт бэриш, марал навчит гичгэнэ, яргуй, хонгор зул зэрэг ургамал ургана. Ургамлын дундаж өндөр 25-30 см, зуны дундаж ургац 5.0ц\га, 100кг тэжээлд нь 49.5 тэжээлийн нэгж агуулагдана. Энэ ангийн бэлчээр нь бүх төрлийн малд тохиромжтой боловч өвлийн улиралд цас хунгарлаж голдуу хүйтэн салхитай байх тул хүрч ашиглахад бэрхшээлтэй байдаг.

Ботууль-алаг өвс-үетэн-улалжит төрөл уулын нилээд чийгтэй, нугархаг хэсгээр хааяа тохиолдож байсан бөгөөд хялгана-алаг өвст бэлчээрийг бодвол улалжийн оролцоо ихэсч ирсэн байв. Энд ургамлан нөмрөгийн ерөнхий бүрхэц 70-75%, ботууль 20-25% хүртэл бүрхэцтэйгээр зонхилж хөх яргуй, хэвлэг гиш, түмэн навчит ортууз, хоёр ишт бэриш, өрөмтүүл, бэр цэцэг, уул өвс, хурдан цагаан, туужууны биелэг, шивээт хялгана, шеллийн бутнуур, өлөнгө ургах бөгөөд зогдор улалж зарим хэсэгт толболон үзэгдэнэ. Ургамлын дундаж өндөр 20-25 см, зуны дундаж ургац 6.0 ц\га байгаа нь өмнөх судалгааны \1974\ үеэс төдийлэн буураагүй байна. Өвсний шимт чанараар дунд зэрэг үхэр адуунд тохиромжтой бэлчээр юм.

Дээрхээс гадна хялгана, зүр өвс ээлжлэн зонхилж хялгана-зүр өвст, зүр өвс-хялганат төрлүүдийг үүсгэнэ.

Эдгээр уулын бэлчээр нь улирлын чанартай бэлчээрт ашиглагдана.

Нам бэсрэг уулын хоорондох нуга хөндийн бэлчээр-УХ нь нутаг дэвсгэрийн 5,7 %д эзлэж д.т.д. 900-1100м орчим өргөгдсөн дундаж ба нам уулсын хоорондох нарийн ам хөндий, судгаар тархжээ. Ургамалжилтын байдлаар авч үзвэл өлөнгө-алаг өвст \УХ-II-1-3\, зүр өвс-хялганат\УХ-II-3-5\, үетэн-улалж--алаг өвст \УХ-II-2-1\, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст хээржсэн нуга \УХ-II-2-4\, ботууль-алаг өвст хээржсэн нуга \УХ-II-2-5\, улалж-үетэнт \УХ-II-4-1\ бүлгэмдэл зонхилно. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг нугын дурваалаг, нугын биелэг, шеллийн бутнуур, соргүй согоовор, хиаглай түнх, монгол туйпланцар, улаан толгойт, сөд өвс, марал навчит гичгэнэ, галуун гичгэнэ, коржинскийн улалж голлон бүрдүүлнэ. Ургамлын ерөнхий бүрхэц 70-80 %, дундаж өндөр 28-40 см, зуны дундаж ургац нь төрлөөсөө шалтгаалан 9.3-12.3ц\га, шимт чанар нь 39.8-50.7 тэжээлийн нэгж байдаг. Ашиглалтанд харьцангуй таатай учир аймаг сумын төвийн ойр орчим, Өвөр булаг, Хөндлөнгийн хөндий, Булагийн хөндий орчмын бэлчээр талхлагджээ. Их талхлагдсан *бэлчээрийн* ургамлын ерөнхий бүрхэц 40-45%, ургамлын зүйлийн тоо 4-6, зуны дундаж ургац 5,3 ц\га байгаа нь талхлагдалд ороогүй хувилбараас 25-30%-иар буурсныг гэрчилж байна./Наранбулаг орчимд/ .

Тал хээрийн бэлчээр- X: Тал хээрийн бэлчээр нь нийт эдэлбэр газрын 48,4 % буюу 25563 га талбайг эзлэнэ. Үүнд Жаргалантын хөндий, Ар хөндий, Булагийн хөндий, Хөшөөтийн хөндий, Дулаан хөндий, Хөөврийн хөндий, Өвөр булагийн хөндий, Ар булагийн хөндий багтах ба ургамалжилтийн хувьд ботууль-жигжиг дэгнүүлт үетэн-алаг өвст, хялгана-алаг өвст, хялгана биелэгт болон түүний талхлагдсан хувилбарууд болох ботууль-жигжиг дэгнүүлт үетэн-агьт, агь-ботуульт, хялгана-агьт, агь-хялганат, хялгана-агь-биелэгт, агь-хялгана-биелэгт төрлүүд зонхилохын дээр хиаг-агь-алаг өвст, агь-хиагт, хялгана-үетэн-агьт, хялгана-зүр өвст төрлүүд ч тохиолдоно.

Хялгана-алаг өвст /X-I-2-9/ төрөл нь энэ ангид хамгийн өргөн тархалттай бөгөөд намхан толгодын ар арай чийглэг газраар тохиолдоно. Энэхүү бүлгэмдэлийн ургамлын ерөнхий бүрхэц 45-50%, ургамлын зүйлийн тоо 4-6, ургамлын өндөр 12-15 см байх ба энд крыловын хялгана 15-20 % зонхилж ишгүй навтуул, хөх яргуй, цайвар шар цагаан түрүү, бор цоохор цахилдаг, шүдлэг сонгино, хоёр ишт бэриш зэрэг элдэв өвс ургахын зэрэгцээ үетэнээс дагуурын биелэг өвс, туяхан дааган сүүл, хиаглай түнх, саман ерхөг оролцон ургана. Шимт чанар сайтай 100 кг тэжээлд нь 48.6 тэжээлийн нэгж агуулагдана. Ямар ч улиралд бүх төрлийн малд тохиромжтой. Энэ төрөл нь Жаргалант сумын төвийн хойд талын хөндий Хангалын голын 2 хөвөөгөөр түгээмэл тохиолдох ба жилийн 4 улиралд сэлгээгүй ашигласанаас талхлагдаж *хялгана-агьт, агь-хялганат* төрлүүд түгээмэл тохиолдох болжээ.. Талхлагдсан эдгээр төрлүүдэд ургамлын ерөнхий бүрхэц сийрэгжиж 35-40%, зүйлийн 3-4 болсон байна. Мөн зүйлийн бүрэлдэхүүнд агь өндөр бүрхэцтэйгээр түрэн орж иржээ.

Хялгана-жигжиг дэгнүүлт үетэнт /X-I-2-3/. Энэ төрлийн бэлчээрийн үндсэн хэвшинжийг бүрдүүлэгч ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд үетнээс: крыловын хялгана, туужууны биелэг, дааган сүүл, ленийн ботууль, дэрвээн хазаар өвс, алаг өвснөөс: буурал гандбадраа, нумраа хунчир, хянгар царгас, ишгүй гичгэнэ, хавчиг гичгэнэ, жинхэнэ өрөмтүүл, арзгар согсоолж, алаг цэцэгт башир, фишерийн бэр цэцэг зэрэг ургамлууд оролцоно. Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 50-55%, ургамлын өндөр 12-20 см. Жилийн турш адуу, үхэр, хонь, ямаа бэлчээрлүүлэхэд тохиромжтой. Үүний өөрчлөлт орсон хувилбарт зонхилох ургамал нь үетнээс: ширэг улалж, нангиад хиаг, крыловын хялгана, саман ерхөг, алаг өвснөөс: агь, ямаан шарилж, арзгар согсоолж, ишгүй гичгэнэ зэрэг ургамлууд ургана. Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 35-40%, ургамлын өндөр 3-10 см байна. Нэг га-д жилд дунджаар 3.5 цн малд идэгдэх хуурай ургацтай байгаа нь урд судалгаатай харьцуулахад 20-25 % буурсан ба 100 кг тэжээлд 32.8 тэжээлийн нэгж агуулагдана.

Тал хээрийн бэлчээр нь жилийн аль ч улиралд ашиглахад тохиромжтой боловч хотжилт, үйлдвэржилт, газар тариалангийн үйлвэрлэл нөлөөгөөр хязгаарлагдаж сэлгээгүй ашиглах болсон нь бэлчээр талхлагдах шалтгаан болжээ.

Нугын бэлчээр-Н:

Голын хөндий, нуурын захын аллювийн нугын хээржсэн болон аллювийн нуга-намгийн хөрстэй газруудаар тархах нуга, нам хотсын бэлчээр нь нийт нутгийн 4,0 % буюу 2158 га талбайг эзлэнэ.

Намгархаг нугын бэлчээр Хангал, Чингэлийн голын чийглэг татамын нугаар тааралдах ба ургамалжилтын хувьд *Улалж-алаг өвст /Н-I-2-4/* ба *Улалж-үетэнт*

/Н-1-2-2/ бэлчээр давамгайлна. Бүрдүүлэгч ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд улалжнаас: дэгнүүлт улалж, цэх түрүүт улалж, шмидтийн улалж, үетнээс: нугын биелэг, марцны гол өвс, мөлхөө хиаг, монгол улаан толгойт, дорнодын тор өвс, ахар сорт арвай, алаг өвснөөс: намгийн дүндэггарав, намгийн холтсон цэцэг, дэрэвгэр жиргэрүү, хянгар царгас, их таван салаа, энгийн буржгар, галуун гичгэнэ, эмийн багваахай, ишгүй азаргана зэрэг ургамлууд оролцохоос гадна бүрхэц арвин 65-70% байна. Харин талхлагдсан хувилбарт нь шарилжны оролцоо ихсэж 15-20 % -иар дэд зонхилогч болсон байна.

Голын хөндийн дэнжирхэг хэрсгээр тархсан аллювийн нугын болон аллювийн хээржсэн, үелэсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татмын нугын 1172 га талбайд хиаг-алаг өвст, үетэн-улалж-алаг өвст, шарилж-үетэн-улалжит, улаан толгой-шарилжит, улалж-үетэн-шарилжит тархах ба өнөөгийн байдлаар бараг нийтдээ талхлагджээ.

Бэлчээрийн төрх байдлаас харвал нийт газрын 32725 га нь өвслөг ургамалтай, 5744 га чулуутай, 10184 га нь сөөгтэй, 2864 га нь довонтой бөгөөд 26478 га бэлчээр талхлагдсан нь нийт судалгаанд хамрагдсан газрын 50,1%-ийг эзлэж байна. Талхлагдсан бэлчээрийн 33,5% нь дунд, 16,6% нь их талхлагдсан нь талхлагдал ерөнхийдөө эрчимтэй байгааг нотолж байна.

Орхон аймаг нь биологийн төрөл зүйл ихтэй Хангайн нуруунд байрласан учир нэн ховор, ховор ургамал нилээд элбэгтэй бөгөөд ургамлын судалгаанаас харвал дундаж өндөр уулын бүслүүрт 5, уулын нугад 5, тал хээрт 4, голын татамд 6 зүйл ургамал тус тус тааралджээ. Нэн ховор ургамлын жагсаалтад орсон 133 ургамлаас 10, Монголын улаан номонд орсон 100 гаруй зүйл ургамлын 20 зүйл ургамал тус аймгийн 21 цэгт тэмдэглэгдсэн байна. /Хүснэгт 5/

Хүснэгт 5. Орхон аймгийн нутагт тархсан нэн ховор, ховор ургамлын жагсаалт

Д/д	Монгол нэр	Латин нэр	Тархалт	Тайлбар
1	Буржгар сараана	<i>Lilium martagon</i> L.	Шувуутын голын хөндий	Сарааны овог, ховор
2	Хоёр навчит Зуншил цэцэг	<i>Majanthemum bilolium</i> (L.) Schmidt	Шувуутын ууланд	Сарааны овог, ховор
3	Эмийн Мухар цагаан	<i>Polygonatum officinale</i> All.	Дуулгат уул	Сарааны овог,
4	Бар цоохор цахилдаг	<i>figrida</i> Bge.	Бэрхийн овооны зүүн бэлээр	Цахилдагийн овог,
5	Мөлхөө Өн цэцэг	<i>Goodyera repens</i> (L.) R. Br.	Шувуут голын нугад	Цахирамын овог,
6	Хоёр навчит Шөнийн нил	<i>Planthere xifolis</i> (L.) C. Rich	Хангалын голын нугад	Цахирамын овог,
7	Сэрхэн Хөхөө цэцэг	<i>Gymnadenia conopsea</i> (L.) R. Br.	Хангалын голын нугад	Цахирамын овог,
8	Марцны Цахирам	<i>Orchis salina</i> Turcz	Хангалын голын нугад	Цахирамын овог,
9	Ацан Ажигана	<i>Stellaria dichotoma</i> L.	Согоот голын нугад	Баширын овог,
10	Ахар дэлбээт Шөнөжмөл цэцэг	<i>Melandrium brachipetalum</i> (Harnem) Fenzl.	Согоот голын нугад	Баширын овог,
11	Жавхаалаг Башир	<i>Diathus superbus</i> L.	Булгийн амын эхэнд	Баширын овог,

12	Шар яргуй	<i>p. flavescens</i> (Zuce) Juz.	Хангалын голын урд хөвөөгөөр тал хээрт	Холтсон цэцгийн овог,
13	Дорнодын гүзээлзгэнэ	<i>Fragaria oratalis</i> A. Los.	Нарангийн уул	Тэргүүлэгч цэцэгтэн,
14	Ягаан хүцэнгэ	<i>Onobrychis dahurica</i> (Laxm.) Schindl.	Дуулганы хөндий	Буурцагтны овог,
15	Сибирийн Зүрхэн цэцэг	<i>Polygla sibirica</i> L.	Пинт уул	Зүрхэн цэцгийн овог,
16	Үст Зэллэг цэцэг	<i>Calystegia pellita</i> (Ldb.)G. don.	Хавчигийн голын нугад	Сэдэргэний овог,
17	Царсан Гүүн хөх	<i>Scutellaria scordiifolia</i> Benth.	Даристын голын нугад	Уруул цэцэгтний овог,
18	Нангиад Садагнава	<i>Lophanthus chinensis</i> Benth.	Даристын голын нугад	Уруул цэцэгтний овог,
19	Азийн Төлөгч өвс	<i>Achillea asiatica</i> Serg.	Дарьстын овооны орчим	Нийлмэл цэцэгтний овог,
20	Сибирийн Заяахай	<i>Ligularia sibirica</i>	Хонгот амын нугад	Нийлмэл цэцэгтний овог,

1.2.6. Ан, амьтан

Монгол орны нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан амьтны тоо, толгой, байршил, экологи, биологийн талаар судалгааны нилээд хийгдсэн боловч эдгээр судалгаанд Орхон аймгийн нутаг дэвсгэр хамрагдаагүй байна.

Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан тус аймгийн нутаг дэвсгэрт нутагшсан ан амьтны нөөц хомс .

1.2.7. Ойн сан

Орхон аймгийн ойн сан нь Монгол орны ойн ургамалжилтын бүсчлэлээр Хангайн уулархаг мужийн зүүн хойд Хангайн хошуунд багтана. 2001 онд хийгдсэн ойн зохион байгуулалтын судалгааны материалаас үзэхэд 20968 га ойн сантай үүний 93.1 хувь буюу 19529 га нь цэвэр ой, 6.9 хувь буюу 1439 га уулын энгэр, голын хөндий орчмын цагаан газар хамрагджээ. /Хүснэгт 6, Зураг 5/

Ойн 17.2 хувь буюу 3601 га нь Баян-Өндөр сумын нутагт өөрөөр хэлбэл Эрдэнэт хотын ногоон бүсэд, 82.8 хувь буюу 17367 га нь Жаргалант сумын нутагт тархсан байдаг.

Хүснэгт 6. Ойн сангийн газрын төрөл

Ойн талбай									Ойн талбайн дүн	Ойн биш талбай	Бүх талбай
Ойгоор бүрхэгдсэн		Ойгоор бүрхэгдээгүй									
Байгалийн ой	Сөөг	Шатсан талбай	Тармаг ой	Огтолсон талбай	Хортон идэгдсэн ой	Ойжих талбай	Ойжуулсан газар	Дүн	Цагаан энгэр		
Баян-Өндөр сум											
2236			673	169	127	47	623	1279	3515	86	3601
10.7%			3.2%	0.8%	0.6%	0.2%	1.3%	6.1%	16.8%	0.4%	17.2%
Жаргалант сум											

12994		170	21.48	28	147	434	93	3020	16014	1353	173 67
62.0%		0.8%	10.2 %	0.1%	0.7%	2.1%	0.5%	14.4 %	76.4%	6.4%	82.8 %
Орхон аймгийн ойн сангийн талбай											
15230		170	2821	197	274	481	356	4299	19529	1439	209 68
71.6%		0.8%	13.4 %	0.9%	1.3%	2.3%	1.7%	20.5 %	93.1%	6.9%	100 %

Хүснэгт 7. Ойн модны бүтэц ба нөөц

Ойн төрөл	Ойн талбай /га/	Ойн нөөц /мян.м ³ /
Баян-Өндөр сум		
Шинэсэн ой	1907	232.1
Хусан ой	329	24.2
Сумын дүн	2236	256.3
Жаргалант сум		
Шинэс	11850	1641.3
Хус	1144	75.1
Сумын дүн	12994	1716.4
Аймгийн дүн		
Шинэс	13757	1873.4
Хус	1473	99.3
Нийт дүн	15230	19727.0

Ойн сангийн талбайн нийт нөөцийн 2034.7 мян/м³ буюу 90.0 хувийг ургаа ой, 200.0 мян/м³ буюу 8.8 хувийг хатсан мод, 26.3 мян/м³ буюу 1.2 хувийг унасан мод тус тус эзэлж байна./хүснэгт 7/

Ойн 1 га-гийн дундаж нөөц нь 130 м³ боловч модны төрлөөс хамааран харилцан адилгүй ба шилмүүст модны насжилт 128 жил, навчит модных 50 жил. Харин нийт нөөцийн 48.1 хувь буюу 940.3 мян.м³ нь насны 8-р ангид хамрах ба модны төрөл тус бүрээр нь үзвэл шинэс модны хамгийн их нөөц нь 7-р ангиас дээш, хусных 5-6-р ангиудад хамрагдана.

1.2.8. Эрдэнэт хотын экологийн өнөөгийн нөхцөл байдал.

Тус аймагт орчны бохирдлыг бий болгох томоохон хүчин зүйлсийн тоонд уурхай, үйлдвэр, гэр хороолол бөгөөд хөрс ус агаарын бохирдлын түвшин харьцангуй их, цаашид ч нэмэгдэх хандлагатай байна. /Зураг 6/

Агаарын бохирдол:

Орхон аймгийн төв Эрдэнэт хот нь хүнд үйлдвэр түшиглэн байгуулагдсан Монгол Улсын цөөн хэдэн хотын нэг юм. Үйлдвэр хөгжиж, хот тэлж, хүн ам, техникийн төвлөрөл ихсэж, цахилгаан, дулааны хэрэглээ нэмэгдэхийн хирээр агаарын чанар ихээхэн муудаж байгаа ба түүний бохирдлын түвшин нь

бохирдуулагч эх үүсвэрийн байршил, тэдгээрийн тархах хүрээ, хаягдлын найрлага, газар зүйн нөхцлөөс шалтгаалан харилцан адилгүй байна.

Агаар бохирдуулагч гол эх үүсвэр нь Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын сан, мөн тэсэлгээнээс үүссэн тоосонцорууд юм. Үйлдвэрийн хаягдал цагаан тоосонд төмөр 39.9 мг/г, титан 6.3г/кг, сурьма 1026.7 мг/г, зэс 2157.9мг/кг, молибден 17.34 мг/кг, калий 27.2мг/кг агуулагддагаас зэс, цайр, мөнгө нилээд агуудагдсан байдаг нь хавар, намрын улирлын хуурайшилт, салхины хурд нэмэгдэх үед их хэмжээгээр хийсч газарт буухаас гадна жижиг тоосонцорууд нь гидродинамик үйлчлэлээр үүл үүсгэн агаарт удаан хугацааны туршид тогтдог. Үүнээс болж тус аймгийн хөдөө аж ахуйн гол нутгууд болох Зуны гол, Хангалын голын хөндий, Төмөр замын өртөө, Бумбат орчимд бохирдлын хэмжээ ихсэж, хүн малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Лабораторийн хэмжилтийн дүнгээс харвал тоосны хэмжээ салхины чиглэлийн дагуу Төмөр замын өртөө орчимд 732-2963 мг/кг буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс 19.8 дахин их, Жаргалант сумын төв орчимд 329 мг/кг буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс 2.2 дахин өндөр гарчээ.

Агаарын бохирдлын өөр нэг томоохон эх үүсвэр нь гэр хорооллын дутуу шаталттай зуух, уурын зуухнууд юм. Тус аймагт нийт . . . өрх айл ердийн галлагаатай гэрт амьдарч өвлийн улиралд нэг өрх 5-7 тн нүүрс шатааж байна. Гэрийн зуух нь технологийн хувьд хоцрогдсон хүний амьжиргааны орон зайд их хэмжээний дутуу шаталт үүсгэдэг нь агаарын орчинд муугаар нөлөөлдөг. Үүнийг багасгах зорилгоор бүрэн шаталттай, түлшний хэмнэлттэй шинэ загварын ТТ-03 маркийн гэрийн зуухыг туршин Дэлхийн банкны Гэрийн зуух төслийн багтай нилээд хамтран ажиллаж эхлэсэн боловч үр дүн хараахан гарч амжаагүй байна.

Мөн хотын доторхи автотээврийн хэрэгслийн тоо нэмэгдснээр агаар бохирдож байна. БОШТ лабораторитой хамтран Итали улсад үйлдвэрлэгдсэн автомашинаас ялгарсан хорт хийг хэмждэг багажаар 2003-03-12-ны өдөр хотын төвд төрөл бүрийн маркийн А-76 бензин зарцуулдаг G4; 11-р сарын 24-нд 32 автомашинд нүүрсхүчлийн хий /CO/, угаар /CO/ нүүрстөрөгч /HC/ зэрэг агаар бохирдуулагч бодисыг хэмжин уг хэмжилтээр нийт хамрагдсан машины 60 хувь нь зөвшөөрөгдөх агууламжаас 3-4 дахин CO-2, 14 хувь нь HC-ыг 1 дахин их хаяж агаар бохирдуулж байгаа нь тогтоогджээ.

Усны бохирдол:


Гадаргын болон гүний усны бохирдол нь үйлдвэрийн үйл ажиллагаатай ихээхэн холбоотой байна. Үйлдвэрийн технологийн дагуу Зуны голын голидролыг боож хаягдлын аж ахуйн сан байгуулсан бөгөөд энд хоногт дундажаар 50 тн эрдэс зуурмаг байдлаар ирж хөрсний гүн рүү нэвчихээс гадна сангаас доош голын голидролыг даган урсаж Эрдэнэтийн голд цутган Хангалын голд нийлж байна. Хангалын гол нь Жаргалант сумын бэлчээрийн усан хангамжийн гол эх үүсвэр бөгөөд үүнээс уусан мал чацга алдаж, элэг дэлүү, ходоодонд цоохор толбо маягийн шохойжилт үүссэн байдгаас гадна зарим малаас зангидсан гарын дайтай хавдар гарсан тохиолдол ч ажиглагджээ. Ер нь энэ орчмын бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн эрс цөөрч мал чацга алдах байдал элбэг ажиглагддаг байна.

Мөн хотын үерийн сувгаар хаягддаг үйлдвэрийн бохир ус, цэвэрлэх байгууламжийн хаягдал ус, ДЦС-ын үнс баригчаас гарсан ус зэрэг нь бохирдуулагч эх үүсвэрүүд болно.

Тус аймгийн үйлдвэрийн районд хийгдсэн Байгаль орчны шинжилгээний төв лаборатори болон Эрдэнэт харуулын олон жилийн шинжилгээний дүнгээс үзэхэд Сэлэнгэ мөрөн, Хялганат тосгоны орчим, Орхон ба Хангал голын цутгалаас дээш, Чингэл гол бүхэлдээ шим бохирдлоос бусад үзүүлэлтээр гадаргын усны чанарын стандартад нийцэж байхад үйлдвэрийн дээд, доод гүүр, Хангал өртөө орчмоос авсан усны сорьцонд хүнд металлууд, эрдэс, азот, фосфор болон хялбар исэлддэг органик бодисны хэмжээ усны чанарын стандартаас давсан үзүүлэлттэй байгаа нь хотжилт, үйлдвэржилтийн нөлөөлөөс болжээ. Харин энэ бохирдлын хэмжээ ус арвинтай үед харьцангуй багасдаг боловч усны гачиг үед ялангуяа хаврын улиралд эрс нэмэгддэг байна.

Хүснэгт 8. Голын ус хүнд элементээр бохирдсон байдал

Д/д	Сорьц авах цэг	Fe мг/л		Cu мг/л		Mo мг/л	
		2002 он	2003 он	2002 он	2003 он	2002 он	2003 он
1	Үйлдвэрийн дээд гүүр	0.12	0.05				
2	Үйлдвэрийн доод гүүр	0.23	0.06	0.013	0.010	0.152	0.142
3	Хангал өртөө	0.06	0.05	0.005	0.005	0.095	0.102



Диаграмм 3. Гадаргын усны бохирдлын хэмжээ /мг/л/.

Хүснэгт 9. Усны эрдэсжилтийн байдал

Д/д	Сорьц авах цэг	Эрдэсжилтийн дундаж агууламж мг/л		Эрдэсжилтийн хамгийн их агууламж мг/л	
		2002 он	2003 он	2002 он	2003 он
1	Үйлдвэрийн дээд гүүр	958.7	884.9	1203.6	1133.6
2	Үйлдвэрийн доод гүүр	794.3	739.3	1088.9	1758.0
3	Хангал өртөө	790.1	654.4	959.0	745.3

Хөрсний бохирдол:

Судалгаанаас үзвэл тус аймгийн нутаг дэвсгэрийн хөрсөн бүрхэвч механик үйлчлэл болон биологийн болон химийн гаралтай эх үүсвэрүүдээс нилээд бохирдож байна. Аймгийн хэмжээнд 0.38 мян.га хөрс атаржиж, 0.119 мян.га үйлдвэр, 5.429 мян.га уурхай, карьер, салаа зам, хог хаягдлын цэгүүдийн үйл ажиллагаанаас болж физик элэгдэлд оржээ.

Мөн үйлдвэрийн хаягдлын сан, хотын цэвэрлэх байгууламжаас гарсан эрдэс болон органик бодис агуулсан уусмал, түүнчлэн өвлийн цагт агаарт дэгдсэн дутуу шаталтын ислүүд цасны хамт бууж хөрсөнд шингэхдээ тодорхой хэмжээгээр хуримтлагдан химийн бохирдлыг үүсгэнэ. Орхон аймгийн БОШЛ нь үйлдвэрлэлийн районд болон гэрийн хороолол, бэлчээрийн талбай зэрэг төлөөлөх, харьцуулах, чадвартай хэсгээс жилд 1-2 удаа хөрсний дээж сорьц аван шинжилгээ хийж бохирдлын хэмжээг тодорхойлж төлөв байдлыг тогтоодог байна.

Хүснэгт 10. Хөрсний бохирдол

Цэг	PH	NO ₃ мг/л	SO ₄ мг/л	P ₂ O ₅ мг/л	NH ₄ мг/л
Гэр хороолол	6.27	6.72	310.6	199.5	83.8
Бэлчээр	6.45	6.08	213.2	200.0	17.0
Үйлдвэр	7.00	23.12	114.7	237.0	499.0
Говил	7.81	14.4	135.5	87.0	35.5

Хүснэгтээс харвал хөрсний орчин рН хотын гэр хороолол болон бэлчээрийн газарт сул хүчиллэг байхад үйлдвэрийн районд саармаг /7.0/, Говилын хэсэгт шүлтлэг /7.8 / болсноос хотын салхин доод талд элдэв төрлийн химийн элементийн хуримтлал нэмэгдэж байна. Ялангуяа хотын зүүн хэсэгт буюу үйлдвэрийн дүүрэгт сульфатын агууламж харьцангуй их байгаа нь үйлдвэрээс гарч буй хаягдалтай шууд холбоотой юм.

Хөрсний бохирдлыг үзүүлэхийн тулд өвлийн улиралд цасны найрлагыг тодорхойлсныг Улаанбаатар хотын ижил төрлийн шинжилгээний дүнтэй харьцуулан үзүүлэхэд доорхи байдал гарч байна.

Хүснэгт 11. Цасанд буусан химийн зарим элементүүдийн агууламж /мг/г/

	PH	EC	CL	NO ₃	SO ₄	NH ₄
Эрдэнэт	6.65	64.2	3.9	0.131	27.9	0.819
Улаанбаатар	7.78	300	44.6	3.6	123.8	16.2

Хүснэгтээс харахад Эрдэнэт хотын цасны усны РН-ын орчин саармаг бөгөөд эрдэсжил болон ихэнх ионуудын агууламж 5-13 дахин бага байгаа нь /өвлийн улиралд дулааны станцаас өөр бохирдуулагч байхгүй болдог/ цасан бүрхэвчийн үр дүнд хөрс бохирдуулагч эх үүсвэрийн тоо буурдагтай холбоотой юм.

Хөрсний бохирдлыг үүсгэж байгаа өөр нэг эх үүсвэр нь хатуу хог хаягдал бөгөөд түүнийг зайлуулах, устгах албан ёсоор зөвшөөрөгдсөн цэг Баян - Өндөр, Жаргаланд суманд тус бүр 1 байгаа бөгөөд нийт 29 га газрыг эзэлдэг.

Гэвч хүн амын төвлөрлөөс гэр хороолол тэлж, хогийг зориулалтын бус цэг, гуу жалга, гудамж талбайд эмх замбараагүй хаяж байгаа нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихэсч байна. Хог хаягдлын эх үүсвэрийг төрлөөр нь авч үзвэл ахуйн, аж ахуйн нэгж байгууллагын, ахуй үйлчилгээний, үйлдвэрийн, барилга байгууламжийн, гудамж талбайн цэвэрлэгээний хог хаягдал байгаа бөгөөд жилд дунджаар 53,4 мянган шоо метр хог хаягдлыг устгаж байна. Нийт хог хаягдлын 60 орчим хувийг үйлдвэрийн болон барилгын хог хаягдал эзэлж, ахуйн хог хаягдлаас цаас, шил, мод, яс, хоол хүнсний үлдэгдэл нь 5-10 мянган шоо метр буюу 9 -18 хувийг эзэлж байна.

Хог хаягдлын цэгийн тоо, байршил, талбайн хэмжээ, хог хаягдлын шинж байдал, түүнийг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, эргүүлэн ашиглах, дахин боловсруулах арга хэмжээ болон устгал, зайлуулалтын байдал туйлын хангалтгүй байгаагаас цаас, нийлэг уут, картон цаас, нийлэг материал нь салхи шуурганд хийсэж орчныг бохирдуулж хогийн талбайг тэлэх байдал бий болж байна.

Хоёр. Аймгийн газар ашиглалтын болон газрын харилцааны өнөөгийн байдал


2.1 Газрын нэгдмэл сан, түүний ашиглалт

Газрын нэгдмэл сангийн 2003 оны тайлангаас үзэхэд аймгийн нийт нутаг дэвсгэр 84,4 мян.га бөгөөд үүний 46.4 мян.га буюу 55.1 хувийг хөдөө аж ахуйн газар, 21.0 мян.га буюу 24.8 хувийг хот тосгон бусад суурингийн газар, 955.4 га буюу 1.1 хувийг зам, шугам сүлжээний газар, 14.0 мян.га буюу 16.6 хувийг ойн сан бүхий газар, 201.5 га буюу 0.2 хувийг усан бүхий газар, 1739.0 га буюу 2.2 хувийг тусгай хэрэгцээний газар тус тус эзэлж байна. /хүснэгт 12/

Хүснэгт 12.Орхон аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц

№	Газрын үндсэн ангилал	Талбай	
		Мян.га	хувь
1	Хөдөө аж ахуйн газар	46.4	55.1
2	Хот тосгон, бусад суурины газар	21.0	24.8
3	Зам, шугам сүлжээний газар	0.9	1.1
4	Ойн сан бүхий газар	14.0	16.6
5	Усны сан бүхий газар	0.2	0.2
6	Тусгай хэрэгцээний газар	1.7	2.2
	БҮГД	84.4	100

Диagramм 4



Тайлбар: 1-ХАА-н газар, 2-Хот суурин, 3-Зам шугам сүлжээ,
4-Ойн сан, 5-Усан сан, 6-Тусгай хэрэгцээ


Нийгмийн хэрэгцээ шаардлага, эдийн засгийн хөгжлийг даган газар ашиглалтын хэлбэр зориулалт тодорхой хэмжээнд өөрчлөгдөж байдаг бөгөөд үүнийг сүүлийн 2 жилийн байдлаар харуулав. /Хүснэгт 13 /

Хүснэгт 13. Орхон аймгийн нэгдмэл сангийн өөрчлөлт /га/

Д/д	Газрын ангилал	2002	2003	Зөрүү+.-
1	Нийт нутгийн хэмжээ	84400	84400	-
	ХАА-н газар бүгд	46481	46481	-
	Үүнээс:			
	Бэлчээр	39748.7	39748.7	-
	Хадлан	1400	1400	-
	Тариалан	5319.3	4936.3	-383.0
	Атаржсан газар	597	383	-214.0
	Жимс, жимсгэнэ	3	3	-
	Хот тосгон бусад суурин газар	21140.1	21001.1	-
	Үүнээс:			
	Барилгажсан талбай	583.7	585.1	+1.4
	Гэр хороолол	625.4	894.4	+269.0
	Нийтийн эзэмшил	14328.3	13972.9	+355.4
	Гудамж талбай	5.7	46.8	+41.1
	Үйлдвэрлэлийн зориулалттай	119.6	119.6	-
	Уурхайн зориулалттай нийт	5429	5429	-
	Үүнээс: Нөөцөд			
	ЗШ Сүлжээ			
	Зам шугам сүлжээний газар	955.4	955.4	-

Үүнээс:	Эрчим хүчний	5	356.0	+351.0
	Холбооны	0.8	50.5	+49.7
	Авто зам	147	147	-
	Төмөр зам	300.5	300.5	-
Ойн сан		15602	14002	-1600.0
Үүнээс:	Ой	15596	13996	-1600.0
	Мод үржүүлэг	6	6	-
Усан сан		221.5	221.5	-
Үүнээс:	Гол	201.5	201.5	-
	Нуур			
Тусгай хэрэгцээний газар		2039.5	1739	300.5
Үүнээс:	Тусгай хамгаалалтай	1600	1600	-
	Батлан хамгаалах	136.8	136.8	-
	Боловсрол, ШУ туршилт	0.4	0.4	-

Диаграмм 5



Тайлбар: 1-Тариалан, 2-атаржсан газар, 3-барилгажсан газар, 4-гэр хороолол, 5- нийтийн эзэмшил, 6-гудамж талбай, 7-эрчим хүчний шугам, 8-холбооны шугам, 9-ой, 10- тусгай хэрэгцээ

Газар ашиглалтын байдал болон өөрчлөлтийг нэгдмэл сангийн ангилал бүрээр гаргавал:

ХАА-н газар: 46481.0 га. Үүнээс бэлчээр 39748.7 га хадлангийн талбай 1400 га, тариалангийн газар 4936.3 га, атаршсан газар 383.0 га, ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар 13 га тус тус байгаа бөгөөд өнгөрсөн онд атаршсан газар 597.0 га байснаас 2 аж ахуйн нэгж байгууллагад 214 га газрыг эзэмшүүлж тариалангийн газарт шилжүүлсэн.

Хот суурин газар: Хот тосгоны эдэлбэр газар нийт 21001.0 га бөгөөд барилга байгууламжийн дэвсгэр газар 585.1 га, нийтийн эдэлбэрийн газар 13972.9 га, үйлдвэрийн газар 119.6 га, уурхайн эдэлбэр 5429.0га, гэр хорооллын газар 894.4 га тус тус байна. Монгол улсын иргэнд газар өмчлөх хуулийн дагуу иргэдэд шинээр газар олгож нийтийн эдэлбэрийн газраас гэр хорооллын газарт 670 га газар, улсыг батлан хамгаалах аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газрын 80 гаруй хувь нь буудлагын болон хээрийн сургалтын талбайн зориулалтаар, 3,57 га газрыг барилга байгууламжийн дэвсгэрт тус тус шилжүүлжээ.

Зам шугам сүлжээний газар: Зам, шугам сүлжээний газар бүгд 955 га бөгөөд авто замын газар 147,0 га төмөр замын газар 300,5 га, агаарын тээврийн газар 90,4 га, шугам сүлжээний газар 417,5 га байгаа нь өөрчлөлт гараагүй болно.

Усны сан бүхий газар: Усан сан бүхий газар 221,5га гол мөрний эзлэх газар 201,5 га, горхи булаг шандын эзлэх газар 20,0 га байгаа нь онд өөрчлөлт ороогүй болно.

Ойн сан бүхий газар: Ойн сан бүхий газар 14002.0 га, үүнээс 13976 га ой, 6 га нь мод үржүүлгийн газар байна. Ойн сангийн газар нь 2002 оныхоос 1600 га буюу 10.2 хувиар буурсан.

Тусгай хэрэгцээний газар: Тусгай хэрэгцээний газар 1739,0 га үүнээс байгалийн нөөц газар 1600га улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 136,8 га, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар 1,8 га, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгал орчины цаг агаарын төлөв байдлын ажиглалтын талбай 0,4 га тус тус байгаа бөгөөд 2002 оны балансаас төмөр замын 300,5 га газрыг тухайн ангилалд оруулан энэ оны балансаас хасаж өөрчлөлтийг тусгалаа.

2.2. Газрын харилцааны өнөөгийн байдал.

Нийгмийн өнөөгийн харилцааг даган газрын харилцаанд оролцогчдын эрх үүрэг улам бүр нарийсч, иргэн аж ахуйн байгууллага газрыг хууль эрхийн хэмжээнд баталгаатай эзэмшиж ашиглаж эхэлснээс хойш бараг 10 шахам жил боллоо.

Одоогоор тус аймгийн хэмжээнд нийт 8153 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газрын эзэмших, ашиглах, өмчлөх эрх нь баталгаажсны 901тариалангийн, 412 хадлангийн, 8 уурхайн, 626 нь аж ахуйн, 6206 гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар тус тус эзэмшиж, ашиглаж байна.

Хадлангийн газрын ашиглалтын хувьд нийт 412 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад эзэмшүүлж ашиглуулсан бөгөөд 403 иргэн, 6 аж ахуйн нэгж байгууллага, 3 төрийн байгууллагад эзэмшүүлж байна.

Тариалангийн газарт 2003 онд аймгийн хэмжээнд 41 аж ахуй нэгж байгууллага 2756 өрх тариалалт хийж, 1931 га талбайгаас үр тариа 1982 тонн, төмс хүнсний ногоо 2690,0 тн-ийг тус тус хураан авсан байна. Ирэх онд тариалалт хийхээр 1770.0 га талбайд хавж элдэншүүлэх технологиор уриншийн боловсруулалт хийжээ.

2003 оноос газрын шинэтгэлийн хүрээнд Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан нэг удаа үнэгүй

өмчлүүлэх газрын хэмжээг хүн амын нягтрал, газар нутгийн хэмжээг харгалзан Баян-өндөр суманд 0,08-0,11 га, Жаргалант суманд 0,2 га байхаар тогтоон тус бүр 571,9 га ба 86,7 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөжээ. Тус аймагт 19686 иргэн газар өмчилж авахаас 8411 иргэн гэр орон сууц хашааны газар, 227 аж ахуйн нэгж байгууллага өөрийн хэрэгцээний эзэмшил газраа хуулийн дагуу эзэмших эрх хангагдсан тул цаашид өмчлүүлэх боломжтой болжээ. 2004 оны 5-р сарын байдлаар газар өмчлөхөөр 6000 гаруй иргэн өргөдөл ирүүлснээс 3252 иргэнд 255,3 га газрыг шинээр олгожээ.

Харин хотын ерөнхий төлөвлөгөөгөөр авто зам болон барилга байгууламж барих, өндөр хүчдэлийн шугам бүхий газар суурьшсан 1641 иргэний газрыг өмчлүүлэх боломжгүй гэж үзжээ.

Тус аймагт 178 иргэн, 193 аж ахуйн нэгж байгууллага, 6 гадаадын байгууллага газар ашиглаж байна.

2.3. Газрын үнэлгээ, төлбөр

Газар нь хүний оршин тогтнох орон зайн хэрэгцээнээс гарч эдийн засаг, зах зээлийн утга агуулгатай болж газрын үнэлгээ төлбөрийн систем бүрэлдсэн билээ. Орхон аймагт хууль ёсны газрын эзэмшигч, ашиглагчдаас 2003 онд 3366848 мян.төг-ийг орон нутгийн төсөвт хуримтлуулсны 96 хувь нь Эрдэнэт үйлдвэрт ноогдож байна. Томоохон татвар төлөгчдийн тоонд хотын барилгажсан бүсийнхэн орох ба газар тариалангийнхан орж байна. /Хүснэгт 14/

Хүснэгт 14. Газрын төлбөрийн хуримтлал 2003 оны байдлаар

ДД	Газрын менежментийн бүсүүд	2003 он	
		талбай /га/	төлбөр /мян.төг/
1.	Хотжсон бүс /барилга байгууламж, гэр хорооллын газрууд/	13576.5	100300.4
3	Газар болон ховор ландшафтыг хадгалах бүс /орон нутгийн тусгай хамгаалалт/	1415.4	1248
4.	ХАА-н барилга байгууламжийн доорхи газар	-	88
5.	Хадлангийн газар	1286.2	-
6.	Тариалангийн газар	5577.1	5212
7.	Үйлдвэр уурхайн бүс	5548.6	3260000
Нийт дүн		21855.2	3366848

Газрын төлбөрийн хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 152-р тогтоолыг үндэслэн тогтоодог бөгөөд сүүлийн жилүүдэд хотын механик өсөлттэй холбоотойгоор газрын эрэлт хэрэгцээ ялангуяа гэр хорооллын хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгаатай холбоотойгоор төлбөр тогтооход онцгой анхаарч төвлөрлийг сааруулах механизм болгон ашиглавал зохистой.

2.4 Газар хамгаалах арга хэмжээ

Дээрхи судалгаануудын дүнгээс үзвэл Орхон аймгийн нутагт газрыг элэгдэл эвдрэл доройтолд оруулж байгаа нилээд олон хүчин зүйлс байгаагийн дийлэнхийг уулын үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой юм. Мөн хотжилтын нөлөөгөөр нилээд их хэмжээний газар доройтолд орох шалтгаан болжээ.

Газрын элэгдэл эвдрэлийг зогсоох, нхөхөн сэргээх талаар орон нутгийн байгууллагууд нилээд анхаарч өөрсдийн болон газар эзэмшигч аж ахуй нэгжийн хүчээр нилээд хэмжээний газарт нөхөн сэргээлт хийсэн байна. Өнгөрсөн онд элэгдэл эвдрэлд орсон 2249 га газрыг нөхөн сэргээхэд 1286.1 мян.төгрөгийн ажил хийжээ. /Хүснэгт 15 /

Хүснэгт 15. Газрыг нөхөн сэргээх, тордон сайжруулахаар авч буй арга хэмжээ

ДД	Арга хэмжээ	Газрын байршил	Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Хөрөнгийн эх үүсвэр /мян.төг/
1	Ойн зурвас байгуулах	Баян-Өндөр	3000,0	БХСан
2	Эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээх	Уурхай	120000,0	УБҮ болон бусад ААНБ
3	Зүлэгжүүлж цэцэрлэгжүүлсэн	Хүрэнбулаг, Ганц модотын рашаан	2405,8	БХСан
4	Бэлчээр хамгаалах	Хангалын голын дагуу	6200,0	Орон нутгийн төсвөөс
	Нийт дүн		128605,8	

Ойн зурвас байгуулах /Баян Өндөр ууланд/, эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээх /Эрдэнэт үйлдвэр болон бусад аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил газарт/, зүлэгжүүлэх цэцэрлэгжүүлэх /Хүрэнбулаг, Ганц модотын рашааны хамгаалалтад/, бэлчээр нөхөн сэргээх /Хангалын голын сав дагуу/ зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Газрыг зөв зохистой ашиглах зорилгоор Эрдэнэт хот орчмын ногоон бүс, Жаргалант сумын Хангалын голын дагуух бэлчээрийг малын хөлөөс чөлөөлж өнжөөн бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, тариалангийн газрын элэгдэл эвдрэлийг тогтоож, бэлчээрийн даац хэтрэлт, хөрс хмгаалах талаар аймгийн Засаг даргын захирамж гаргах зэргээр зохион байгуулалтын арга хэмжээ авчээ.

ГУРАВ. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТӨНД ХАРГАЛЗСАН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛҮҮД

Орхон аймгийн гзар зохион байгуулалтан ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтөд харгалзах нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс бүрийн одоогийн болон хэтийн төлөвд дүн шинжилгээ хийж, цаашдын хөгжлийн чиг хандлагыг хэрэгжилтийн үе шатуудаар /2008-2012-2016-2020он/ тодорхойлон гаргалаа.


3.1.1. Хүн ам. Хүн амын төвлөрөл ба суурьшилт

Хүн ам, нийгмийн талаархи SWOT шинжилгээ

Давуу талууд:

1. Аймгийн хүн ам 82.0 мянга, өрхийн тоо 20.0 мянга бөгөөд нийт хүн амын 95.8 хувь нь хотын төвд, 4.2 хувь нь хөдөөд амьдардаг. 1 кв.км нутагт 97 хүн ногдож байгаа нь хүн ам шигүү суурьшиж төвлөрч байгааг харуулж байна. 1 кв.км ногдох хүний тоо болон өсөлтийг төлөвлөлтийн хэрэгжилтийн үе шат бүрээр тодорхойлон диаграммаар харуулав.

Диаграмм 6



Тайлбар: Төлөвлөлтийн онууд: 1-2003 суурь он, 2-2008 он 3-2012 он, 4-2016 он, 5-2020 он

Графикаас харвал хүн амын нягтшил хотын барилгажсан хэсэгт нилээд өндөр байна.

Хүснэгт 16. Газрын ачааллыг Улаанбаатар хоттой харьцуулбал

Нэг кв.км талбайд ногдох хүн амын тоо	Хэмжих нэгж	кв.км	2003	2008	2012	2016	2020	
Нийт газар	Орхон	хүн/кв.км	844.0	97	124	146	170	195
	УБ хот	хүн/кв.км	4704.4	185	226	263	304	351
Суурьших газар	Орхон	хүн/кв.км	674.8	122	155	183	213	244
	УБ хот	хүн/кв.км	3505.4	249	303	352	409	471
Хот суурин	Орхон	хүн/кв.км	210.0	391	409	484	562	645
	УБ хот	хүн/кв.км	3244.9	268	327	381	441	508

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын ачаалал Орхон аймгийн хувьд улсын нийслэлээс бараг 2 дахин бага байх боловч барилгажсан хэсэгт улаанбаатар хотынхоос 1.5 дахин их байгаа нь газрын хүрэлцээнээс шалтгаалж байна. /хүснэгт 16/

3. Хөдөлмөр эрхлэлтийн албанд 1636 ажилгүй хүн бүртгэлтэй бөгөөд ажилгүйдлийн түвшин 5.0 хувь байна. /Хүснэгт 17 /


Хүснэгт 17. Хөдөлмөр эрхлэлтийн байдал, хэтийн төлөв

ДД	Ангилал	х/нэгж	2003	2008	2012	2016	2020
1	Нийт хүн амын тоо	мян.хүн	82.0	104.5	123.5	143.5	164.7
2	Хөдөлмөрийн насны хүн	мян.хүн	48.5	61.9	72.7	84.1	95.9
4	Ажил эрхлээгүй хүн ам	мян.хүн	5.2	4.2	3.6	3.2	2.9
5	Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо	мян.хүн	1.6	1.3	1.0	0.8	0.7

Хүснэгт 18. Ажлын байрны тоо, хэтийн төлөв

№	Ангилал	Нийт бий болох ажлын байрны тоо					
		х/нэгж	2003	2008	2012	2016	2020
1	Аймгийн хэмжээнд	мян.хүн	3.3	10.0	11.2	11.2	11.5
2	Улсын үйлдвэрийн газар	мян.хүн	0.4	1.2	1.0	0.8	0.8
3	Төр, төсвийн байгууллага	мян.хүн	0.1	0.4	0.3	0.2	0.2
4	Компани, нөхөрлөл, хоршоо	мян.хүн	1.5	4.5	5.3	5.4	5.6
5	Бусад	мян.хүн	1.3	3.9	4.6	4.7	4.8
6	Шинээр бий болох ажлын байр	мян.хүн	2.3	7.0	7.8	7.8	8.0

Диаграмм 7



Графикаас харахад 2020 оны түвшинд ажлын байрны хангалт бараг 8 дахин нэмэгдэх бөгөөд ажиллагсдын дийлэнхи нь аж ахуйн нэгж байгууллагад ажиллах болно.

3. Аймгийн нийт хүн амын бүтцийг насны бүлгээр авч үзвэл, 0-15 насныхан 35 %, хөдөлмөрийн насныхан 59 %, тэтгэврийн насныхан 6 %-ийг эзлэж байна. Эдийн засаг дахь идэвхитэй хүн ам 31.9 мянга, хөдөлмөрийн нөөц 43.6 мянга болж байна.

4. Бусад аймгуудад 1-2 их дээд сургууль, коллеж байхад Орхон аймагт 5 их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, 13 ерөнхий боловсролын сургууль, 18 цэцэрлэг ажилладаг. Төрийн 3, хувийн хэвшлийн 6 эмнэлэг 436 ортой ажиллаж, 1000 хүнд их эмч 34, эмнэлгийн дунд мэргэжилтэн 60, эмнэлэгийн ор 61 ногдож байгаа бөгөөд 15 өрхийн нөхөрлөлийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна. /Хүснэгт 19/

Хүснэгт 19. Сургууль, цэцэрлэгийн тоо, хангамжийн өнөөгийн байдал, хэтийн төлөв

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2003 он	2008 он	2012 он	2016 он	2020 он
Сурагчдын тоо	Мян.хүн	21.4	27.2	32.1	37.3	42.8
Сургуулийн тоо	Тоо	13	16	19	22	26
Нэмэгдэх сурагчдын тоо	Мян.хүн		5.8	10.7	15.9	21.4
Хүүхдийн тоо	Мян.хүн	4.1	5.2	6.1	7.1	8.2
Цэцэрлэгийн тоо	Тоо	18	22	26	31	36


Нэмэгдэх хүүхдийн тоо	Мян.хүн		1.1	2.0	3.0	4.1
Орны тоо	ширхэг	436	556	656	763	876
Эмнэлгийн тоо	Тоо	9	11	13	15	18
Шаардлагатай орны тоо	Тоо		120	220	327	440

5. Нутаг дэвсгэрийн хувьд бага, хот хөдөөгийн хоорондохи зай ойрхон, харьцахад хялбар учраас аймгийн хэмжээнд хот хөдөөгийн ялгаа улам багасч хот, хөдөөг хослуулан амьдрах шинж харагддаг.

Сул талууд:

1. Аймгийн хэмжээнд нэг хүнд ногдох дундаж орлогын хэмжээ 108,0 мянган төгрөг боловч нийт хүн амын 15.8 хувь буюу 2.8 мянган өрхийн 13.0 мянган хүн нэн ядуу амьдарч байна.

Диаграмм 8



Хүснэгт 20. Ажиллагсдын мөнгөн орлогын байдал

№	Ангилал	Нэг ажилчны сарын дундаж орлого, цалин хөлс					
		х/нэгж	Хэрэгжилтийн үе шат				
			2003	2008	2012	2016	2020
1	Аймгийн хэмжээнд	мян.төг	108	206.7	315.1	436.1	546.6
2	Үйлдвэрлэлийн салбарт	мян.төг	143.4	288.4	453.8	640.6	808.8

3	Үйлчилгээний салбарт	мян.төг	87.4	175.8	276.6	390.5	492.9
4	Төр, төсвийн салбарт	мян.төг	91.5	172.8	253	344.1	434.5
5	ХАА-н салбарт	мян.төг	108.1	190.5	278.9	379.5	479.1
6	Бусад	мян.төг	107.1	206.2	313	425.9	517.7

3.Тус аймгийн хувьд хүн амын өсөлтөнд механик өсөлтийн эзлэх хувь өндөр байна. Голдуу мэргэжил боловсролгүй, ажлын туршлагагүй, малгүй болсон иргэд Булган, Завхан, Увс, Хөвсгөл зэрэг хөдөө аймгуудаас шилжин ирж байхад мэргэжил боловсролтой, ажлын туршлагатай хүмүүс Улаанбаатар хот руу шилжин явдаг. /Хүснэгт 21 /

Хүснэгт 21. Хүн амын шилжилт хөдөлгөөн

Үзүүлэлт	Шилжих газар	Хэмжих нэгж	2003 он	2008 он	2012 он	2016 он	2020 он
Нийт хүн ам	Орхон	мян.хүн	82.0	104.5	123.5	143.5	164.7
	УБ хот	мян.хүн	871.1	1062.1	1235.5	1432.0	1650.0
Хүн амын нийт өсөлт	Орхон	мян.хүн	3.0	22.5	19.0	20.0	21.2
	УБ хот	мян.хүн	24.6	191.0	173.4	196.5	218.0
	Орхон	хувь, %	3.8	27.4	18.2	16.2	14.8
	УБ хот	хувь, %	2.9	21.9	16.3	15.9	15.2
Хүн амын жилийн дундаж ердийн өсөлт	Орхон	мян.хүн	0.8	1.0	1.3	1.5	1.8
	УБ хот	мян.хүн	8.5	11.2	16.4	22.1	25.3
	Орхон	хувь, %	1.0	1.10	1.13	1.15	1.20
	УБ хот	хувь, %	1.0	1.1	1.3	1.5	1.5
Хүн амын механик өсөлт	Орхон	мян.хүн	2.2	17.4	13.9	14.0	14.0
	УБ хот	мян.хүн	18.8	135.0	108.0	108.0	101.0
	Орхон	хувь, %	2.8	21.2	13.3	11.3	9.8
	УБ хот	хувь, %	2.2	12.7	8.7	7.5	6.1

4. Мэргэжлийн /анхан болон дунд шатны мэдлэг/ боловсролтой ажилгүйчүүдийн тоо сүүлийн жилүүдэд эрс багасч дээд болон бүрэн, бүрэн бус дунд боловсролтой, анх удаа ажил эрж байгаа ажилгүйчүүдийн тоо буурахгүй өсөх хандлагатай байна.

Боломж:

1. Орхон аймгийн эрүүл мэнд, боловсрол болон бусад салбарууд нь Хангайн бүсийн бусад тулгуур төвтэй хоршиж, төрөлжиж өргөжих шинжтэй байна.

2. Хангайн бүсийн тулгуур төв болсноор томоохон хэмжээний үйлдвэр, үйлчилгээний газрууд шинээр бий болохын хирээр ойр орчмын бусад аймаг, хотуудаас шилжин ирэгсэд улам нэмэгдэнэ.

Өөрчлөлтийн чиг хандлага.

1-р үе шат. /2004-2008 он/

1. Аймгийн хүн ам жилд дунджаар 2.9 - 3.1%-аар өснө. Ажилгүйчүүдийн 30-аас доошгүй хувийг ажлын байраар хангана. Ажил эрхлэлтийн түвшинг 66.0 %-д хүргэнэ. Ажилгүйдлийг 2000 оны хэмжээнээс өсгөхгүйгээр байлгана.

2. Хувийн хэвшлийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудын тоо, үйлчилгээний хүрээг нэмэгдүүлнэ.

3. Арвайхээр хотын ШУТС-ийн Технологийн сургууль, Хархорины төрийн өмчийн коллеж, Эрдэнэт хотын ШУТИС-ийн Теникийн сургуулиудыг хоршуулж, Бүсийн их, дээд сургуулийн цогцолбор болно.

4. Хангайн бүсийн байгалийн баялаг, түүхий эдийн нөөц, амьдралын туршлага, оюуны чадавхийг зах зээлд бүрэн ашиглах, орчин үеийн технологийг хөгжүүлэхтэй холбогдсон их, дээд сургуультай хоршсон шинжилгээ, судалгааны төрөлжсөн байгууллага бий болгоно.

5. Эрдэнэт хотын нэгдсэн эмнэлгийг өргөтгөж Зүрх судасны өвчний оношлогооны төв байгуулна. Мөн Эм эмнэлэгийн хэрэгслийн хангамжийн сүлжээ байгуулна.

2-р үе шат. /2009-2012 он/

1. Арьс шир боловсруулах, барилгын материалын зэрэг үйлдвэрүүд баригдаж эхэлснээр ажлын байрны тоо хэмжээг жилд дунджаар 2.5-3.0 мянгаар нэмэгдүүлж, ажилгүйдлийг багасгаж ядуурлыг бууруулна.

2. Хүн амын бодит орлого болон амьжиргааны түвшинг байнга нэмэгдүүлнэ.

3-р үе шат. /2013-2016 он/

1. МАА-н гаралтай түүхий эд боловсруулах Аж үйлдвэрийн паркийн цогцолбор, цэвэр зэс боловсруулах үйлдвэрүүд шинээр ашиглалтанд орсноор ажлын байрны тоо нэмэгдэж, ажилгүйдэл багасаж, ядуурал буурна.

2. Ажиллагсдын сарын дундаж цалин одоогийн хэмжээнээс 3,5-4,0 дахин нэмэгдэх замаар хүн амын бодит орлого болон амьжиргааны түвшин байнга нэмэгдэнэ.

4-р үе шат. /2017-2020 он/

1. Хүн амын амьдрах нөхцлийг сайжруулахад чиглэгдсэн нийгмийн үйлчилгээнүүдийн хүрээг нэмэгдүүлнэ..

3.1.2. Хотжилт, үйлдвэржилт, дэд бүтцийн хөгжил

Хотжилт, үйлдвэржилтийн талаархи SWOT шинжилгээ:

Давуу талууд:

1. Улсын нийт бүтээгдэхүүний 20.7 хувь, ДНБ-ний 8.6 хувийг үйлдвэрлэж, борлуулалтын 33.3 хувь, экспортын 36.3 хувийг хийдэг.

2. Жилд 25.0 сая тн хүдэр олборлож боловсруулах хүчин чадалтай “Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, 1350 мянган кв.м хивс нэхэх хүчин чадалтай “Эрдэнэт хивс”, 950 бог, 600 бод нядалж, 2280 тн мах хөлдөөж хадгалах хүчин чадалтай “Эрдэнэт прогресс”, Монгема, 1200 тн талх, 500.0 мянган л архи, 2.0 сая л пиво, 2.0 сая л сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх “Эрдэнэт чандмань”, 50.0 мянган тн түүхий нефть боловсруулах Петролиум продакшн, төмөр хийц бэлдэцийн Эрдэнэт металл, Металл индустралл”, 140.0 тн самнасан ноолуур үйлдвэрлэх “Эрдэнэт ноолуур”, 3600 тн 99.9 %-ийн сорьцтой катодын зэс утас үйлдвэрлэх “Эрдмин” зэрэг 103 үйлдвэр 180-аад тэрбум төгрөгийн 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Жилд дунджаар 60-аад байгууллага шинээр бий болж байна. /Хүснэгт 22 /

Хүснэгт 22. Шинээр бий болох үйлдвэр, үйлчилгээний газар

№	Ангилал	х/нэгж	Хэрэгжих үе шат				
			2003 он	2008 он	2012 он	2016 он	2020 он
			1	Аймгийн хэмжээнд	тоо	57	233
2	Үйлдвэрлэлийн салбарт	тоо	4	19	16	17	21
3	Үйлчилгээний салбарт	тоо	29	120	125	123	138
4	Төр, төсвийн салбарт	тоо	6	15	12	8	6
5	ХАА-н салбарт	тоо	7	35	47	59	76
6	Бусад	тоо	11	44	43	45	52

3. 5-6 төрлийн бүтээгдэхүүнийг экспортонд гаргаж байгаа ч гадаад худалдааны эргэлтийн 79.0 хувийг экспорт, 21 хувийг импорт эзэлдэг.

Сул талууд:

1. Бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн боломж болон багтаамж, үйлдвэрлэлийн хөдөлмөрийн зохион байгуулалт, санхүүгийн эх үүсвэрийн дутагдал, түүхий эд, материалын хангамжаас шалтгаалж нефть боловсруулах, хүнс, хивс, барилгын материал, мод боловсруулах, төмөр хийц бэлдэцийн зэрэг зарим үйлдвэрүүд үйлдвэрийнхээ төслийн хүчин чадлаа бүрэн ашиглаж чадахгүй, байнга тогтвортой жигд ажиллахгүй байна.

2. Аймгийн төсвийн орлого нь Эрдэнэтийн УБҮ-ээс голлон хамаардаг бөгөөд орлогын дийлэнхи хувийг зөвхөн газрын төлбөр эзэлдэг.

Боломж:

1. Зэсийн баяжмалыг хими болон бусад технологийн аргаар боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр баригдах боломжтой.

Хот байгуулалтын талаархи SWOT шинжилгээ

Давуу талууд:

1. 273.1 мянган кв.м талбай бүхий тохилог орон сууцанд 9.9 мянган өрхийн 31.5 мянган хүн амьдардаг бөгөөд нийт өрхийн 49.6 хувийг эзэлж байна. 11-р бичил хороолол болон зээлийн хороололд 120 орчим амины орон сууц баригдаж ашиглагдаж байна.

2. Асфальт-бетон, төмөр-бетон хийц, 2 карьерийн үйлдвэр, 3 тоосгоны үйлдвэр, барилгын хаалга, зүймэл шалны зэрэг барилгын материалын үйлдвэрүүд нь барилгажилтыг нэмэгдүүлэх нөхцлийг зохих хэмжээнд бүрдүүлж байна. Шинэ хорооллуудад жилд дунджаар 7.5 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил хийгдэж байна.

3. Жилд дунджаар 88.2 сая квт цахилгаан эрчим хүч, 605.3 мянган гкал дулаан үйлдвэрлэдэг цахилгаан, дулааны эрчим хүчний системтэй, Дархан-Уул, Сэлэнгэ аймууд болон Улаанбаатар хотыг холбосон засмал хар зам болон олон улсын төмөр замтай, радио релейн шугам болон интернет сүлжээтэй, нийт айл өрхийн 34.0 хувь буюу 6520 айл өрх, 1200 аж ахуйн нэгжийг телефон утасны үйлчилгээгээр хангадаг тоон системийн автомат телефон, үүрэн телефон болон сансарын холбооны станцтай, насанд хүрсэн 5 хүн тутмын нэг нь үүрэн телефон хэрэглэж байгаа зэрэг нь дэд бүтэц сайн хөгжснийг харуулж байна.

4. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн 730 байрнаас бусад орон сууцнууд хувьчлагдсан. 1372.7 га худалдаа, үйлчилгээний газар, 256.3 га хашааны газар, 97.8 га хүнсний ногооны талбайн газар олгогдож, улмаар хувьчлагдаж эхлээд байна.

Сул талууд:

1. Эрдэнэт хотын ахуйн хэрэглээний болон үйлдвэрлэлийн зориулалтын хэрэгцээт усыг Сэлэнгэ мөрнөөс татаж авчирдгаас оршин суугчдын хувьд хэрэглээний усны үнэ тариф өндөр, ойр орчмын голын усны агуулгын эрдэсжилтийн хэмжээ их байгаа зэргээс гүний усаар хангах шаардлага тавигдаж байна.

2. Бохир ус цэвэрлэх байгууламж нь төсвийн хүчин чадлаа 30-40 хувь хэтрүүлэн ажиллаж байна.

3. Аймгийн хэмжээнд 2003 онд автомашины тоо 40 гаруй хувиар эрс өссөнөөс замын ачаалал нэмэгдсэн, хөрөнгө болон материалын хангамжаас

шалтгаалан замын засвар үйлчилгээг технологийн зохих түвшинд хийж чадахгүй байгаагаас болж хотын доторхи замууд эвдэрч муудсан.

Боломж:

1. Булган-Хөвсгөлийн чиглэлд 153.5 км хар зам тавигдснаар аялал жуулчлалын сүлжээнд хамрагдахад улам хялбар болох юм. Авто, төмөр замын дагуу түр болон богино хугацаагаар буудаллаж амрах амралт, сувиллын газрууд, үйлчилгээний цэгүүдтэй бичил бүсүүд байгуулагдана.

2. Жаргалант сум /хуучнаар Улаантолгойн САА/ нь Эрдэнэт хотыг төмс, хүнсний ногоо, сүү, мах зэрэг ХАА-н бүтээгдэхүүнээр хангаж ирсэн бөгөөд цаашид ч дагуул хот хэлбэрээр хөгжих бүрэн боломжтой.

3. Хангайн бүсийн тулгуур төв болсноор тухайн бүс нутгийг удирдах, хөгжүүлэхэд давамгайлж оролцох болж байна.

Өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага.

1-р үе шат. /2004-2008 он/

1. Төмөр болон хийжүүлсэн царууц бетон эдлэхүүн үйлдвэрлэлийн бааз, цэвэрлэх байгууламжийг өргөтгөж шинэчилнэ. Барилгын машины түрээсийн бааз, барилгын материалын баталгаажуулалтын салбар төв байгуулагдснаар орон сууцны хорооллууд болон үйлдвэр, үйлчилгээний газрууд шинээр баригдах нөхцлийг бүрдүүлж өгч байна.

2. Шинээр арьс шир боловсруулах үйлдвэр байгуулна. Орхон, Булган, Хөвсгөл зэрэг аймгуудын МАА-н гаралтай түүхий эд - арьс шир, ноос ноолуур, мах, дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах Аж үйлдвэрийн паркийг бий болгож бүтээгдэхүүнийг нь экспортлоно.

3. Зэсийн бага агуулгатай баяжмалын хаягдал шороон овоолгонуудыг орчин үеийн хими болон бусад технологийн аргаар боловсруулж эцсийн бүтээгдэхүүн /цэвэр зэс бүтээгдэхүүн/ үйлдвэрлэх 2 үйлдвэр баригдаж эхэлнэ.

4. Түүхий нефть боловсруулах үйлдвэр нь жилд дунджаар 22.3 мянган тн автобензин, 22.8 мянган тн дизель түлш, 4.8 мянган тн мазут үйлдвэрлэж, Эрдэнэт хот болон ойр орчмыг хангах болно.

5. Булган, Мөрөнгийн хоорондхи засмал хар зам, 110кв-ын цахилгаан дамжуулах шугам нь Орхон аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрнө. Хархорин-Хөвсгөлийн зэрэг аялал жуулчлалын төвүүдийг холбосон аялал жуулчлалын нэгдсэн сүлжээний эхлэл тавигдаж 4-5 аялал жуулчлал, амралт сувиллын газрууд шинээр бий болно.

6. Бохир усны цэвэрлэх байгууламжийг гадаад улсуудын хөрөнгө оруулалтын тусламжтайгаар өргөтгөж хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

7. Хуурай хог хаягдал боловсруулах чиглэлээр цаас картоны, яс боловсруулах болон полиэтилен гялгар уут, ундааны сав зэргийг боловсруулах үйлдвэрүүд баригдаж эхэлнэ.

2-р үе шат. /2009-2012 он/

1. Бүрэнхааны фосфорын бордооны үйлдвэр баригдаж эхэлснээр зам харилцаа, газар тариалангийн хөгжилд зохих хэмжээгээр нөлөөлнө.

2. Жилд :

- 332.1 мянган хонины арьс, 328.0 мянган ямааны арьс, 120.2 мянган үхрийн шир, 44.2 мянган адууны шир, 3.0 мянган тэмээний шир бэлтгэн боловсруулах,
- 596.7 тн ноолуур, 3196.9 тн хонины ноос, 250.4 тн тэмээний ноос, 398.9 хялгас хөөврийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах
- 13.16 мянган тн хонины мах, 9.58 мянган тн ямааны мах, 24.92 мянган тн үхрийн мах, 7.49 мянган тн адууны мах, 1.81 мянган тн тэмээний махыг үйлдвэрийн боловсруулж, улмаар экспортод гаргах боломжтой Аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

3. Эцсийн бүтээгдэхүүн /цэвэр зэс бүтээгдэхүүн/ үйлдвэрлэх 2 үйлдвэрийг ажиллуулж 3 дахь үйлдвэрийг барьж эхэлнэ.

3-р үе шат. /2013-2016 он/

1. Мах, махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос, ноолуур, хивс зэрэг бүтээгдэхүүнүүдийг гадаад зах зээлд нийлүүлдэг Аж үйлдвэрийн парк цогцолборыг улам өргөжүүлнэ.

2. Зэсийн баяжмалыг олборлох, баяжуулах, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 5 үйлдвэрээс бүрдсэн иж бүрэн цогцолбор үйл ажиллагаагаа явуулах болно.

4-р үе шат. /2017-2020 он/

1. Хангайн бүс болон улсын хэмжээнд аж үйлдвэрлэлээрээ тэргүүлэх том төв хэвээрээ байна.

3.1.3. ХАА-н үйлдвэрлэл, түүний эрчимжилт

3.1.3.1. Мал аж ахуйн талаар.

Мал аж ахуйн талаархи SWOT шинжилгээ

Давуу талууд:

1 Аймагт нийтдээ 107.9 мянган мал /2003 оны эцсийн дүнгээр/ тооллогдсоны Хангайн бүсэд үржүүлэхэд илүү тохиромжтой хонь, үхэр голлож байна. /Хүснэгт 23/

Хүснэгт 23. Малын тоо

№	малын нэр, төрөл	хэмжих нэгж	2003	Төлөвлөлтийн үе шат			
				1-р үе	2-р үе	3-р үе	4-р үе
1	Тэмээ	мян.тол	0.1	0.1	0.1	0.1	0.1
2	Адуу	мян.тол	7.8	8.0	8.2	8.6	9.2
3	Үхэр	мян.тол	11.9	12.1	12.5	13.1	13.9
4	Хонь	мян.тол	42.8	43.6	44.9	47.0	50.0
5	Ямаа	мян.тол	45.3	45.8	47.2	49.4	52.5
Бүгд		мян.тол	107.9	109.6	112.9	118.2	125.7
Бүгд /хонь-толгой/		мян.тол	210.1	213.9	220.4	230.7	245.4

2. 1.8 мянган малтай өрхийн 0.8 мянга нь малчин өрх бөгөөд нэг малтай өрхөд 58, нэг малчин айлд дунджаар 131 толгой мал ноогдож байна. 60-150 малтай малчин өрхүүд дийлэнхи хувийг эзэлдэг. Нийт малын 3/4 нь Баян-Өндөр сум, 1/4 нь Жаргалант суманд байдаг.

3. Бэлчээрийн мал аж ахуйгаас суурин, эрчимжсэн аж ахуйд шилжих эхлэл болох 7 саалийн үнээний фермерийн аж ахуй, хоршоо байгуулагдсан.

4. Цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилдэг омгийн мал нь нийт малын 2.2 хувь буюу 2393 толгой бөгөөд 1171 хонь, 987 ямаа, 233 үхэр байна.

5. МАА-н гаралтай бүтээгдэхүүнээ борлуулах зах зээл нь ойрхон, дэд бүтэц сайн хөгжсөн.

Сул талууд:

1. Зах зээлд борлуулсан, өөрсдөө хүнсэнд хэрэглэсэн болон зүй бусын хорогдлоос шалтгаалан зарим айлууд огт малгүй болсноос малтай болон малчин өрхийн тоо буурч байна. Үхэр, хонины тоо толгой эрс багасч байна. /Хүснэгт 24/

Хүснэгт 24. Хүнсний хэрэгцээний махны хангамж

№	Махны нэр, төрөл	хэмжих нэгж	2003	Төлөвлөлтийн үе шат			
				1-р үе	2-р үе	3-р үе	4-р үе
1	Тэмээ	тн	13.3	14.5	14.9	15.6	16.6
2	Адуу	тн	513.0	527.1	543.1	568.5	604.6
3	үхэр	тн	858.7	871.6	898.1	940.1	999.8
4	Хонь	тн	449.3	457.3	471.1	493.2	524.5
5	Ямаа	тн	272.0	274.8	283.1	296.4	315.2
6	Махаар хангах боломж	тн	2106.3	2145.3	2210.4	2313.8	2460.6
7	Бүгд /хонь-толгой/	мян.тол	55.5	56.5	58.2	60.9	64.8
8	Хэрэгцээт махны хэмжээ	тн	9022.0	11499.0	13583.6	15781.6	18120.9
9	Зөрүү / +, - /	мян.тн	-8966.5	-11442.5	-13525.4	-15720.7	-18056.1
10	Шаарлагатай малын тоо	мян.хонь-толгой	-236.1	-301.2	-356.0	-413.8	-475.3

2. Цаг агаарын хүндрэл, ган зудын байдал, мөн зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэх сонирхлоор бусад аймаг, сумдын малтай өрх олноороо Эрдэнэт хотыг тойрон нутагладаг зэргээс шалтгаалан бэлчээрийн даац хэтэрсэн.

3. Нутаг дэвсгэрийн хэмжээ бага, уламжлалт найрсаг харилцаанаас үүдэн зэргэлдээ 2 аймаг, 6 сумдын нутаг дэвсгэр дээр малаа малладаг.

4. Нийт малын малын тоонд ямааны эзлэх хувийн жин өндөр байгаагаас малын хоорондохи зохистой харьцаа алдагдаж байна.

Боломж

1. Сүү махны өндөр ашиг шимт малын олдоц бага учраас донор хуц, бухны гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэх зэрэг замаар цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн малын тоог нэмэгдүүлж сүү, махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэх нь зохимжтой.

2. Эрдэнэт-Дархан, Эрдэнэт-Булган, Булган-Хөвсгөлийн чиглэл дэх автозам, аялал жуулчлалын сүлжээний дагуу бүтээгдэхүүнээ нийлүүлэх боломж шинээр бий болж байна.

3. Аймгийн хэмжээнд 786 гахай, 1374 тахиа байгаа дээр үндэслэн гахай, тахианы загвар аж ахуй байгуулах боломжтой.

4. Эрдэнэт хот нь Хангайн бүсийн төв болж хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээ улам нэмэгдснээр МАА-н гаралтай бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ өснө.

3.1.3.2. Газар тариалангийн талаар

Газар тариалангийн талаархи SWOT шинжилгээ

Давуу талууд:

1. Тариалангийн 5.3 мянган га эргэлтийн талбайтай, үүний 45 %-д үр тариа, 15 %-д төмс, хүнсний ногоо тариалдаг, харин 35%-д буюу 1.2-1.9 мянга га талбайд уринш хийдэг. Газрын хөрс нь газар тариалан эрхлэхэд нэн тохиромжтой.

2. Жилдээ 20-40 тн өргөст хэмх, улаан лооль хураан авах хүлэмжийн аж ахуй ажилладаг.

3. Жилдээ 250 тн дарш, 60 гаруй тн гар тэжээл бэлтгэдэг. 40 гаруй тн овьёосыг тэжээлийн үйлдвэрт нийлүүлсэн.

4. Жаргалант сумын айл өрхийн талаас илүү хувь нь газар тариалан эрхэлдэг.

5. Жилдээ 12.0-13.5 мянган тн байгалийн хадлан бэлтгэдэг. Нийт хадлангийн 2/3-ыг Баян-Өндөр сум, 1/3-ийг Жаргалант сумаас бэлтгэдэг.

Сул талууд:

1. Тариалалтын 1/4-ыг нь гадны аймгуудын нутаг дэвсгэр тариалдаг. /Хүснэгт 25/

Хүснэгт 25. Үр тариа

№	Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2003	1-р үе	2-р үе	3-р үе	4-р үе
1	Тариалсан талбай	га	1931.0	2196.1	2196.1	2196.1	2196.1
2	Хэрэгцээг хангах боломж	тн	1979.8	2053.8	2119.3	2185.0	2250.7
3	Шаардлагатай хэрэгцээ	тн	3728.1	4751.6	5613.0	6521.3	7487.9
4	Тариалах шаардлагатай талбай	га	3584.7	4568.8	5397.2	6270.5	7199.9
5	Шаардлагатай талбайн хэмжээ	га	-1653.7	-2372.7	-3201.1	-4074.4	-5003.8

2. Газар тариалангийн чиглэлээр байгуулагдсан САА нь хувьчлалын явцад тарж бутарсан бөгөөд техник хэрэгслүүд нь хуучирсан.

3. Услалтын систем нь хуучирч эвдэрсэн, ашиглалтгүй болсон.

Боломж:

1. Газар тариалангийн хуучирсан услалтын системийг сэргээж ашиглах боломжтой.

Өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага.**1-р үе шат. /2004-2008 он/**

1. Баян-Өндөр, Жаргалант сумдад сүүний үхрийн эрчимжсэн загвар аж ахуй тус бүр нэгийг байгуулна.

2. Сүү, махны эрчимжсэн фермер, хоршоо эрхлэгчдэд малын тэжээл тариалах чиглэлээр тариалангийн талбай олгон, буурцагт, шүүст тэжээлийн хэрэгцээг нэмэгдүүлнэ. /Хүснэгт 26/

Хүснэгт 26. Тэжээлийн хангамж

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2003 он	2008 он	2012 он	2016 он	2020 он
1	Бэлчээрийн газар	га	39748.7	38500	38000	37000	36000
2	Бэлчээрийн ургац	м.тн	29.4	32.7	42.6	51.4	59.8
3	Хадлангийн газар	га	1400.0	2647.7	2647.7	2647.7	2647.7
4	Хадлангийн ургац	м.тн	13.5	27.5	29.5	31.5	33.5
5	Тэжээлийн ургамал	га	77.0	1446.4	1446.4	1446.4	1446.4
6	Тэжээлийн ургац	м.тн	0.2	9.4	23.4	37.5	43.6
7	үр тарианы талбай	га	1738.0	2196.1	2196.1	2196.1	2196.1
8	үр тарианы ургац	м.тн	2.0	2.8	3.1	3.4	3.7
10	Тэжээл.хангах боломж	м.тн	45.2	72.4	98.6	123.8	140.5
12	Тэжээл.нийт хэрэгцээ	м.тн	117.7	119.8	123.1	128.8	137
13	Шаардагдаж буй өвс тэжээл	м.тн	-72.5	-47.4	-24.5	-5.0	3.5

3. Хөрс боловсруулах цомхотгосон болон тэг эдлэншүүлэлтийн талбайг нэмэгдүүлнэ

4. Бага оврын услалтын системүүдийг нэвтрүүлэх, худаг гаргаж гар усалгаа хийх, мөн Жаргалант сумын хуучин услалтын системийг сэргээх замаар усалгаат газар тариалангийн талбайг нэмэгдүүлнэ.

5. Хүлэмжийн нөхцөлд хүнсний нарийн ногоо тариалалтыг улам өргөжүүлнэ. Ургамлын тосны тариалан, жимсний аж ахуй бий болох нөхцлийг судална. /Хүснэгт 27/

Хүснэгт 27. Тариалангийн газрын хэрэгцээ ба хангалт

№	Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2003	1-р үе	2-р үе	3-р үе	4-р үе
1	Тариалангийн талбай	га	728.9	1306.7	1306.7	1306.7	1306.7
2	Хэрэгцээг хангах боломж	тн	6372.9	11424.7	11424.7	11424.7	11424.7
3	Шаардлагатай хэрэгцээ	тн	4921.1	6272.2	7409.2	8608.1	9884.1
4	Хангалтын хувь	%	129.5	182.1	154.2	132.7	115.6
5	Тариалах шаардлагатай талбай	га	563.1	717.6	847.7	984.9	1130.9

6. Эрчимжсэн газар тариаланг сүүний үхэр, гахай, тахианы аж ахуйтай хослон хөгжүүлэх бололцоог бүрдүүлнэ.

2-р үе шат. /2009-2012 он/

1. Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйнуудыг өргөжүүлнэ. /Хүснэгт 28/

Хүснэгт 28. Хээлтэгч малын тоо

№	Малын нэр, төрөл	хэмжих нэгж	2003	1-р үе	2-р үе	3-р үе	4-р үе
1	Тэмээ	мян.тол	0.01	0.01	0.01	0.01	0.01
2	Адуу	мян.тол	2.2	2.2	2.3	2.4	2.6
3	Үхэр	мян.тол	6.9	7.0	7.2	7.6	8.1
4	Хонь	мян.тол	28.8	28.7	29.6	31.0	33.0
5	Ямаа	мян.тол	24.1	24.3	25.0	26.2	27.8
6	Бүгд	мян.тол	62.0	62.3	64.2	67.2	71.4
7	Бүгд /хонь-толгой/	мян.тол	107.1	108.4	111.7	116.9	124.4
8	Ингэний сүү	мян.л	0.2	0.3	0.3	0.3	0.3
9	Гүүний сүү	мян.л	172.0	178.9	184.3	193.0	205.2
10	Үнээний сүү	мян.л	4425.6	4493.7	4630.3	4846.8	5154.5
11	Хонины сүү	мян.л	115.3	115.0	118.5	124.0	131.9
12	Ямааны сүү	мян.л	192.7	194.2	200.1	209.4	222.7
13	Сүүгээр хангах боломж	мян.л	4905.8	4982.1	5133.5	5373.4	5714.6
14	Хэрэгцээт сүүний хэмжээ	мян.л	3690.8	4704.1	5556.9	6456.1	7413.1
15	Зөрүү / +, - /	мян.л	1215.0	277.9	-423.4	-1082.7	-1698.5
16	Шаардлагатай малын тоо	мян.хонь-толгой			-9.2	-23.6	-37.0
17	Сайн үүлдрийн үнээ	мал		-55	-132	-338	-531

18	Фермерийн тоо	тоо		3	7	15	25
19	15-20 үнээтэй фермер	тоо		2	5	10	17
20	25-50 үнээтэй фермер	тоо		1	2	5	8
21	Шаардлагатай талбай	га		1.4	3.2	7.2	11.8

2. Сүү махны өндөр ашиг шимт малын донор хуц, бухны гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэх зэрэг замаар цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн малын тоог нэмэгдүүлж сүү, махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэнэ.

3. Олон найрлагат багсармал, хорголжин болон макро, микро элементээр баяжуулсан эрдэс тэжээлийн үйлдвэрлэх бага оврын үйлдвэр байгуулна.

3-р үе шат. /2013-2016 он/

1. Зохиомол хээлтүүлгийн байнгын болон явуулын цэгийг ажилуулж эхэлнэ.
2. Усалгаат тариалангийн талбайн хэмжээг эрс нэмэгдүүлнэ.

4-р үе шат. /2017-2020 он/

1. Эрчимжсэн газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлнэ.
2. Орхон аймгийн сүү болон төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрсдийн ХАА-н үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.

ДӨРӨВ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГЫН БҮСҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1990 оноос өмнө монгол оронд хэрэгжиж байсан газар төлөвлөлтийн зарчим нь газрыг нийгэмд аль болох өгөөжтэй ашиглах асуудал байсан бол өнөө үед нийгмийн аливаа үйл ажиллагааг байгалийн нөөцийн даац чадавхид тохируулах, газрын доройтол болох цөлжилт, ой, ургамал, хөрс, усны нөөцийн хомсдлоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж байна.

Газрын менежментийн энэхүү үндсэн зарчмыг баримтлан Орхон аймгийн өнөөгийн болон хэтийн хөгжилд зохицсон газрын менежментийн бодлогын бүсүүдийг төлөвлөв. Үүнд :

- Хөдөө аж ахуйн газрын менежментийн бүс
- Хотын болон суурьшсан газрын менежментийн бүс
- Зам шугам сүлжээний газрын менежментийн бүс
- Ойн сангийн газрын менежментийн бүс
- Усан сангийн газрын менежментийн бүс
- Уурхай болон газрыг хадгалан хамгаалах, нөхөн сэргээлтийн менежмент
- Хүн амын социаль нөхөн сэргээлтийн бүс гэх мэт

4.1. Хөдөө аж ахуйн газрын менежментийн бүсүүд

Хөдөө аж ахуйн газрын менежментийн бүсүүд нь ашиглалтын зориулалтаараа

1. бэлчээрийн газрын
2. хадлангийн газрын
3. тариалангийн газрын гэсэн ангиллаар төлөвлөгдсөн бөгөөд хөдөө аж ахуйн барилга байгууламж, үтрэм зэрэг газар ашиглалтын дагалдах төрлүүд нь тухайн бүсийн хэмжээнд байршиж аймаг сумын газар зохион байгуулалтын жил бүрийн төлөвлөгөөгөөр зохицуулагдах юм.

4.1.1 Бэлчээрийн газрын менежмент

Тус аймаг нь бэлчээрийг уламжлалт мал аж ахуйн зохицуулалтаар ашиглаж иржээ. Хотын хөгжлийн бодлоготой уялдуулан эрчимжсэн аж ахуйнуудыг зохистой байршуулах үүднээс бэлчээрийн газрын менежментэд зарчмын нилээд өөрчлөлтүүд тусгагдсан болно.

Бэлчээрийн газрын төлөвлөлтийг газрын эзэмшилт ашиглалтын хувьд 4 үндсэн бүсэд хувааж тус бүрт нь ашиглалтын чиглэлийг тогтоолоо. Үүнд:

1. Хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс
2. Хуваарьт эдлэн болон нийтийн ашиглалт хосолсон газартай аж ахуйн суурьшлын бүс
3. Өрхийн аж ахуйн суурьшлын бүс
4. Чөлөөт ашиглалтын бүс

4.1.1.1. Хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс

Энэхүү бүсийг эдлэн газрын хэмжээ нь урьдчилан нормчлогдсон, нутаг дэвсгэрийн хуваарилалтын дагуу газар эзэмших гэрээнд заасан болзол, нөхцлөөр нарийн төрөлжсөн, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх фермер, аж ахуйн нэгжийн газрыг энэ бүсэд хамруулан авч үзсэн үүнийг эрчимжсэн мал аж ахуйн бүс гэж бас ойлгож болно. /хүснэгт 29/

Хүснэгт 29. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломжтой нутгийн бэлчээрийн даацын одоогийн үнэлгээ

№	Газрын байршил	Бэлчээр			Бэлчээр ашиглалтын коэф	Бэлчээрийн даац /үхрээр/
		Талбай /га/	Га-ийн ургац	Тэжээлийн нөөц / тн /		
1	Жаргалант сум	15130.1	4.0	605	60	259
2	Чингэлийн голын савд Бүрэн бүстийн орчимд	177.4	3.3	6	-	15
	Дүн	15307.5		61.1		274

Дээрх тооцоог саалийн үнээг дан байгалийн тэжээлээр хангах нөхцөлд ашиглаж болох бөгөөд дулааны улирлын 5 сард байгалийн тэжээлээр үлдсэн сард тариалсан тэжээлийн ургамлаар тэжээх нөхцөлд малын тоог 531 үнээ болгон нэмэгдүүлэх боломжтой. Эрчимжсэн аж ахуйн нэг онцлог нь хүйтний улиралд малыг үр тариа, тэжээлийн манжин, сүрэл, дарш, давс хужиараар байнга байранд тэжээдэг онцлогтой тул аж ахуй нь бэлчээрээс гадна тэжээл тариалах тариалангийн талбайтай байх шаардлагатай. Архөндий, Хавчин, Нарангийн булаг, Жаргалант суурин орчмын 1446 га тариалангийн талбайг тэжээл тариалахаар төлөвлөсөн.

Энэ бүс нь Жаргалант сумын нутагт Булгийн хөндий, Дулганы хөндий, Хөшөөтийн хөндийн урд хэсэг, Хангалын гол, Нарангийн болон Хавчингийн булаг орчмын нутаг хамрагдсан 15264.4 га буюу нийт нутаг дэвсгэрийн 17.6 хувьд оршин байгаа бөгөөд энд 25-50 үнээтэй 6 фермерийн аж ахуй хөгжүүлэхээр төлөвлөсөн.

Энэ бүсэд эзэмшил газрын байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах, хамгаалах асуудлыг газар эзэмшигч бүрэн хариуцах бөгөөд үйлдвэрлэлийнхээ үр ашгийн дээшлүүлэх үүднээс экологид хоргүй нөхцлөөр газарт хөрөнгө оруулж, эдлэн газраа хашиж хамгаалах, хөрсний үржил шимийг дээшлүүлэх, ургац нэмэгдүүлэх, үйл ажиллагаа явуулна. Энэ бүсэд орших аж ахуйнууд нь өөрийн хэрэгцээт тэжээлийг тариалах чиглэлээр газар тариаланг хөгжүүлнэ.

Энэ бүсэд үйлдвэрлэл эрхэлж буй газар эзэмшигч Эрдэнэт болон дагуул хотын хүн амд шаардлагатай мал аж ахуйн бүтээгдэхүүн нийлүүлэхэд чиглэгдэнэ.

Эрүүл ахуйн нарийн чанд дэглэмд захирагдаж үйлдвэрлэл явуулах учир ашиг шимийн төрөлжилтийн бус бусад мал, амьтан холилдон нутаглах, бусдын мал дамжин өнгөрөхийг тусгай эрхзүйн актын дагуу хатуу хориглох арга хэмжээ авна.

Эл бүсэд нутаг байршлын хувьд голын хөндий, уулсын ар хөндий, хоолой дагасан хар хүрэн, хүрэн хөрстэй, ургамалшилтын хувьд баялаг, ургац сайтай,

цаашид сайруулахад бэрхшээл багатай, экологийн даац сайтай газрыг хамарч байгаа. Гэвч одоогоор бэлчээрийг ямар нэг зохицуулалтгүйгээр ашигласан, мөн тариалангийн талбайг ашиглах горим буруу явагдсанаас үүдэн талхлагдлын шинж тод илэрсэн байна. Иймээс энэ бүсэд байгаль орчны тэнцвэрийг хадгалах, нэгэнт доройтолд орсон газрыг нөхөн сэргээх, усны эх булгийг хамгаалах арга хэмжээг авах нь чухал байна.

4.1.1.2. Хуваарьт эдлэн болон нийтийн ашиглалтын газартай хосолмол аж ахуйн суурьшлын бүс

Энэ бүс нь Баянцагааны эх болон Ар булаг орчим, Даристын ам, Онгоцотын ам, Ар булаг, Согоотын давааны орчим болон Уртын гол дагуу байхаар төлөвлөгдсөн бөгөөд байгаль цаг уурын хувьд чийглэг сэрүүн ой, нуга, хээр хосолсон, усан хангамж сайтай эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой нутаг юм. Нийт 6145.4 га буюу нийт нутаг дэвсгэрийн 7.1 хувийг хамарсан. /Хүснэгт 30/

Хүснэгт 30. Бүс нутаг дахь бэлчээрийн даац

№	Бүс нутаг	Бэлчээр			Бэлчээрийн даац /хонь толгой/
		Талбай /га/	Га-ийн ургац	Тэжээлийн нөөц / тн /	
1	Баянцагааны эх, Ар булаг орчим	710.1	3.5	2.5	2662.8
2	Онгоцотын ам, Даристын ам орчим	834,3	4.6	3.8	4111.8
3	Согоотын давааны орчим	259.3	3.0	0.7	833.4
4	Ингэт, Баруун залаат	4065.2	3.2	13.0	2763.0
5	Уртын голын сав	276.5	3.0	0.8	888.6
	Дүн	6145.4	17.3	20.8	11259.6

Уулсын ар, бэл хормой, голын хөндийгөөр чийгсэг нугын ургамалтай, нам уулс, ухаа гүвээ дагаж уулын хар хүрэн болон бараан өнгийн хөрстэй хялгана, жижиг үетэн, алаг өвст хээр зонхилно. Хүн малын нягтрал ихтэй хэсэгт бага зэрэг талхлагдсан. Цаашид газрын ачаллыг хэтрүүлэхгүй зөв зохицуулах шаардлагатай.

Энэ бүсэд уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэхийг хориглохгүй боловч сүү, махны чиглэлийн үхэр, хонь, адууны эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх чиглэлийг хэтийн зорилго болгоно. Иймээс эрчимжсэн мал аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжид газар хуваарилан эзэмшүүлнэ.

Хөдөө аж ахуйн газрын ашиглалтыг сайжруулах, үр шимийг нэмэгдүүлэхийн тулд фермер, аж ахуй дундын хоршилтыг дэмжиж, техникийн үйлчилгээний газрыг хөгжүүлэхийг эрмэлзэнэ.

4.1.1.3 Өрхийн аж ахуйн суурьшлын бүс

Цөөн тооны малд зориулан Говилын тосгон, Жаргалант сумын урд / далан орчмоор/ , Ар булаг орчмыг хамруулсан. Нийт 376.2 га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.2 хувийг эзэлнэ.

Газрыг өрх айлаар эзэмших бөгөөд газрын төлөв байдал, чанарын асуудлыг уг өрх хариуцаж, малын тооноос хамаарч түрээсийн төлбөр төлж, хариуцлага хүлээнэ. Газар хязгаарлагдмал, түрээсийн төлбөр төлөх учир мал бүхий иргэд аль болох өндөр ашиг шимтэй цөөн тооны малтай байхыг эрмэлзэх юм.

Энэ бүсэд бэлчээрийн мал аж ахуй эрхлэхийг хязгаарлаж жимс жимсгэнэ, далд хөрсний ногооны аж ахуй, гахай, тахиа, зөгийний аж ахуй хөгжүүлэх чиглэлийг баримтална.

4.1.1.4 Чөлөөт ашиглалтын бүс

Дээр дурьдсан 4 бүсээс гадна тодорхой хэмжээний бэлчээр уламжлалт мал аж ахуйд улирлын хуваарьтайгаар ашиглагдахаар төлөвлөгдөж байна. Энд гол төлөв уулын сулавтар хөгжилтэй хар хүрэн болон нимгэн хүрэн хөрстэй хээр зонхилсон 11959.7 га бэлчээрийн газар хамрагдана. /Хүснэгт 31/

Хүснэгт 31. Чөлөөт ашиглалтын бүсийн бэлчээрийн даац

№	Бүс нутаг	Бэлчээр			Бэлчээр ашиглалтын зориулалт	Бэлчээрийн даац /хонь толгой/
		Талбай /га/	Га-ийн ургац	Тэжээлийн нөөц / тн /		
1	Хөөврийн хөндий, Чингэлийн голын сав	3206.4	3.3	23.9	Зун-намар	2179.7
3	Уртын голын сав	2268.5	4.2	9.5	өвөл-хавар	3856.8
4	Онгоцотын ам, Даристын амны орчим	780.5	4.5	3.5	өвөл-хавар	1421.9
5	Жаргалантын хөндийн баруун урд хэсэг, Нарангийн болон Хавчингийн булагийн орчим	1367.0	3.1	4.2	өвөл-хавар	1715.6
6	Мэргэн, Шувуут, Хөшөөтийн давааны орчмын хэсэг газар	4337.3	4.0	17.3	өвөл-хавар	7024.0

Энэ бүсийн ургамлан нөмрөг нь сийрэг тачир, ургац багатай. Ургамлан нөмрөгийг нөхөн сэргээхэд хялбар бус учир бэлчээр ашиглалтыг улирлын хуваарьтайгаар малын хөлөөс чөлөөлөх, ашиглалтыг хязгаарлах замаар зохицуулах боломжтой.

Аймгийн харьяат болон шилжин ирэгсэд газрыг чөлөөтэй ашиглах эрхтэй бөгөөд ачааллыг зохицуулах үүднээс газар ашиглах эрхийн бичгийг гаргаж уг бичгийг авсан иргэн энэ бүсэд суурьших эрхтэй байхаар зохицуулвал газрыг хамгаалахад чухал нөлөөтэй юм.

Мал тууврын зам чөлөөт ашиглалтын бүсэд хамрах бөгөөд Орхон аймгийн хувьд мал тууврын зам Чингэлийн голоор уруудаад Арцатын даваагаар давж Уртын гол даган нийт 23 км урт, 2376.3 га газрыг хамарсан. Одоогоор зарим тууварчид Булган-Эрдэнэт-УБ-ын чиглэлийн төв зам дагаж явах байдал ажиглагдаж байгаа бөгөөд цаашид мал тууврын замын дагуу явах зохицуулалтыг

хийхгүй бол бэлчээр ургамалжилтад үзүүлэх нөлөөлөл нь улам нэмэгдэнэ. Мөн тууврын зам нь Чингэлийн голыг даган явж байгаа учир усны эрэг орчмын бүсэд оруулахгүй байх арга хэмжээг авах хэрэгтэй. Боломжгүй бол удаан хугацаагаар энэ хэсэгт бэлчээрлүүлэхгүй байх бодлогыг баримтлах ёстой.

4.1.1.5. Бэлчээрийн газрыг нөхөн сэргээх:

Нийт бэлчээрийн 2.3 хувь буюу 2017 га газар нь их талхлагдалд орсон учир ашиглалтаас түр чөлөөлж сэргээн сайжруулах шаардлагатай. Энэ бэлчээрийг наад зах нь 2-3 жил ашиглахгүй байгалийн аясаар нөхөн сэргээх эсвэл бордох зэрэг бусад аргыг ашиглан сэргээх шаардлагатай.

Энэ бэлчээрт төв засмал зам дагуух газар, Жаргалант сумын төв орчмын бэлчээр орно. Харин Баян-Өндөр сумын нутагт нийтдээ хот суурин, үйлдвэр уурхайн газарт хамрагдах боловч тэдгээрийн ойр орчмын 6855.8 га газар оршин суугчдынмалыг бэлчээрлүүлэхэд ашиглагдаж байна. Гэвч эдгээр нь нийтийн эзэмшлийн газар тул үүнийг бэлчээрт оруулж тооцоогүй бөгөөд цаашид хот орчмын газрын даацад тохирсон малыг байршуулах нь зохистой

4.1.2. Хадлангийн газрын менежмент

Орхон аймгийн хэмжээнд хадлангийн талбай 1286.2 га талбайг эзлэх бөгөөд эндээс жилд 11.5 мян тонн өвс бэлтгэх боломжтой. Аймгийн хэмжээнд 2003 онд нийт 13.5 мян.тонн хадлан бэлтгэсэн бөгөөд дээрх хадлангийн хэмжээ нь нийт бэлтгэх хадлангийн хэмжээнд хүрэхгүй байна. Өөрөөр хэлбэл жилд бэлтгэдэг өвсний 85.1 хувьтай тэнцэж байна. Цаашид хадаж болох бэлчээрийн 1247.7 га талбайгаас жилд дунджаар 6 мян. тонн өвс бэлтгэнэ гэж үзэхэд аймгийн хэмжээнд жилд 17.5 мян. тонн хадлан бэлтгэх боломжтой.

Орхон аймгийн хэмжээнд байгаа хадлангийн 2 том талбайг эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлж ашиглуулах бодлого баримтлах нь зүйтэй. Эдгээр хадлан нь хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүсэд ойр байрлах учир газар нутгийн байрлалын хувьд тохиромжтой.

Цаашид ургамлан нөмрөгийн хэв шинжийн хувьд тохиромжтой зарим бэлчээрийг хадаж болох бэлчээрээр төлөвлөсөн. /Хүснэгт 32/

Хүснэгт 32. Хадаж болох бэлчээрийн газрын тэжээлийн нөөц, хэмжээ

Индекс	Ургамлын хэв шинж	Дундаж ургац (ц/га)	Талбай /га/	Тэжээлийн нөөц /мян.тн/
26	Зүр өвс-хялганат	4.7	225.5	1.1
28	Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст	4.3	506	2.1
30	Сөөг бүхий алаг өвс-үетэнт	5.4	516.2	2.8
	Дүн	14.4	1247.7	6.0

Төлөвлөж буй хадлангийн талбайг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын болон орон нутгийн эзэмшилд байхаар төлөвлөв.

4.1.3.Тариалангийн газрын менежмент

Орхон аймгийн хувьд газар тариалангийн үйлдвэрлэлийн гол бүс нутаг нь Жаргалант сумын нутагт Хангалын голын сав болон Жаргалантын хөндийд тархсан. Одоо нийт тариалалт хийдэг 5577.1 га талбайгаас 5348.2 га буюу 95.9 хувьд тариалан эрхэлж, 105.8 га буюу 2 хувьд өрхийн жижиг тариалалт явуулж байна. Үлдсэн талбай буюу 123.1 га талбайг атаршуулах шаардлагатай гэж үзэж атаршуулахаар төлөвлөсөн. Тариалангийн газрыг хөрсний шимт чанараар нь ангилан үзвэл дараахи байдалтай байна. /Хүснэгт 33/

Хүснэгт 33. Тариаланд ашиглаж буй болон ашиглаж болох газрын хэмжээ ба чанар

Д/д	Тариалангийн хэлбэр	Талбай /га/	Агроүйлдвэрлэлийн чанар		
			Тариаланд тохиромжтой сайн чанарын хөрстэй газар /Агрогрупп I/	Тариаланд тохиромжтой дунд чанарын хөрстэй газар Агрогрупп II	Тариаланд тохиромжтой доод чанарын хөрстэй газар Агрогрупп III
1	Тариалан	5348.2	1501.3	3209.6	637.3
2	Өрхийн тариалан	105.8	77.9	13.5	14.4
3	Атаршуулах талбай	123.1	22.7	100.4	-
4	Атар	230.2	152.0	78.2	-
	Дүн	5807.1	1753.7	3401.7	651.7

Нийт тариалангийн талбайн хувьд агроүйлдвэрлэлийн I группын хөрс 1753.7 га буюу 30.2 хувь, II группын хөрс 3401.7 га буюу 58.6 хувь, III группын хөрс 651.9 га буюу 11.2 хувийг эзэлнэ. /Хүснэгт 34/

Хүснэгт 34. Тариалангийн газрын менежментийн бүсүүд

Д/д	Газрын нэр	Контурын дугаар	Талбай /га/	үүнээс			Тайлбар
				Агро групп I	Агро групп II	Агро групп III	
Газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл эрхлэх бүс							
1	Жаргалантын хөндий	1,2,3,4,5,6	478.9	417.6	61.3		Үр тариа
2	Харганатын энгэрийн зүүн хажуу	43-46,56-59 67,69,73-75 77,79-82	703.0	10.8	692.2		Үр тариа
3	Хөшөөтийн хөндий	51,53-55, 62-66 83-96	1746.2	520.4	588.3	637.5	Үр тариа
4	Хангалын голын савд	18- 23,36,47-50 52,58,60,61 68,70,71,76 78	949.5	147.4	802.1		Төмс, хүнсний ногоо
5	Хангалын голын сав /голоос хойш/	72	24.2	24.2			3 га-д жимс жимс гэнэ, 19.2 га-д төмс, хүнсний ногоо

Газар тариаланг МАА-тай хослуулан эрхлэх бүс							
7	Ар хөндий	14-17, 24-31,34,35, 37-42	1291.9	380.7	911.2		Тэжээл
8	Хавчин, Нарангийн булаг орчим	7,8,9,10,11, 12,13	154.5		154.5		Тэжээл
Өрхийн тариалан эрхлэх бүс							
9	Баянцагааны эх		3.1			3.1	Хүнсний ногоо
10	Говилын хөндий		8.7	1.0		7.7	Хүнсний ногоо
11	Шар чулуутын хоолой		43.5	43.3			Хүнсний ногоо
12	Согоотын даваа		28.9	26.9	2.0		Хүнсний ногоо
13	Ар булгийн овоо, Хутаг өндөр орчим		14.6	4.0	5.0	5.6	Хүнсний ногоо
14	Даристын ам		7.0	3.8	3.2		Хүнсний ногоо
15	Тариаланд тохиромжтой атар газар		230.2	152.0	78.2		Хүнсний ногоо
	Дүн		5684.2	1732.1	3298	653.9	

4.1.3.1. Газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл эрхлэх бүсийн менежмент

Тариалангийн газрын менежментийн хувьд газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл эрхлэх бүсийг Жаргалант сумын төв орчмын талбайнуудад явуулахад тохиромжтой. Энэ бүс нь уулын хар хүрэн ба хүрэн, шавранцар хүрэн хөрстэй гадаргын хувьд нугархаг хээрийн дундаж ба нам уулс-уулс хоорондын тэгшивтэр хөндий, уулс хоорондын тэгшивтэр ба долгиорхог хөндий, ухаа гүвээт талд оршино. Дээрх хүснэгтээс харахад энэ бүс нутгийн хувьд талбайн ихэнх хэсэгт нь агро үйлдвэрлэлийн I зэрэглэлийн хөрс буюу бараан болон нугын, хар хүрэн, зузаан хүрэн, дунд зэргийн зузаан, нимгэн хар хүрэн хөрс, агро үйлдвэрлэлийн II зэрэглэлийн хөрс буюу дунд зэргийн зузаан, дунд зэргийн үйрмэг чулуутай, мөн нимгэн үйрмэг чулуутай хүрэн хөрстэй бүрдэл, хөнгөн шавранцар хөрс давамгайлан тархаж, агро үйлдвэрлэлийн III группын хөрс буюу дунд зэргийн зузаан хүрэн, хөнгөн шавранцар хөрс, нимгэн хүрэн хөнгөн шавранцар хөрс багахан талбайд тархсан байна. Энэ 3 төрлийн хөрс нь тариаланд тохиромжтой хөрс бөгөөд агро үйлдвэрлэлийн I группын хөрсөнд нутагшсан сортын үр тариа, II группын хөрсөнд үр тариа, тэжээлийн ургамал, III группын хөрсөнд үр тариа тариалахад тохиромжтой. Иймээс энэ бүсэд орших талбайнуудыг үр тарианы аж ахуй эрхлэх аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд эзэмшүүлнэ.

Мөн энэ бүс орчмын бэлчээр нь их талхлагдсан учир ашиглалтаас бүрэн чөлөөлж байгаа учир тариалан эрхлэх үйл ажиллагааны горимд ойр орчмын бэлчээрийг талхлахгүй байх, нөхөн сэргээх үүднээс зохицуулалттай ашиглах нь зүйтэй.

4.1.3.2. Газар тариаланг мал аж ахуйтай хослуулан эрхлэх бүсийн менежмент

Энэ бүсийг Хангалын голоос урагш хэсэгт, мөн Нарангийн болон Хавчингийн булгийн орчимд төлөвлөж байгаа бөгөөд энэ хэсэг нь жижиг жижиг талбайнууд ихтэй учир МАА-тай хослуулан өрх айл дангаар эсвэл хоршсон хэлбэрээр тариалан эрхлэх боломжтой гэж үзэж энэ бүсийг энэ хэсэгт төлөвлөсөн. Хөрсний бүтцийн хувьд агро үйлдвэрлэлийн II болон III группын хөрс давамгайлах учир үр тариа болон далд хөрсний ногоо, жимс жимсгэнэ тариалах боломжтой. Ялангуяа Хангалын голыг түшиглэн усалгааны систем төвлөрүүлж жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжих нь зүйтэй.

Хавчингийн болон Нарангийн булгийн орчим дахь талбайнуудад тэжээл тариалж буй хуучин тариалалтыг дэмжиж ойр орчмын эрчимжсэн фермерийн аж ахуйнуудад уялдсан үйл ажиллагааг эрхлэх нь зүйтэй гэсэн үүднээс энэ орчимд газар тариалан, МАА-г хослуулан эрхлэх бүсийг төлөвлөсөн.

Дээрх бүсүүд нь хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшлын бүсэд байрлах учир тариалангийн талбайд мал орох, бэлчээрлэхгүй байхаар зохион байгуулагдсан. Энэ талын зохицуулалтыг фермерийн эзэддэд хариуцлага ногдуулах байдлаар зохицуулах нь зүйтэй.

4.1.3.3. Өрхийн тариалангийн бүсийн менежмент

Өрхийн тариалангийн бүс нь аймгийн хэмжээнд хэсэгчлэн ашиглахаар төлөвлөсөн бөгөөд хүн амын суурьшил дагаж энэ бүс нь хөгжинө. Баянцагааны эх болон Говилын голын хөндий, Согоотын давааны өврийн хэсэг, Ар булгийн орчимд, Хутаг Өндөр уулын ар, Даристын амны талбайнуудад өрхийн тариалан эрхлэх нь тохиромжтой. Эдгээр газруудад жижиг суурьшил бий болж байгаа бөгөөд энд голчлон бага хэмжээний малтай өрхүүд өрхийн хэрэгцээний хүнсний ногоо тариална. Өрхийн тариалангийн талбайнууд нь хэсэгчлэн бага хэмжээгээр зохион байгуулагдсан учир хөрсний хувьд голчлон агро үйлдвэрлэлийн I группын хөрс зонхилно.

4.1.3.4. Атаршуулах газар

Газар тариалангийн зориулалтаар хагалагдсан газруудын хөрсний үржил шим харьцангуй сайн бөгөөд цаашид ашиглахад бүрэн тохиромжтой байна. Гэвч улсын тусгай хэрэгцээний зориулалтаар 123.1 га тариалангийн газрыг атаршуулах шаардлагатай байна. Үүний 26.0 га нь төмөр замын аюулгүйн бүсэд орсон учир төмөр замыг осол сүйрлээс хамгаалах, орчинд учирч болох хохирлыг багасгах зорилгоор ойн зурвас байгуулах, том оврын барилга байгууламж барих боломжгүй юм.

Мөн Жаргалант сумын төв өргөжин тэлж байгаагаар холбогдуулан сумын төвийн урд болон зүүн хойно байгаа ашигладаггүй гурван талбайг атаршуулж суурьшлын бүс болгох орон нутгийн саналыг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгалаа.

4.1.3.5. Газар тариаланд ашиглаж болох атар газар:

Аймгийн хэмжээнд тариаланд тохиромжтой 230,2 га газар төлөвлөгдсний 152 га нь агро үйлдвэрлэлийн I группын хөрстэй, үлдсэн 78.2 га нь агро үйлдвэрлэлийн II группын хөрстэй байна. Эдгээр газрууд нь энд тэнд хэсэгчилсэн байдлаар тархсан бөгөөд эдгээрийг өрхийн хэрэгцээнд ашиглуулах юм. Харин газар тариаланг МАА-тай хослуулан эрхлэх бүсэд одоогийн тариалангийн талбайг сунгах замаар атар газраас нэмж оруулах боломжтой. Жишээ нь: 18-р талбайд 23.0 га, 49-р талбайд 45.4 га, 50- талбайд 24.7 га, 52-р талбайд 9.8 га, 72-р талбайд 3.5 га, 78-р талбайд 16.3 га газрыг тус тус атраас тариалангийн газарт шилжүүлж болох юм. Эдгээр газрууд нь голчлон агро үйлдвэрлэлийн II группын хөрс буюу тариаланд тохиромжтой дунд чанарын хөрстэй бөгөөд үүнд дунд зэргийн зузаан, дунд зэргийн зузаан үйрмэг чулуутай, мөн нимгэн үйрмэг чулуутай хүрэн хөнгөн шавранцар хөрс багтана. Энэ хөрсөнд үр тариа, тэжээлийн ургамал, төрөл бүрийн хүнсний ногоо тариалах боломжтой.

4.2. Хотын болон суурьшсан газрын менежментийн бүсүүд

4.2.1. Хотын функциональ бүсийн онцлог

Газар ашиглалтыг оновчтой болгох зорилгоор Эрдэнэт хотын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан суурьшлын тэг гортиг доторхи нутаг дэвсгэрийг хотын функциональ бүсүүдэд төрөлжүүлэн ангилав. Эрдэнэт хотод дараах функциональ бүсүүд байхаар төлөвлөлөө. / Зураг / Үүнд :

А. Амины орон сууцны бүс. Хотын зүүн хойт хэсэг IV, V микрорайоноос хойшхи газрыг ОХУ-ын консулын газар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг үлдээн бусад талбайг иргэдэд орон сууц барих зорилгоор олгоно. 1-3 давхар амины тохилог орон сууц нь өрх бүрийн газар тусдаа жижиг хайсаар тусгаарлагдсан зэрэгцээ эгнээ маягаар төлөвлөгдөх нь зүйтэй болов уу.

Б. Нийтийн орон сууцны бүс. Одоо байгаа хотын орон сууцны I,II,III,IV,V,VI микрорайоноос гадна Хот төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр баригдаж байгаа болон барихаар төлөвлөсөн VII, X микрорайонуудыг энэ бүсэд хамруулан төлөвлөв. Эдгээр хорооллын төлөвлөлт нь хот төлөвлөлт, архитектурын төслийн дагуу явах юм.

В. Гэр хорооллын бүс . Энэ бүс нь өнөөгийн гэр хорооллын нутаг дэвсгэр болон шинээр өмчлөлд олгохоор төлөвлөгдсөн шаардлагатай талбайн хэмжээг бодолцон баруун хойш, баруун тийш Баян Өндөр уулын хамгаалалтын хил, аймгийн хил хүртэл, өмнө тийш Бүрэн бүстийн овооны урд хэсэгийн өрхийн суурьшлийн бүс хүртэл, зүүн урагш Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрт олгогдсон талбайг хотоос зааглан хамгаалан ойн ногоон бүс байхаар төлөвлөсөн. Гэр хорооллын бүсийг төлөвлөхөд зайлшгүй анхаарах нэг зүйл нь зам, шугам сүлжээ, эмнэлэг , сургууль, цэцэрлэг, нийтийн үйлчилгээний газруудыг барих талбайг газар олгохдоо тусад нь салган үлдээж хамгаалах асуудал юм.

Г. Нийтийн үйлчилгээний цогцолборуудын бүсийг олон нийтэд хүрч үйлчлэхэд хялбар дөт буюу “бүгдийг нэг дороос” гэсэн үндсэн зарчимд тулгуурлан хотын төв замын дагуу зохион байгуулав. Нийтийн үйлчилгээнд төрийн болон худалдаа-үйлчилгээний байгууллагуудын эзэмшил газрууд хамруулав. Төрийн үйлчилгээний байгууллагад аймаг, сумын орон нутгийн захиргааны байгууллагуудыг оруулж, худалдаа-үйлчилгээнд дэлгүүр, нийтийн хоолны газар, интернет кафе, бар, ресторан г.м үйлчилгээний байгууллагуудын газрыг хамрууллаа. Мөн хүнсний болон барааны зах, автовокзал хавийн газар хамрагдсан. хүн амд үзүүлэх зах зээлийн хувьд хотын төв зам, нийтийн тээврийн буудал, томоохон хорооллын дагуу байрлана.

Д. Спорт амралтын бүс нь спортын ордон, хөл бөмбөгийн талбай, морин тойруулга, наадмын талбайг хамарч одоо байгаа талбайн гадуур ногоон байгууламж тариж хамгаалсан байхаар бодож бүсийн хилийг гаргасан.

Е. Ногоон бүс. Хотын хүн амын эрүүл ахуйд онцгой ач холбогдолтой энэ бүсийг хотын төв хэсэг, баруун өмнө хэсэгт цэцэрлэгт хүрээлэнгийн архитектурын зохиомжоор болон Баян Өндөр уулын ойг тэр хэвээр, ашигт малтмалын олборлолтын орд /хиймэл уул/ газрыг хотоос тусгаарласан ногоон бүс байгуулахаар хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тусгав.

Ж. Үйлдвэрийн бүс. Энэ бүсийг Эрдэнэт хотоос зүүн тийш Говилын хэсэг, уулын баяжуулах үйлдвэрт олгогдсон талбайг хамруулан одоогийн байгаа барилга байгууламжийн байрлалаар нь бүс болгов. Үйлдвэрийн газарууд нь хотын суурьшлын тэг гортигоос гадна байхаар төлөвлөх нь хүн амын эрүүл, аюулгүй байдалд ихээхэн ач холбогдолтойг анхаарч цаашид үйлдвэр, уурхайн зориулалтаар газар олгохдоо төлөвлөсөн бүсийн дотор олгож байх нь зүйтэй юм.

З. Эрүүл мэнд, соёл, боловсролын бүс. Эрдэнэт хотын их дээд сургуулиудын салбар, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эмнэлэгийн газрыг тус тусад нь бүс болгон хамгаалж бусад ашиглалтанд олгохгүй байхаар төлөвлөсөн.

И. Хот суурины дэд бүтцийн бүсэд төмөр замын вокзал, нисэх онгоцны буудлын нутаг дэвсгэр хамарна.

К. Жимс ногооны цэцэрлэгийн бүс. Хотын баруун өмнө хэсэгт байгаа тариан талбай, мод үржүүлгийн талбай, атаршсан газрыг ашиглан далд хөрсний ногоо, жимс жимсгэнэ тарих зорилгоор иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх газрыг төлөвлөсөн. Хүн ам нягт суурьшсан хот сууринд задгай талбай хагалж шороо тоос босох, талбай бохирдохоос сэргийлж ихэвчлэн хүлэмжийн болон цэцэрлэгийн аж ахуй эрхлэнэ.

Л. Өрхийн мал аж ахуйн бүс. Говилын тосгоны хойд хэсэг, Урт булаг, Бүрэн бүстийн овооны өмнө хэсэгт саалийн үнээний болон зөгий, гахай, тахианы аж ахуйн зориулалтаар газар олгоно.

М. Батлан хамгаалах аюулгүй байдлыг хангах бүс. Говилын тосгоны хойд хэсэгт байрлах объектуудыг хамруулж гаргасан.

4.2.2. Хот өргөжин тэлэх бүс

Эрдэнэт хотыг хүн амын өсөлт, газар өмчлөлийн үйл ажиллагаатай холбогдуулан одоогийн байгаа суурьшлын тэг гортигоос гадагш дараах байдлаар тэлэхээр төлөвлөв. / Зураг /

Хотын гэр хорооллыг хойд тал руу Баян Өндөр уулын хамгаалалтын хил, баруун тал руу аймгийн хил, баруун урд тал руу Бүрэн бүстийн овоо хүртэл тэлэх. Орон сууцны хорооллыг шинээр Х,ХI, VII хороолол болгон төлөвлөгдсөн газарт, Говилын тосгон, Урт булаг, Баян цагаан орчмоор хүн амыг суурьшуулах, Жаргалант сумын төвийн хойд, өмнө, Далангийн хэсэг, төв замын дагуу нарийн зурвас газар, төмөр замын ажилчдын тосгон, хуучин үтрэмийн суурингуудыг өргөтгөн тосгоны нутаг дэвсгэрийг тэлнэ.

4.2.3. Дагуул хот

Орхон аймгийн хувьд Жаргалант сумыг Эрдэнэт хотын дагуул хот болгон хөгжүүлэх зүйтэй. Жаргалант сумын хувьд дэд бүтцийн хувьд сайн хөгжсөн. Нийслэл болон аймгийн төвтэй сайжруулсан улсын чанартай авто зам болон төмөр замаар бүрэн холбогдсон. Зам дагасан хөгжил нэгэнт бий болсон. Төвийн эрчим хүчний сүлжээнд бүрэн холбогдсон, эрчимжсэн МАА болон газар тариалангийн үйлдвэрлэлийг улам бүр хөгжүүлж, Эрдэнэт хотын хүн амын ХАА-н гаралтай бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангадаг байхаар төлөвлөгдөх ёстой.

Жаргалант сумын төвийг нутаг дэвсгэрийн хувьд өргөтгөн тэлэхээс гадна сүүний эрчимжсэн аж ахуйн бүс, өрхийн суурьшлын аж ахуйн бүс / далангийн ойролцоо/-ийг гахай тахианы аж ахуйн зориулалтаар олгох, төв зам дагуу үйлчилгээний цэгүүдийг байгуулах, төмөр замын ажилчдын тосгон байрууд болон хуучин үтрэмийг өргөтгөн үйлдвэрийн бүс болгохоор төлөвлөсөн бөгөөд үүнтэй уялдуулан дагуул хотын ерөнхий төлөвлөгөө хийх шаардлагатай.

4.2.4. Хүн амын социаль нөхөн сэргээлтийн бүс

Нутаг дэвсгэрийн ихээхэн хязгаарлагдмал орон зайд байрлах Орхон аймгийн хувьд хүн амын социаль нөхөн сэргээлтийн бүс төлөвлөх асуудал нилээд хүндрэлтэй бөгөөд газар зохион байгуулалтын үүднээс энэ бүсэд нийтийн амралт, аялал зугаалгын бүс, хог хаягдал, оршуулгын газар, уламжлалт ёс, заншил, түүх соёлын өвийг хадгалан хамгаалах газруудыг оруулан үздэг.

Амралт, аялал зугаалгын бүс:

Хүнд үйлдвэрлэл хөгжсөн Эрдэнэт хотын экологийн өнөөгийн байдал хүн амын эрүүл мэндэд төдийлөн таатай нөлөө үзүүлэхгүй байгаагаас үйлдвэрийн хүнд хүчир ажилд алжаасан ажиллагсдыг янз бүрийн хугацаанд байгалийн сайханд амраах замаар эрүүл мэндийг дэмжих бодлого зайлшгүй чухал болоод байна.

Амралт аялал зугаалгын бүс нь ландшафтын үзэсгэлэнт байдлаасаа гадна оршин суугчдад аль болох ойр, хүрч очиход төхөмтэй газарт байрласан байх шаардлагатай.

Орхон аймаг болон Булган аймгийн хил залгаа нутагт орших Бүрэн бүстийн амралтын газраас өөр амралтын газар тус аймагт байхгүй юм.

Ландшафтын үзэсгэлэнт байдлыг нь харгалзан Согоотын нурууны орчимд 2711.9 га газрыг нийтийн амралт, зугаалга, явган аяллын бүс болгох боломжтой бөгөөд харин Дарист болон Пинт уулын аманд амралтын газар байгуулахаар төлөвлөв.

Суурьшмал амьдралын улмаас аль ч хотод байдаг тулгамдсан асуудлын нэг нь хатуу хог хаягдал бөгөөд тус аймгийн Баян Өндөр сумын нутагт 2 хэсэг, Жаргалант сумын нутагт 1 хогийн цэгийн байршил тогтоон ашиглаж байна. Жаргалант сумын нутагт байгаа сумын төвөөс урагш байрласан хогийн цэг нь карьерын дэргэд байдаг. Энэ карьерын нөөц, ашиглалт дуусахад хүнхээл ухмалыг ашиглан хог булшлах цэг болгоход тохиромжтой учир хогийн цэгийг энэ хэсэгт өргөтгөх боломжтой.

Баян Өндөр сумын хувьд хогийн цэгүүд нь үйлдвэрийн бүсэд байрладаг. Энэ бүсэд үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас үүссэн ухмал нүхнүүд ихтэй. Томоохон ухмалыг хог булшлах төвлөрсөн цэг болгон ашиглах нь зүйтэй.

Харин хогийг цуглуулан төвлөрсөн цэгт хүргэх, ангилан боловсруулах ажиллагаанд оршин суугчдын хариуцлагагүйн улмаас хүндрэл учирч энд тэнд хур хог нилээд байна. Хогийн цэгийг шинээр байгуулахад нутаг дэвсгэрийн хүрэлцээ байхгүй тул хогийг боловсруулах үйлдвэрийг нэн яаралтай байгуулж боловсруулах, харин боломжгүй хогийг уурхайн үйл ажиллагаанаас үлдсэн ухмалуудад хийж дарахад анхаарах хэрэгтэй. Мөн хог боловсруулалт болон булаах ажиллагааг үйлдвэрлэлийн өдөр тутмын ажиллагаанд саад болохооргүй байхаар зохицуулах нь зүйтэй.

Нас барагсдыг оршуулах 3 цэг байгаагийн нэг нь Булган аймгийн нутагт, 2 нь Жаргалант сумын нутагт байна. Энэ хоёр цэгт Баян Өндөр сумаас хүрч очиход орон зайн хувьд холдож байгаа учир тус сумын оршуулгын газрыг аймаг хоорондын газар зохион байгуулалтаар шийдэх нь зүйтэй. Харин Орхон аймгийн хувьд өргөтгөж болох оршуулгын цэгийг Сарлагт уулын баруун урд энгэрт төлөвлөсөн ба талбайг 75.4 га-аар нэмэгдүүлэх боломж байна.

Гэвч хүн амын өсөлт жилээс жилд нэмэгдэж нас нөгцөгсдийг оршуулах газар улам бүр хомсдож болохыг харгалзан нас барагсдыг оршуулах асуудлыг Монгол Улсад нэгэнт хэрэгжээд эхэлсэн чандарлуулах ажиллагаанд шилжүүлэх

нь зүйтэй бөгөөд үүнд монгол ёс заншил, жаягийг харгалзан Эрдэнэтийн уурхайн бүсэд нөөцийн бус газарт байршуулах боломжтой гэж үзэж байна.

4.3. Зам, шугам сүлжээний газрын менежмент

Газрын менежментийн бодлогод зам шугам сүлжээний газарт үйлдвэрлэл-технологийнх нь онцлогийн дагуу олгосон дэвсгэр болон зурвас газраас гадна хүрээлэн буй орчны таагүй нөлөөллөөс хамгаалахад зориулан хамгаалалтын зурвас гаргаж өгөх шаардлага гардаг. Гэхдээ эдгээр хамгаалалтын зурвас нь тус тусын ангилал, зориулалтын газарт хамаарагдах ба түүн дээр зориулалтын бус үйл ажиллагаа явуулахыг бүрмөсөн хориглодог онцлогтой.

Төмөр замын газар нь төмөр замын зурвас газар болон аюулгүйн буюу хамгаалалтын бүсийн газраас тогтдог. Төмөр замын зурвас газрын өргөн нь төмөр замын өртөөнүүдийн хоорондох замд 120 метр, өртөөнүүд дээр 300 метр, зарим шаардлагатай газарт төмөр замын аюулгүйн бүсийг 500 метр хүртэл өргөнтэй тогтоодог бөгөөд үүнийг зам шугам сүлжээний менежментийн зурагт тусгалаа.

Автозамын газарт нийслэлийг аймгийн төвүүдтэй, аймгийн төвүүийг өөр хооронд нь холбодог замд 100 метр, засаг захиргааны нэг нэгжийн нутаг дэвсгэрт оршин буй хот тосгон, суурин газрыг холбон буй орон нутгийн чанартай замын дагуу 60 метр өргөнтэй зурвас газрыг тогтоодог.

Эрчим хүч, харилцаа холбооны шугам сүлжээний газарт 220 кв-ын шугмын дагуу 110 метр өргөнтэй хамгаалалтын зурвас тогтоож, хот суурины дотор хамгаалалтын зурвасын өргөнийг 14-28 м хүртэл багасган төлөвлөв.

Тус аймгийн онцлогийг харгалзан үйлдвэрийн хаягдлыг зөөвөрлөж хиймэл нуурт хүрдэг суваг шуудуу, далангийн орчимд аюулгүй байдлыг хангах үүднээс 30-40 метрийн өргөнтэй зурвасыг тогтоолоо.

Аймгийн хэмжээнд зам, шугам сүлжээний дэвсгэр газрын хэмжээ 4888.8 га бөгөөд агаарын тээврийн буудлын газар 77.8 га байна. Аймгийг нийслэл болон бусад томоохон хотуудтай сайн чанарын замаар холбогдсон боловч сум ба суурин хоорондын хээрийн шороон замуудыг хөдөө аж ахуйн эрчимжилттэй уялдуулан сайжруулах зайлшгүй шаардлага гарч ирж байна. Ойрын үед Булган-Мөрөнгийн чиглэлийн замыг хатуу хучилттай болгох, мөн энэ чиглэлд төмөр замыг сунгах ба энэ замын 14.4 км нь тус аймгийн нутаг дэвсгэрээр өнгөрнө. Үүнээс шалтгаалан ойрын үед зам шугам сүлжээний газарт нийт 432.1 га-гаар нэмэгдэх юм. /Зураг /

4.4. Ойн сангийн газрын менежмент

Газрын тухай хуулийн дагуу ойн сан бүхий газарт ой мод, загтай газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас болон ойг өсгөн үржүүлэхэд зориулсан газар, мөн ой тэлэн ургах боломжийг хангахуйц ойн захын тодорхой

хэсгийг хамуулав. Мөн Ойн тухай хуульд “Ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн захаас гадагш 100 метр хүртэлх өргөнтэй зурвас газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай зэрэг нь ойн санд багтдаг” гэжээ.

Дээрх тодорхойлолтын дагуу бүртгэгдсэн ой бүхий газар 15503.0 га, ойн цоорхой 1349.9 га, ойгоос 100 метр хүртэлх өргөн газар 6617.6 га. Нийт ойн сангийн газрын нийт талбай нь 23470.5 га газар байна. Аймгийн хэмжээнд мод үржүүлгийн талбайг Бортын аманд 5.9 га талбайд төлөвлөв.

Усан сангийн газрын менежментэд гол горхины эх, нуурын эргэн тойрны 5 км доторхи, голын эргээс хоёр тийш урсгалын дагуу, булаг шандын тархины эргэн тойрны 3 км доторхи ойг хориотой зурвасын ойд тооцож ойг арчлах, тордохоос өөр зориулалтаар мод огтлохыг хуулиар хориглодог бөгөөд энэ нь хөрсийг усны эвдрэлээс хамгаалах, газрын доорхи болон гадаргуугийн усны тэнцлийг хадгалахад чухал үүрэгтэй гэж үздэг. Энэ бодлогын дагуу Уртын нурууны орчим Уртын гол, Уртын булаг бусад жижиг булгийн эхийг хамгаалах зорилгоор хориотой бүсийн ойг тогтоосон. /Зураг /

Ойн өрөөсгөл хүр эрвээхэйн өндөг ихээр тархсан газруудад устгал хийх, аль болох ойгоос их хэмжээгээр мод огтлохгүй байх нь чухал. Мөн ойн орчимд амьдарч байгаа малчид ойн сан бүхий газарт хамаардаг ойн захаас 100 метр хүртэлх зай, ойн цоорхой зэрэг газарт малаа бэлчээж, хадлан бэлтгэж байгаа нь ой мод байгалийн жамаар үрээ хаяж, нөхөн төлжих боломжийг нь ямар нэг хэмжээгээр алдагдуулдаг учир энэ газарт мөрдөх тусгай дэглэмийг шинээр боловсруулах хэрэгтэй.

Баян Өндөр, Согоотын нурууны орчимд орон нутгийн тусгай хамгаалалттай газар орших бөгөөд энэ хэсгийн ой нь тусгай хамгаалалттай газар нутгийн ойд хамаарах учир энэ хэсгийн ойд ямар нэг аж ахуйн болон бусад үйл ажиллагаа явуулахгүй байх бодлого баримтлах нь зүйтэй. Энд ойг арчлах тордохоос өөр үйл ажиллагаа явуулахгүй, мод огтлохыг хязгаарлах, бүр хориглох хүртэл арга хэмжээ авах хэрэгтэй.

4.5. Усан сангийн газрын менежмент

Усан сан бүхий газарт гадаргуугийн усны эзэлж байгаа газар, мөнх цас, мөсөн гол, түүнчлэн усны нөөц чанарыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай усны эрэг орчмын /усны хөвөө/ зурвас газар багтдаг. Олон улсын жишгээр бол нуур, гол горхины эргийн дагуу 50 метр өргөнтэй, усархаг намгархаг газрын эргэн тойрны 100 метр өргөн зурвас газрыг усны эрэг орчмын бүс гэж зарлан түүн дээр усны нөөц, чанарт нөлөөлж болох аливаа үйл ажиллагаанд чанга хяналт тавьдагаас гадна энэ зурвас газарт газар хагалах, барилга байгууламж барих, орчны нөхцөл байдлыг өөрчлөх, нуур голын усанд ан амьтан чөлөөтэй хүрэх замыг алдагдуулах зэргээс аль болохоор зайлсхийдэг байна. /Зураг /

Орхон аймгийн нийт голуудын урт 194.7 км . усан сан бүхий газрын нийт талбай 3152.8 га. Аймгийн хэмжээнд усан сан бүхий газрын ашиглалт хамгаалалтын 2 бүсийг төлөвлөсөн. Үүнд:

4.5.1. Усны эрэг орчмын бүс:

Орхон аймгийн хувьд аймгийн хэмжээнд байгаа голуудын ихэнх нь ширгэдэг бөгөөд хур тунадас ихтэй жил эсвэл хавар шар усны үеэр устай болдог голууд байдаг. Эрдэнэтийн гол, Говилын гол, Уртын гол, Хөөврийн ус гэх мэт байнгын урсгалтай болон Даристын гол, Шувуутын гол, Согоотын гол гэх мэт байнгын биш урсгалтай голуудад тус тус голуудад усны эрэг орчмын бүсийг 50 метрээр татсан. Энэ бүсийн нийт талбай 2821.5 га. Энэ бүсэд усны нөөц, чанарт нөлөөлж болох аливаа үйл ажиллагаа болон энэ зурвас газарт газар хагалах, барилга байгууламж барих, орчны нөхцөл байдлыг өөрчлөх зэрэг үйл ажиллагаа явуулахыг аль болох зайлсхийх арга хэмжээ авч энэ талын зохицуулалтыг хийх шаардлагатай.

4.5.2. Усны эрүүл ахуйн бүс:

Усан сан бүхий газрын менежментэд баримтлах гол бүсийн нэг нь усны эрүүл ахуйн бүсийг тогтоох явдал бөгөөд гол горхи, булаг шанд, худаг, усан сан нь усан хангамжийн эх үүсвэрийн үүрэг гүйцэтгэж байгаа бол тэдгээрт 100 метрээс доошгүй өргөнтэй эрүүл ахуйн бүс тогтооно гэж үздэг. Тус аймгийн хэмжээнд байгаа голуудаас хамгийн гол усан хангамжийн эх үүсвэрийн үүргийг гүйцэтгэж байгаа нь Хангалын гол юм. Усны эрүүл ахуйн бүсийн нийт талбай 331.3 га. Энэ бүсэд дээрх бүсийн нэгэн адил ашиглалтын горим баримтлах бөгөөд ундны усан хангамжийн эх үүсвэр болдог гэдэг утгаар нь энэ бүсийг эрэг орчмын бүстэй нь нэг дэглэмээр ашиглаж хамгаалах нь зүйтэй.

Гол горхи, булаг шандын эх үүсвэрийг хамгаалах, ойжуулах, ариун цэврийн бүс тогтоох талаар аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2003 оны үндсэн чиглэлд зорилт тавьж 3 булаг, рашааны эхийг тохижуулж хамгаалах ажилд 2405.8 мян. төгрөгийг байгаль хамгаалах арга хэмжээний зардлаас зарцуулжээ.

4.5.3. Эрэг орчмын газрын ашиглалт, авах арга хэмжээ:

Дээрх бүсүүдээс гадна аливаа барилга байгууламж, жуулчны бааз, хоноглох газар нуур, голын эргээс 100 метрээс холгүй газар байрлавал зохих бөгөөд зоо мал эмнэлгийн ариутгал-боловсруулалтын цэг, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах, үйлдвэрлэх газрыг усны хамгаалалтын бүсийн гадна, урсгалын доод хэсэгт байрлуулж хаягдал усыг тусгайлан цэвэрлэж зайлуулах ёстой. Мөн хориотой бүсийн ойд хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх ба гол горхины эх, нуур, тойрмын эргэн тойронд 2км дотор ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хуулиар хориглосон.

Зуны голыг бүрэн хааж үйлдвэрийн хаягдлыг хийх хиймэл нуурыг байгуулснаар нуурын бохир ус нь Зуны голын хуучин сайрыг дагаж Эрдэнэтийн болон Хангалын гол орох боломжтой юм. Иймээс энэ хэсэгт цэвэрлэх байгууламж эсвэл далан байгуулж усыг давхар цэвэршүүлснээр дээрх голуудыг бохирдлоос хамгаалах нөхцөл бүрдэнэ.

4.6. Газрын хэвлий нөөцийн менежмент

Газрын хэвлийг ашиглах нь улсын эдийн засгийн хөгжилд зайлшгүй шаардлагатай боловч үүнээс байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөөлөл гардаг. Харин түүний нөлөөллийн цар хэмжээ олборлолтын технологиос шалтгаалан харилцан өөр өөр байдаг.

Газрын хэвлийг нээхэд хорт хий агаарт гарахаас гадна хүдрийн олборлолтонд олон тооны хүнд механизмууд оролцдог. 7 хоногт 1-ээс доошгүй удаа газрыг дэлбэлдэг. Эдгээрийн үр дүнд агаарт их хэмжээний тоосонцорын үүл тогтдог. Мөн Эрдэнэт үйлдвэрийн технологийн дагуу 1 тонн зэсийн баяжмалыг гаргахад 50 тн хаягдал гарч хаягдлын аж ахуйн талбайд задгай хадгалдаж байна. Сүүлийн 10 жилд тус үйлдвэр нь үйлдвэрлэлийн технологио өөрчлөн зэсийг исэлдэн ангижруулах замаар гарган авч байгаа нь түрүүний аргыг бодвол харьцангуй дэвшилттэй боловч их хэмжээний химийн исэлдүүлэгчийг ашиглаж байгаа нь агаар дахь хүхрийн хүчлийн агууламжийг нэмэгдүүлж орчныг бохирдуулж байна.

Үйлдвэрлэлийн технологийн дагуу тус үйлдвэр нь газрыг үндсэн 3 зориулалтаар ашиглож байна. Үүнд:

- Хаягдлын талбай
- Агуулахын хэсэг
- Үйлдвэр уурхайн талбай

4.6.1. Хаягдлын аж ахуй, цэвэрлэх байгууламж :

Энэ хэсэгт хиймэл нуур болон түүн лүү орсон далан, хоолой суваг зэрэг хиймэл нууртай холбоотой барилга байгууламжууд орж байна. Нийт талбайн хэмжээ 3299.0 га. Хаягдлын талбайн гол үүрэг нь үйлдвэрээс гарсан хаягдлыг тусгай хоолойгоор дамжуулан хиймэл нуурт зөөж агуулах явдал юм. Үйлдвэрийн хаягдлаас гаралтай цагаан тоосны дэгдэлт үүсдэг. Энэ нь тодорхой хил заагийг бий болгож байгаа. Энэ тоосны хэмжээг багасгах арга хэмжээг 2003 оноос авч байгаа бөгөөд энэ ажлын үр дүнд цагаан тоосны дэгдэлт буурч байгаа гэсэн байгаль орчны дүгнэлт гарсан боловч цаашид хүн амын эрүүл мэндэд нөлөө үзүүлэхгүй байхаар байнгын арга хэмжээ авах нь чухал асуудал болж байгаа.

4.6.2. Агуулахын хэсэг:

Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаанд байнга хэрэглэгддэг тэсрэх бодисын агуулах энэ хэсэгт байрладаг. Нийт талбайн хэмжээ 316.7 га. Энд голлон тэсрэх бодистой ажиллах горимыг сайн баримталж, эндээс тэсрэх бодис хадгалалтын горим алдагдах байдлаас болгоомжилж ажиллах нь зүйтэй. Тэсрэх бодисын агуулахаас холгүй зарим нэг өрхийн жижиг тариалангийн талбай байгаа учир энэ хэсэгт нөлөөлөхгүй байхаар зохицуулалтыг хийх хэрэгтэй.

4.6.3. Үйлдвэр уурхайн талбай:

Үйлдвэр уурхайн талбайд Эрдэнэт үйлдвэрийн гол үйлдвэрлэл, олборлолт хийгдэж байгаа газрууд хамрагдах энэ нь нийтдээ 1840.4 га газрыг эзэлнэ. Харин 727.5 га газар нь овоолгын доорхи талбай байна.

Ер нь Эрдэнэтийн зэс молибединий хүдэржилтийг бүсийг Зүүн урд талын, Дунд талын, Баруун хойд талын, Цагаан чулуут-Тал булгийн хэсэгчлэн үздэг ч эдгээрээс үйлдвэрийн ач холбогдол бүхий хэсгээр Баруун хойд талыг нь сонгосон ба гүний судалгаагаар энэ хэсгийн 905 метр хүртэл түвшинд 6730.0 мянган тонн зэс, 200.0 мянган тонн зэс молибединий нөөцтой болох нь тогтоогджээ.

Эрдэнэт үйлдвэр нь байгуулагдсанаас хойш дээр тогтоосон нөөцөөс 3600 мянган тонн зэс, 87.6 мянган тонн зэс молибединийг олборлосон ба цаашид энэ хэсэгт 35 жилийн нөөц үлдээд байгаа гэсэн тооцоо гарчээ.

4.6.4. Бусад карьер, талбай:

Орхон аймгийн хэмжээнд энд тэнд хэсэгчилсэн байдалтай нэлээд хэдэн карьерууд байгаа бөгөөд эдгээр нийт 71.2 га талбайг эзэлнэ. Эдгээр ордуудын ихэнх Баян-Өндөр сумын нутагт Эрдэнэт үйлдвэрийн орчимд байгаа бол цөөхөн хэдэн карьер Жаргалант сумын нутагт байдаг. Одоогийн байдлаар эдгээрийг нөхөн сэргээх ажил хийгдээгүй байна.

4.6.5. Уурхайн хөгжлийн хэтийн чиглэл:

Эрдэнэт үйлдвэрийн бүсэд одоо олборлож буй талбайгаас гадна цаашид ашиглах нөөцтэй 870.3 га газар байна. Үүний нэг болох Цагаанчулуутын орд нь 648.6 га талбайтай.

Сүүлийн үед хийгдэж буй газрын харилцааны шинэчлэлтийн хүрээнд Цагаанчулуутын ордын ойр орчимд тухайлбал Ар булгийн орчимд суурьшлын бүс үүсч эндэхийн айлуудад газрыг өмчлүүлж эхэлжээ. Мөн тус орд газрын баруун хэсэг орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан Баян Өндөр уулын бүсэд багтана. Иймээс уг ордыг ашиглахад эрх зүйн зохицуулалтын зарим арга хэмжээ авах шаардлагатай болжээ. Энд суурьшигсдын өмчлөлд шилжсэн газрыг хүдрийн олборлолт эхлэх үед нөхөн олговортойгоор эргүүлэн авах, түүнчлэн нэмж газар өмчлүүлэхгүй зөвхөн эзэмшүүлэх, ашиглуулах замаар газрын харилцааг зохицуулах нь зүйтэй.

Харин үлдсэн хоёр орд 221.7 га талбайтай бөгөөд одоогийн олборлолт явуулж буй нутагт ойр байрлах тул түүний ашиглалтанд нөлөөлөх зүйлгүй юм..

4.7. Тусгай хэрэгцээний ба тусгай хамгаалалттай газрын менежмент

Одоогоор аймгийн хэмжээнд орон нутгийн тусгай хамгаалалтад авсан 2 газар байгаа. Үүнээс

- Баян Өндөрийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг: Тус газар нутгийн хил цэс: Зосын даваа, Бортын ам, Ар булаг, Цагаан чулуутын даваа, Цагаан чулуутын булаг, Хүрэн булаг, Ганц модотын ам, Урт булаг, Чандагатын хөтөл, Хар модотын хөтөл, Зосын даваа хүрнэ. Газар нутгийн хэмжээ 1373.8 га.
- Хангалын голын савд буй бургасыг хамгаалахаар орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Жаргалант сумын төвөөс урагш Хангалын голын Бөөн бургас нь нийт 41.6 га газрыг эзэлдэг.

Цаашид орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар Согоотын нурууны хэсэг газрыг төлөвлөөд байгаа бөгөөд энэ хэсэг нь байгалийн тогтоц, орчны байдал нь унаган төрх нь алдагдаагүй, цаашид унаган төрхийг нь хадгалан хамгаалах үүднээс орон нутгийн тусгай хамгаалалтад авах нь зүйтэй гэж үзэж байна. Хилийн цэсийг дараах байдлаар тогтоож болох юм. Согоотын нурууны орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэс: Согоотын нурууны хойд үзүүрийн толгой, Ар булгийн овоо, түүнээс зүүн урагш явж Баян Өндөр сумын хилд хүрч сумын хилээр цааш явж Согоотын даваа, Өвөр булаг, эндээс Согоотын нурууны баруун урд талын толгой, Согоотын нурууны хойд үзүүрийн толгой. Энэ хилийн дагуу нийт 1185.1 га газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар төлөвлөв.

Эдгээр орон нутгийн тусгай хамгаалалтад орсон болон цаашид орох газар нутагт орон нутгийн тогтоосон тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын дэглэмийн дагуу ашиглаж үйл ажиллагаа явуулна.

ТАВ. ГАЗРЫН ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

5.1. Газрын экологийн чадавхи, түүний үнэлгээ

Газрын нөхцөл, нөөц, төлөв байдал, чанар нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд түүний хотгор гүдгэр, уур амьсгал, ус зүй, хөрс ба ургамлан бүрхэвч, амьтны аймаг зэрэг байгалийн хам бүрдэл хүчин зүйлсээс хамаарах учраас тодорхой орон зайн хүрээнд ижил төстэй байдлаар нэгтгэн ангилснаар газар зохион байгуулалтын үйл ажиллагааг төлөвлөх нь илүү үр ашигтай юм.

Аймгийн нийт газрын экологийн чадавхийг газар зохион байгуулалтад өргөн хэрэглэгддэг газрыг геоэкологийн ижил төстэй нөхцлөөр нь нэгтгэн ландшафт-типологийн зарчим баримтлан байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлөөр нь ангилж, анги тус бүрийн экологийн чадавхийг тодорхойлсон. Энэхүү ангилгааг дараах үндсэн шаардлагуудад нийцүүлэн хийдэг.

- 1.Газар нутгийн нэгдмэл ижил төстэй байдлыг хангах
- 2.Хэсэг бүлэг газар нутгийн нэгдмэл хэв шинжийг харуулах
- 3.Тухайн газрын ашиглах боломжийн ялгааг харуулах

Тус аймгийн нутаг дэвсгэрийн газрын экологийн чадавхийг тодорхойлон дараахи ангилгааг гаргаж, ашиглалтыг горимыг тогтоов. /Хүснэгт 35/, /Зураг 6/

Хүснэгт 35. Орхон аймгийн газрын ангилгаа

Зурагт тавих индекс	Газрын ангилал		Голлон тархах хөрсний индекс	Эзлэх талбай /мян.га/	Ашиглалтын үндсэн чиглэл
11	Ой хээрийн дундаж ба нам уулс дотоодын нугачаат хөндий	Уулын ойн ширэгт ялзмагт, глейрхэг болон уулын ойн хар бараан хөрст шилмүүс ба холимог ойт дундаж уулсын орой, ар хажуу налуу	8	19465	Экологийн байдлыг алдагдуудахгүй хадгалан хамгаалах, зэрлэг ан амьтан, сарлагийн бэлчээрт ашиглана
12		Уулын ойн цэвдэгт ба ширэгт хар бараан ба хар шороон маягийн хөрстэй сөөг бүхий өвслөг ургамалтай сийрэг ойт дундаж ба нам уулын ар, өвөр, баруун зүүн хажуу налууугийн доод хэсэг, хормой, өвөр ба баруун зүүн хажуу	8,2,1	8258.3	Биологийн төрөл зүйлийг хамгаалан аялал жуулчлал, амралт сувилал хөгжүүлэх, байгалийн дагалдах баялаг болох жимс, самар, эмийн ургамалзэрэгт мэргэжлийн хяналт дор эрчимтэй бус ашиглалтыг хангуулах
21	Нугархаг хээрийн дундаж ба нам уулс хоорондын тэгшивтэр хөндий	Уулын сулавтар хөгжилтэй хар хүрэн хөрстэй сийрэг өвслөг ургамалтай бага зэрэг сөөгтэй чулуурхаг гадаргатай дундаж ба нам уулсын орой дээд энгэр хажуу	1.3	6637.2	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээрт ашиглана
22		Уулын хар хүрэн ба хүрэн хөрстэй өвслөг ургамалтай дундаж ба нам уулсын хажуу налуу, хормой	4	7986.7	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээрт ашиглана. Уулын налуу хажуугийн доод хэсгээс тариаланд түүвэрлэн ашиглах боломжтой
23		Нугын хүрэн ба хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын нарийн ам хөндий	7	3257.4	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээрт ашиглана. Тариаланд түүвэрлэн ашиглах боломжтой
24		Шавранцар хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын тэгшивтэр хөндий	9.10.11.12	6149.2	Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой, бүх төрлийн малын бэлчээрт ашиглана. Хөрс хамгаалалтын арга хэмжээ авч хөрсний үржил шимийг тэтгэх, усны горимыг тохируулах
31	Уулс хоорондын	Уулын хүрэн ба сул хөгжилтэй хүрэн хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг гадаргатай дундаж ба нам уулын орой, хажуу налуу	5.6	8684	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээрт ашиглана

32		Шавранцар хүрэн, заримдаа хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын ухаа гүвээт долгиорхог өргөн хөндий	13.14.15.1 6.17.18.19	23003	Газар тариалангийн үйдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой, бүх төрлийн малын бэлчээрт ашиглана. Хөрс хамгаалалтын арга хэмжээ авч хөрсний үржил шимийг тэтгэх, усны горимыг тохируулах
41	Бус дундын голын хөндий болон гадапш урсгалгүй, нам хотсууд	Голын хөндийн аллювийн нуганамгийн хөрстэй гидрофит ургамал бүхий нойтон нуга	22	1593.1	Малын бэлчээрт ашиглах, мелорацийн арга хэмжээ авсны үндсэн дээр газар тариаланд хэсэгчлэн ашиглах
42		Аллювийн нугын хээржсэн ба үеэлсэн сулавтар хөгжилтэй хөрстэй өвслөг ургамалтай татмын нуга	21	1646.2	Ихэнхдээ малын бэлчээрт ашиглах ба боломжтой газраас хэсэгчлэн газар тариалан, түүний дотроос усалгаатай тариаланд ашиглах боломжтой.
43		Уулын бэл хормойн гуу жалгийн бүрдэл	23	288.5	Хязгаарлагдмал ашиглалттай
Бүгд дүн				86968.8	

Анги: Ой хээрийн дундаж ба нам уулс-уулс дотоодын нугачаат хөндий

Тэгш, хавтгай, эсвэл бөмбөгөрдүү хэлбэртэй, хажуу нь ихээхэн мөлийсөн дундажаар 1800-2000 м-ийн өндөрт өргөгдсөн, 100-200 м-ийн харьцах өндөртэй дундаж бай нам уулсын ам хөндийг хамруулав. Ургамлан ба хөрс нөмрөг нугархаг шинжтэй ба хөрс нь харьцангуй сайн тогтворжсон үе давхаргын ялгарал сайтай, үржил шимээр сайн боловч тархалтын хувьд алаг цоог, бага талбай эзлэх учраас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахад төдийлөн үр ашигтай бус боловч өрхийн аж ахуй, жижиг үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулан түүвэрлэн ашиглах боломжтой. Гадаргын болоод гүний усны хангамж бусад газруудаас сайн. Голлон нугын ба нугархаг хээрийн ургамалжилт давамгайлна. Ургамлан бүрхэвч нь өтгөн, ургац сайтай, зүйлийн бүрэлдэхүүнээр баялаг, малын сайн чанарын бэлчээрт тооцогдоно.

Дэд анги: Уулын ойн ширэгт ялзмагт, глейрхэг болон уулын ойн хар бараан хөрст шилмүүс ба холимог ойт дундаж уулсын орой, ар хажуу налуу /Инд-11/

Үргэлжилсэн шилмүүс ба холимог ойтой дундаж уулсын орой, хажуу налууугаар тогтсон уулын ойн бараан өнгийн хөрстэй, ургамалжилтын хувьд хиага-алаг өвст, үетэн-алаг өвст, ботууль-алаг өвс-улалжит, ботууль-зүр өвст эвшил давамгайна. Ургамлан бүрхэвч сайтайгаас гадна зарим ховордсон ба нэн ховордсон төрөл зүйлийн ургамал тааралдана. Экологийн байдлыг алдагдуулалгүй хадгалан хамгаалах, зэрлэг ан амьтан, сарлагийн бэлчээр болон хүн амын социаль нөхөн сэргэлтийн зориулалтаар ашиглана.

Дэд анги: Уулын ойн цэвдэгт ба ширэгт хар бараан ба хар шороон маягийн хөрстэй сөөг бүхий өвслөг ургамалтай сийрэг ойт дундаж ба нам уулын ар, өвөр, баруун зүүн хажуу налууугийн доод хэсэг, хормой, өвөр ба баруун зүүн хажуу /Инд-12/

Дундаж ба нам уулын ар, өвөр, баруун зүүн хажуу налууугийн доод хэсэг, хормой, өвөр ба баруун зүүн хажуу хэсэгт тогтсон сөөг ихтэй сийрэг ойтой уулын хар хүрэн, уулын сулавтар хөгжилтэй хар шороон болон уулын ойн бараан өнгийн хөрстэй, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, хялгана-алаг өвст, хялгана-зүр өвст, зүр өвс, зүр өвс-алаг өвст, зүр өвс-хялганат эвшил давамгайлсан. Биологийн төрөл зүйлийг хамгаалан аялал жуулчлал, амралт сувилал хагжүүлэх, байгалийн дагалдах баялаг болох жимс, самар, эмийн ургамал зэрэгт мэргэжлийн хяналтын доор эрчимтэй бус ашиглалтыг хангуулах ашиглана.

Анги: Нугархаг хээрийн дундаж нам уулс-уулс хоорондын тэгшивтэр хөндий

Дундаж ба нам уулсын хоорондохи тэгшивтэр хөндий нь монгол орны жинхэнэ хуурай хээрийг бодвол харьцангуй нугархаг шинжээ хадгалсан байна. Хад чулуу багатай, харьцангуй сайн тогтворжсон шаварлаг бүтэцтэй хөрсөн бүрхэвчтэй, голдуу үржил шим сайтай хар хүрэн хөрс зонхилно. Харин арай өндөрлөг гадаргаар хүрэн хөрс тааралдах боловч хуурай хээрийн хүрэн хөрснөөс нилээд ялгагдах үлдмэл нугын шинж тэмдэг ажиглагдана. Хөрс нь гол төлөв шавранцар механикийн бүрэлдэхүүнтэй учраас ашиглалт даах чадвар нь харьцангуй сайн. Газрын унаган чанараараа энэ газар нь агроүйлдвэрлэлийн н сайн чанартай газарт тооцогдоно.

Дэд анги: Уулын сулавтар хөгжилтэй хар хүрэн хөрстэй сийрэг өвслөг ургамалтай бага зэрэг сөөгтэй чулуурхаг гадаргатай дундаж ба нам уулсын орой дээд энгэр хажуу /Инд-21/

Дундаж ба нам уулсын орой, дээд энгэр хажуу налууд тогтсон сийрэг өвслөг ургамалтай, бага зэрэг сөөгтэй чулуурхаг гадаргатай, сулавтар хөгжилтэй хар шороон болон уулын сулавтар хөгжилтэй хар хүрэн хөрстэй ботууль-алаг өвс-агьт, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, хялгана-алаг өвст эвшил бүхий ургамлан бүрхэвчтэй адуу болон бог мал, ан амьтны бэлчээрт илүү тохиромжтой.

Дэд анги: Уулын хар хүрэн ба хүрэн хөрстэй өвслөг ургамалтай дундаж ба нам уулсын хажуу налуу, хормой /Инд-22/

Ойн залгаа уулын ар ба дундаж, нам уулсын баруун хажуу налууд тогтсон уулын хар хүрэн ба хүрэн хөрстэй, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-хялганат, үетэн-улалж-алаг өвст, ботууль-алаг өвст,

Дэд анги: Уулын нугын хүрэн ба хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын нарийн ам хөндий /Инд-23/

Уулс хоорондын нарийн ам хөндийд тогтсон уулын нугын хүрэн хөрстэй, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, үетэн-алаг өвст, ботууль-алаг өвст, биелэг-үетэн алаг өвст эвшил зонхилсон. Бүх төрлийн мал ан амьтаны бэлчээрт ашиглана. Тариаланд түүвэрлэн ашиглах боломжтой.

Дэд анги: Шавранцар хар хүрэн хөрстөй өвслөг ургамалтай уулс хоорондын тэгшивтэр хөндий/Инд-24/

Дундаж ба нам уулс хоорондын тэгшивтэр хөндийд тогтсон. Шавранцар заримдаа элсэнцэр механикийн бүрэлдэхүүнтэй хар хүрэн нугын хүрэн, үлдмэл нугын шинжтэй хүрэн хөрстэй, хиагт, хиаг алаг өвст, ботууль-жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, ботууль хялганат, хялгана ботууль, хялгана- биелэгт, жижиг дэгнүүлт үетэнт- хиагт,биелэг- үетэнт, биелэг- хиагт,дааган сүүл- үетэнт, ерхөг-үетэнт,алаг өвс-үетэнт, жижиг улалж- үетэнт эвшил зонхилсон. Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой, бүх төрлийн малын бэлчээрт ашиглана. Хөрс хамгаалалтын арга хэмжээ авч хөрсний үржил шимийг тэтгэх,усны горимыг тохируулах арга хэмжээ авах шаардлагатай.

Анги: Хуурай хээрийн дундаж ба нам уулс-уулс хоорондын тэгшивтэр ба долгиорхог хөндий

Дундаж ба нам уулсын хоорондохи харьцангуй өргөн сулавтар долгиорхог гадаргатай хөндийг энэхүү ангид хамруулав. Өмнөхи ангийг бодвол чийгийн дутагдал харьцангуй их, дулааны хангамж сайтай. Үүнтэй холбоотойгоор хөрсөн бүрхэвчинд хар хүрэн, хүрэн цайвар хүрэн хөрс зонхилно. Хүрэн хөрс нь гол төлөв бэлчээрт ашиглагддаг ба агроүйлдвэрлэлийн дунд зэргийн чанартай хөрсөнд тооцогдоно. Гэвч нэмэлт арга хэмжээ авснаар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах бүрэн боломжтой. Энэ хөрсийг ашиглахад ус чийгийн горимыг нарийн бодолцохоос гадна хөнгөн механикийн бүрэлдэхүүнтэй учраас хөрсийг салхины эвдрэлээс хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай.

Дэд анги: Уулын хүрэн ба сул хөгжилтэй хүрэн хөрстөй сийрэг ургамалтай чулуурхаг гадрагатай дундаж ба нам уулын орой, хажуу налуу /Инд-31/

Ой модгүй нүцгэн хуурай хээрийн дундаж ба нам уулын орой, хажуу налууд тогтсон. Уулын сулавтар хөгжилтэй хүрэн, уулын хүрэн хөрс тархсан, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-агьт, хялгана-ерхөгт, ерхөг- хялгана- агьт, үетэн-хялганат, алаг өвс- агь- үетэнт эвшил зонхилсон. Бүх төрлийн мал ан амьтны бэлчээрт ашиглана.

Дэд анги: Шавранцар хүрэн, заримдаа хар хүрэн хөрстөй өвслөг ургамалтай уулс хоорондын ухаа гүвээт долгиорхог өргөн хөндий /Инд-32/

Уулс хоорондын ухаа гүвээт долгиорхог өргөн хөндийд тогтсон. Шавранцар хүрэн, хар хүрэн хөрс,үлдмэл нугын шинжтэй хүрэн, нугын хүрэн хөрстэй, хиаг-жижиг дэгнүүлт үетэнт,хиаг-хазаар өвст, хиаг-дэрст,хялгана- жижиг дэгнүүлт

үетэнт, хялгана-хиагт, хялгана-хазаарт, хялгана- дааган сүүлт, хялгана-монгол өвст, хялгана- алаг өвст, хялгана зүр өвст, жижиг дэгнүүлт үетэн- хялганат, зүр өвс- алаг өвст эвшил зонхилсон. Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой, бүх төрлийн малын бэлчээрт ашиглана. Хөрс хамгаалалтын арга хэмжээ авч хөрсний үржил шимийг тэтгэх, усны горимыг тохируулах арга хэмжээ авах шаардлагатай.

**Анги: Бүс дундын голын хөндий болон гадагш урсгалгүй
нам хотсууд**

Монгол орны байгалийн янз бүрийн бүс бүслүүт нилээд түгээмэл шинжтэй тархах голын хөндий, хужир мараат нам хотос, гуу жалгын бүрдлийн тусад нь ялган энэхүү ангид хамруулдаг ба тус аймгийн хувьд Хангалын гол, Эрдэнэтийн гол, Зуны гол, Говилын гол, Чингэлийн гол болон гадагш урсгалгүй хэд хэдэн жижиг нууруудын сав газрыг энэ ангид хамрууллаа. Голын хөндийн хөрс нь нь усны байнгын нөлөөгөөр хуримтлагдах аллювийн хурдас дээр тогтдог ба Хангайн бүсийн голуудын нэгэн адил давсжилтын шинж тэмдэг хөрсөнд бараг илэрсэнгүй.

**Дэд анги: Голын хөндийн аллювийн нуга-намгийн хөрстөй гидрофит
ургамал бүхий нойтон нуга /Инд-41/**

Голын хөндийд тогтсон, аллювийн нуга-намгийн шаварлаг, хүлэрлэг-глеет, хүлэрлэг- ялзмагт болон нуга-намгийн шаварлаг, ялзмагт хөрстэй. Улалж-үетэнт, улалж-алаантолгойт, улалж-алаг өвст, үетэн-улалж-алаг өвст эвшил зонхилсон. Малын бэлчээрт ашиглах, мелорацийн арга хэмжээ авсны үндсэн дээр газар тариаланд хэсэгчлэн ашиглах арга хэмжээ авах шаардлагатай. Энэ нь Хангалын голын хөндийгөөр тааралдана.

**Дэд анги: Аллювийн нугийн хээржсэн ба үеэлсэн сулавтар хөгжилтэй
хөрст өвөслөг ургамалтай татмын нуга /Инд-42/**

Аллювийн нуга болон аллювийн нугын ширхэгт, хээржсэн хөрс, үелсэн сулавтар хөрстэй, улалж-үетэнт, улалж-улаантолгойт, улалж-алаг өвст, үетэн-улалж-алаг өвст эвшил зонхилсон. Ихэнхдээ малын бэлчээрт ашиглах ба боломжтой газраас хэсэгчлэн газар тариалан, түүний дотроос усалгаатай тариаланд ашиглах боломжтой.

Дэд анги: Уулын бэл хормойн гуу жалгын бүрдэл /Инд-43/

Гадаргын усны нөлөөгөөр өндөрлөг гадаргуугийн судгийг дамжин урсах атмосферийн тунадасны нөлөөгөөр үүссэн гуу жалгыг энэхүү ангид хамруулсан ба хөрсөн бүрхэвч нь үндсэндээ зулгарч, ургамалжилтанд сийрэг ургасан дэрс, шарилж, цахилдаг, харгана мэр сэр тааралдана. үндсэндээ ашиглах боломжгүй бөгөөд цаашид хөрс хамгаалалтын арга хэмжээ авахгүй бол эвдрэлийн процесс эрчимжиж орчны газар ашиглалтанд сөрөг нөлөө үзүүлдэг.

5.2. Газрын хадгалан хамгаалах нөхөн сэргээх, сайжруулах арга хэмжээ

5.2.1. Газрын төлөв байдал, чанарын өнөөгийн түвшин.

Монгол Улсын бусад аймгуудыг бодвол Орхон аймаг нь нутаг дэвсгэрийн нилээд онцлог нөхцөлтэй аймаг юм. Түүний 86,9 мян.га нутаг дэвсгэр дээр 82 мян хүн амьдарч байгаа нь үндсэндээ 1 хүн 1 га газар ноогдож байгаа нь улсын дундажаас бараг 70 дахин бага, Улаанбаатар хотынхоос 2 дахин их бөгөөд нэг га бэлчээрт 2,4 хонин толгой мал ноогдож байна. Нийт нутаг дэвсгэрийн 18,7 хувь нь хот суурингийн, 10,1 хувь нь уурхайн зориулалтаар ашиглагддаг. Эдгээрээс харвал тус аймгийн газар ашиглалт ихээхэн ачаалалттай байгаа нь харагдаж байна.

Энэхүү ачааллын улмаас нилээд хэмжээний газар төлөв байдал чанарын өөрчлөлтөнд орсон ба цаашид ч энэ хэмжээ нэмэгдэх төлөвтэй байна. /хүснэгт 36/

Хүснэгт 36. Ашиглалтын явцад төрх байдлын өөрчлөлттэй болсон газруудын судалгаа

ДД	Төлөв байдлын өөрчлөлтийн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Цаашдын хандлага
1	Нийт талхлагдсан бэлчээр	Га	26488	Эрчимтэй нэмэгдэх
	Үүнээс: Их талхлагдсан	Га	8780	Эрчимтэй нэмэгдэх
2	Уурхайн үйл ажиллагаанаас эвэрсэн	Га	801,2	нэмэгдэх
3	Уурхайн үйл ажиллагаанаас бохирдсон	Га	1200	Эрчимтэй нэмэгдэх
4	Хотжилтын улмаас бохирдсон	Га	1023,1	Эрчимтэй нэмэгдэх
	Нийт дүн	га	29512.3	

Газар зохион байгуулалтын арга хэмжээний салшгүй бүрэлдэхүүн хэсгийн нэг нь газрыг зөв зохистой ашиглах, түүнийг хадгалан хамгаалснаар нутаг дэвсгэрийн экологийн тэнцвэрийг хангах асуудал байдаг. Иймд дээр дурьдсан сөрөг нөлөөллийг багасгах, цаашид таслан зогсоох зорилгоор дараахи арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино.

А/Бэлчээрийн газар

Орхон аймаг нь нийт 38 мянга гаруй бэлчээрийн газартай бөгөөд үүний 70 шахам хувь нь талхлагджээ. Нийт талхлагдсан бэлчээрийн 30 гаруй хувь нь их талхлагдаж цаашид бэлчээрийн эдэлбэрт ашиглах боломжгүй болж байгаа ба дунд зэрэг талхлагдсан бэлчээрийн ургамлын бүтэц бүрэлдэхүүнд байгаа малд муу идэгддэг өвсний арви ерөнхийдөө нэмэгдэж байгаа нь ойрын хугацаанд их талхлагдалтай болохыг харуулж байна. Иймд бэлчээрийг зохистой ашиглах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлбэл зохино.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу ХАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэх явцад талхлагдсан бэлчээрийн нилээд хэсэг нь нарийн төрөлжсөн аж ахуйнуудын эзэмшилт-ашиглалтанд шилжиж байгаа нь бэлчээр хамгаалалтанд сайнаар нөлөөлж цаашид нөхөн сэргээгдэх боломжтой гэж үзлээ. Харин чөлөөт ашиглалтын болон өрхийн аж ахуйн бүсэд байрлах 2017 га их талхлагдсан бэлчээрийн ашиглалтын горимыг дараахи байдлаар тогтоож зохион байгуулалтын арга хэмжээ авбал зохино.

Судалгаанаас харвал тус сумын бэлчээрт хялгана, ботууль, хиаг, хазаар өвс болон алаг өвст хээр болон нуга, татмын бэлчээрүүд зонхилж байгаа учир бэлчээрийг дараахи бүдүүвчийн дагуу гурван сэлгээтэйгээр ашиглаж төлөв байдал, чанарыг хадгалбал зохино.

Бэлчээрийг дулааны улиралд ашиглах гурван сэлгээт бүдүүвч

Ашиглах жилүүд	Бэлчээрийн хэсэг, түүнийг ашиглах дараалал		
	I хэсэг	II хэсэг	III хэсэг
0	1	2	3
Эхний жил	Зун /Y-YIII сард 3 ээлжээр/	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/	Намар /X-XI сард нэг ээлжээр/
0	1	2	3
Хоёр дахь жил	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/	/X-XI сард нэг ээлжээр/	Зун /Y-YIII сард 3 ээлжээр/
Гурав дахь жил	X-XI сард нэг ээлжээр	Зун /Y-YIII сард 3 ээлжээр/	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/

Харин талхлагдсан бэлчээрийг байгалийн аясаар нөхөн сэргээхэд доорхи сэлгээг хэрэглэнэ.

Талхлагдсан бэлчээрийг сэргээх сайжруулах сэлгээний бүдүүвч

Ашиглах дараалал /жилээр/	Бэлчээрийн хэсэг, түүний улирлаар ашиглах дараалал				
	I хэсэг	II хэсэг	III хэсэг	IV хэсэг	V хэсэг
Эхний жил	Y-YIII сард 2 ээлжээр	өнжөөнө	YIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр
Хоёр дахь жил	өнжөөнө	YIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Y-YIII сард 2 ээлжээр
Гурав дахь жил	YIII-X сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Y-YIII сард 2 ээлжээр	өнжөөнө
Дөрөв дэхь жил	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Y-YIII сард 2 ээлжээр	өнжөөнө	YIII-IX сард 1 ээлжээр
Тав дахь жил	X-XI сард 1 ээлжээр	Y-YIII сард 2 ээлжээр	өнжөөнө	YIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр

Б/ Уурхайн үйл ажиллагаанаас эвэрсэн болон бохирдсон газар

Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн үйлдвэрлэлийн цар хүрээ, технологийн онцлогоос харвал газрын төлөв байдалд цаашид ч сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Эрдэнэт үйлдвэр нь жилд дундажаар . . . га газарт нөхөн сэргээлт хийж байгаль орчныг хамгаалахад тодорхой хэмжээний зардал гаргах боловч зохистой хэмжээнд тэр бүр хүрч чадаагүй байна. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад нийт 1190 га газар овоолгын дор, 1200 га талбай хаягдлын сангийн дор байрлаж байна. Эдгээрийн нөлөөлөл нь байрлах газрын хэмжээгээрээ тодорхойлогдохгүй түүний орчны газрыг ч хамарч байгаа нь цаашид газрын төлөв байдалд хүчтэй нөлөөлөх эх үүсвэрүүдийн тоонд зүй ёсоор орж байна.

Иймд овоолгуудыг хөрсжүүлэх замаар хиймэл уул болгох, хаягдлын сангийн цагаан тоосыг дарах, бохир усны шүүрлийг багасгах арга хэмжээг юуны түрүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Харьцангуй бага талбайд их хэмжээний

хаягдал цугларч байгаа нь газар хөдлөлтөнд нөлөөлж болзошгүй багаа тул хаягдлын сангийн ачааллыг байнгын мониторинг хийж ачааллыг зохицуулах шаардлагатай болжээ. Мөн хаягдал орж ирж байгаа талаасаа газрын гадаргуу дээшилснээс болж бохир ус хойт тал руугаа тунаж тогтож байгаагаас нэвчилт үүсч хөрсний ус бохирдох нөхцлийг бүрдүүлж байна.

Эрдэнэтийн үйлдвэрийн харьяаллын бус түгээмэл тархацтай зарим баялгийг ашиглах зорилготой хэд хэдэн жижиг карьерууд байгаа бөгөөд тэдгээрийг нөхөн сэргээх талаар ажил хийгдэхгүй байна. Эдгээрийг хөрсжүүлэх арга хэмжээг эзэмшигч ашиглагчдийн үчээр тодорхой эзэнгүй карьеруудыг орн нутгийн төсвөөс газрын төлбөрийн орлогыг тодорхой хувиар санхүүжүүлэн хийхэд орон нутгийн захиргаа, гакзрын албадууд санаачлагатай ажиллах шаардлагатай юм.

В/ Хотжилтын улмаас бохирдсон газар

Суурин соёл иргэншлийн явцад газрын нэгж талбайд ирэх экологийн ачаалал харьцангуй их байдаг боловч түүнийг зохистой инженерийн шийдлээр багасгаж болдог байна. Гэтэл монгол ахуйн зан заншил, улс орны эдийн засгийн нөөц боломжоос шалтгаалан гэр хороолол гэдэг хямд төсөр, инженерийн шийдэл үгүй орон сууц хот суурин газарт тэлж байгаа нь хөрс болон агаарын бохирдлыг нэмэгдүүлэх шалтгаан болжээ. Гэр хорооллын үйл ажиллагаанаас хөрс их хэмжээгээр физик элэгдэлд орж, ахуйн шалтгаанаас бохирдож чанараа алддаг ба ердийн галлагаанаас болж дутуу шаталтын нөлөөгөөр агаарын бохирдол ч нэмэгдэж байна. Эрдэнэт хот нь одоогийн байдлаар 1025 га газрыг гэр хороололд ашиглаж байгаа ба төлөвлөлтийн хугацаанд 2,9 мян.га-гаар тэлэх юм. Үүнээс үзвэл гэр хорооллоос газарт үзүүлэх нөлөөлөл багасахгүй харин ихсэх хандлагатай байна. Энэ нөлөөллийг багасгахын тулд юуны өмнө гудамж хоорондын автозамыг цэгцлэх, хашаанд зүлэг мод тариалах, бохирын цооногуудыг хатуу доторлогоотой болгож бохирыг зөөврийн аргаар хотын цэвэрлэх байгууламжинд нийлүүлэх, хатуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт хүргэх, малтай өрхийн бүс нутгийг нарийн зааглан тогтоох, гэр хороололд дэд бүтцийг хөгжүүлэх асуудлыг үе шаттайгаар шийдэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг улс, орон нутаг, газар эзэмшигч, ашиглагчийн түвшинд хэрэгжүүлбэл зохино. Газрын шинэтгэлийн хүрээнд гэр хорооллын газрыг өмчлүүлэн эдийн засгийн эргэлтэнд орж байгаа өнөөгийн нөхцөлд газраа нөхөн сэргээх, хадгалан хамгаалах зорилгоор тодорхой ажил хийсэн газар эзэмшигч өмчлөгчдийн газрын үнэлгээ, татварын асуудлыг ч төрөөс зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгтэй.

Гэр хорооллын галлагааны нөхцлийг сайжруулах, бүрэн шаталттай зуух, утаагүй түлш үйлдвэрлэх талаар орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн аливаа санаачлагыг дэмжих, бохирдлын эх үүсвэр бүхий газар эзэмшигч ашиглагч өмчлөгчдөд экологийн хариуцлага ноогдуулж улмаар тэдгээрээс орсон орлогыг газрыг хамгаалах нөхөн сэргээх, байгаль орчны бохирдлыг бууруулахад зарцуулахад анхаарах.

Г/ Ойн сангийн газар

Сүүлийн жилүүдэд монгол орны ойн сан бүхий газарт нийтлэг ажиглагдаж байгаа хортон шавьжны хөнөөл тус аймгийн ойн сангийн газарт ажиглагдаж байна. 2003 оны 6-р сард ой, усны хайгуул, судалгааны төвөөс Баян-Өндөр, Жаргалант сумын нутагт нийт 20968 га ойн талбайд явуулсан судалгааны үр дүнд

2000 га талбайд шилмүүсний навч хөнөөлт шавьж болох Өрөөсгөл хүр эрвээхэй тархаад байгааг тогтоожээ.

Энэ судалгааны ажлын үндсэн дээр зайлшгүй тэмцэл явуулах газруудыг сонгон авч Шар чулуут, Бурхант, Борт зэрэг нутгийн 100 га талбайд микробиологийн аргаар тэмцлийн ажлыг гүйцэтгэн устгал хийсэн байна. /Зураг /

5.2.2. Газрыг хадгалан хамгаалах арга хэмжээ:

Газрыг хадгалан хамгаалах зорилгоор түүнийг тусгай хамгаалалтад авч ашиглалтын нарийн горим тогтоох ерөнхий зарчим монгол оронд хэрэгжээд нилээдгүй хугацаа өнгөрлөө. Орхон аймаг нь энэ асуудлын хүрээнд Баян Өндөр уулыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан ба Жаргалант сумын хэмжээнд Хангалын голын савд байгаа бургасыг тусгай хамгаалалтад авсан болно. Эдгээрийн талбай нилээд 1415 га газрыг эзлэх бөгөөд энэ нь нийт нутгийн 1,6 хувьтай тэнцэж байна. Цаашид экологийн тэнцвэрийг хадгалах үүднээс Согоотын нурууны газар нутгийг тусгай хамгаалалтад авч ашиглалтыг горимлох шаардлагатай юм. Тусгай хамгаалалттай газруудад явуулах үйл ажиллагаанд зохицуулалт хийж иргэд амрах, аялал зугаалга хийх болон байгальд нөлөөлөхгүйгээр уламжлалт аж ахуй эрхлэхийг зөвшөөрнө. Байгаль орчинд нөлөөлөх бусад үйл ажиллагааг хязгаарлах хэрэгтэй.

Мөн хүний буруу ашиглалт болон бусад хүчин зүйлийн нөлөөллийн улмаас ургамалжилтын хувьд үндсэн хэв шинжээ алдаж их талхлагдалд орсон Хангалын голын хөндий болон Ар хөндийн нийт 1823.3 га газрыг ашиглалтаас бүрэн чөлөөлж нөхөн сэргээх, сайруулах шаардлагатай гэж үзэж байна. Энд 2-3 жил ашиглахгүй байгалийн аясаар нөхөн сэргээх, шаардлагатай бол нэмэлт арга хэмжээ авч нөхөн сэргээсний дараа зориулалтын дагуу ашиглах нь зүйтэй.

5.3. Газрын эдийн засгийн үнэлгээ, удирдлага, зохион байгуулалт

5.3.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний үндсэн дээр тус аймгийн нэгдмэл сангийн өөрчлөлтийг дараахи байдалтай байна. /Хүснэгт 37/

Хүснэгт 37. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлтийн байдал

ДД	Газар ашиглалтын зориулалтууд	төлөвлөл тийн өмнөх үе	төлөвлөл төөр	өөрч лөлт
1.	Хот суурин газар	13576.5	16492.9	+2916.4
2.	Хүн амын социаль нөхөн сэргээлтийн бүс	1498.3	5772.4	+4274.1
3.	Усан сан бүхий газар		2821.5	+2821.5
4.	Газар, ховор ландшафтыг хадгалах бүс	1415.4	2600.5	+1185.1
5	Нийтийн зориулалтын ашиглалттай бэлчээрийн газар	39748.7	38182.7	-1566.0

5.1.	Хуваарьт эдлэнтэй эрчимжсэн аж ахуйн бүс		15307.5	+15307.5
5.2.	Хуваарьт эдлэн, нийтийн ашиглалтын газар хосолсон аж ахуйн бүс		6145.4	+6145.4
5.3.	Өрхийн аж ахуйн суурьшлын болон чөлөөт ашиглалтын бүс		376.3	+376.3
5.4.	Чөлөөт ашиглалтын бүс болон мал тууврын зам		16353.5	+16353.5
6.	Хадлангийн газар	1286.2	2533.9	+1247.7
7.	Тариалангийн газрын эзэмшилт-ашиглалтын бүс	5577.1	5807.3	+230.2
7.1.	ААН-д эзэмшүүлэх	5348.2	5561.5	+213.3
7.2.	Өрхийн аж ахуйд эзэмшүүлэх	105.8	122.7	+16.9
7.3.	Атаршуулах талбай		123.1	-123.1
8.	Үйлдвэр уурхайн бүс	5548.6	8810.5	+3261.9
9.	Ойн сангийн газар	15602.0	16858.8	+1256.8
9.1.	Мод үржүүлгийн газар		5.9	+5.9

Дээрх хүснэгтэс харахад уламжлалт мал аж ахуйн зориулалтаар дундаа чөлөөтэй ашигладаг бэлчээрийн хэмжээ ихээхэн багасаж түүнийг төрөлжсөн үйлдвэрлэлийн эрчимжсэн аж ахуйнуудад эзэмшүүлэх, үржил шимийн хувьд газар тариаланд тохиромжтой боловч улсын тусгай хэрэгцээний шаардлагаар төмөр замын зурваст багтах 123,1 га тариалангийн газрыг атаршуулж тариалангийн эдэлбэрээс хасахаар тусгагджээ. Харин бусад төрлийн газруудын хэмжээ нэмэгдэж байна. Тухайлбал хотожсон бүс нь 2916.4 га-гаар, хүн амын социаль нөхөн сэргээлтийн бүс 4274.1 га-гаар тус тус нэмэгдэж байна. Харин эдгээр өөрчлөлтийн ашиглалтын зориулалтыг хавсралт . . . хүснэгтээс харах боломжтой

Усан сан бүхий газрын экологийн хамгаалалтын бүс, ундны усны хамгаалалтын бүсийг газар нөөшлөх бүсэдхамрууллаа. Усны хамгаалалтын буюу усны эрэг орчмын бүсийг ширгэсэн болон байнгын урсгалтай голуудыг оролцуулсан ба нийт 2821.5 га газрыг хамарсан ба үүний томоохон бүс нь Хангалын гол нийт 331.3 га газрыг эзэлнэ.

Газар болон ховор ландшафтыг хадгалах бүсийн хувьд аймгийн хэмжээнд өмнө байсан 2 газар, нэмж төлөвлөсөн 1 газрыг орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг гэж үзэн, 1185.1 га талбайгаар нэмж, нийт 2600.5 га талбай болгохоор төлөвлөсөн.

Хөдөө аж ахуйн газрын менежментийн бүсүүдэд бэлчээр, хадлан, тариалангийн газрууд орж байна. Төлөвлөлтийн өмнө бэлчээрийн газар нь 39748.7 га байсан бол төлөвлөлтөөр 38182.7 га болсон. Бэлчээрийн талбайгаас хасагдсан хэмжээ нь хадлангийн болон тариалангийн талбайд нэмэгдэж байна. Бэлчээрийг 4 бүс болгон төлөвлөж байгаа бөгөөд эдгээрт хуваарьт эдлэнтэй эрчимжсэн аж ахуйн бүс 15307.5 га, хуваарьт эдлэн, нийтийн ашиглалтын газар

хосолсон аж ахйн бүс 6145.4 га, өрхийн аж ахуйн суурьшлын бүс 376.3 га, чөлөөт ашиглалтын болон мал тууврын зам, бусад бэлчээрийн газрууд 16353.5 га байна.

Хадлангийн газрын хувьд одоо байгаа 1286.2 га, цаашид 2533.9 га талбайгаас хадлан бэлтгэх боломжтой юм. Төлөвлөлтөөр 1247.7 га талбайг хадлан нэмж ашиглах боломжтой байна. Өөрөөр хэлбэл энэ нь хадаж болох бэлчээр юм.

Тариалангийн газрын эзэмшилт-ашиглалтын 3 бүсийг төлөвлөгдөж байгаагийн 5561.5 га нь аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил-ашиглалтад олгогдож байна. Энэ нь төлөвлөгөөний өмнөх үеийнхээс 213.3 га талбайгаар нэмэгдсэн. Өрхийн аж ахуйд эзэмшүүлэх газрын хэмжээ төлөвлөлтөөр 122.7 га болж нийт 16.9 га талбайгаар нэмэгдэхээр төлөвлөгдсөн. Атаршуулах талбайн хэмжээ 123.1 га талбай байна.

Үйлдвэр уурхайн бүс газар нь төлөвлөлтийн өмнө үед 5548.6 га байна. Энэ нь зөвхөн Эрдэнэт үйлдвэрийн төлбөр ногдуулдаг газрын хэмжээ бөгөөд нийт үйлдвэр, уурхайн эдэлбэр нь 8810.5 га талбай юм. Энэ нь Эрдэнэт үйлдвэр олгогдсон газрын хэмжээ болон цаашид ашиглах, олборлох ордуудын талбай орно.

Ойн сан бүхий газрын хэмжээ нь 16858.8 га бөгөөд төлөвлөлтөөр 5.9 га талбайг мод үржүүлгийн талбай байгуулахаар төлөвлөсөн. Дээрх талбай нь ойгоор бүрхэгдсэн болон ойн цоорхойн талбайг хамарч байна.

5.3.2. Газрын эдийн засгийн үнэлгээ

Газрын төлбөр нь ерөнхий төлөвлөгөөний явцад өөрчлөгдсөн газрын хэмжээнээс хамаарч өөрчлөгдөж байгаа. Газарт ногдуулах төлбөрийн доод болон дээд хэмжээг Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралтад заасан хэмжээгээр авсан. Орхон аймаг нь Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолын 1 дугаар хавсралтад зааснаар Газрын нэгдмэл сангийн үнэлгээний тойргийн хуваариар Хангай Хэнтий уулархаг тойрог орно. /Хүснэгт 38/


Хүснэгт 38. Газрын төлбөрийн өөрчлөлт

ДД	Газрын менежментийн бүсүүд	төлөвлөлтийн өмнөх үе		төлөвлөлтөөр		төлбөрийн өөрчлөлт /мян.төг/
		талбай /га/	төлбөр /мян.төг/	талбай /га/	төлбөр /мян.төг/	
1.	Хотжсон бүс	13576.5	100300.4	16492.9	122047.5	+21747.1
2	Зохион байгуулалттай амралтын бүс	-	-	3013.6	331.5	+331.5
3	Усан сан бүхий газрын экологийн хамгаалалтын бүс	-	-	2821.5	1128.6	+1128.6
3	Газар болон ховор ландшафтыг хадгалах бүс /орон нутгийн тусгай хамгаалалт/	1415.4	1248	2600.5	2340.5	+1092.5
4	Хуваарьт эдлэнтэй эрчимжсэн аж ахуйн бүсийн бэлчээр	-	-	15307.5	11748.5	+11748.5

5.	Хуваарьт эдлэн, нийтийн ашиглалтын газар хосолсон аж ахуйн бүсийн бэлчээр	-	88	6145.4	4716.6	+4628.6
6.	Хадлангийн газар	1286.2	-	2533.9	628.4	+628.4
7.	Тариалангийн газар	5577.1	5212	5807.3	5226.6	+14.6
8.	Үйлдвэр уурхайн бүс	5548.6	3260000	8810.5	5180574	+1920574
9.	Ойн сангийн газар	15602.0	-	16858.8	251.3	+251.3
Нийт дүн			3366848		5327282	+1960522

Хүснэгт 38-аас харвал УБҮ-ийн газрын төлбөрийн орлого 2020 оны түвшинд давамгайлсан хэвээр байх болно. Мөн хот суурин газарт 21747.1 мянган төгрөгөөр нэмэгдэх боломжтой бол ХАА-н бүс газарт 17020.1 мянган төгрөгөөр төлбөр нэмэгдэх бөгөөд үүнээс бэлчээрийн газарт 11748.5 мянган төгрөг, хадлангийн газарт 628.4 мянган төгрөг, тариалангийн газарт 14.6 мянган төгрөг нэмэгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсан.

Диаграмм 9



Тайлбар: 1-хотжсон бүс, 2-Үйлдвэр, 3-Усан сан, 4-ХААН, 5,ТХГ, 6-Ой сан

Газрын сангийн өөрчлөлттэй холбоотойгоор түүнээс авч болох ашгийг тооцож үзвэл: Тариалангийн газрын хэмжээ 230.2 га-гаар нэмэгдэх ба үүний 16.9 га-г иргэний хувийн хэрэгцээнд төмс, хүнсний ногоо тариалах зорилгоор олгох бөгөөд иргэд үүний үр дүнд 3380 тн төмс, хүнсний ногоо шинээр хураан авч зах зээлийн үнээр 1 сая орчим төгрөгийн цэвэр ашиг жилд хуримтлагдана.

213.3 га талбайг тариалангийн талбайд нэмж элдэншүүлэн аж ахуйн нэгж байгууллагад олгосноор жилд 5.2 сая төгрөгийн төлбөр авдаг байснаа 5.4 сая төгрөг хүргэх боломжтой.

Хадлангийн талбайг 1247.7 га-гаар нэмэгдүүлж 1 га хадлангийн талбай ашигласны төлбөрийг 250 төгрөгөөр тооцвол 311 мянган төгрөг нэмж орон нутгийн төсөвт орно.

Гэр хорооллын шинээр суурьших хэсэгт байрлалаас хамааран 2 000-10 000 төгрөгийн жилийн төлбөр хураана гэж үзвэл 2916.4 га газраас доод хэмжээгээр 5.8 сая төгрөгийн орлого төсөвт орно.

Амралтын бүсэд 3013.6 га талбайг шинээр төлөвлөснөөр аж ахуйн нэгж байгууллагад эзэмшүүлэх, аялал зугаалгын хураамж зэргээс жилд 150 орчим мянган төгрөгийн орлого орно.

ДҮГНЭЛТ

1. Орхон аймаг нь уул уурхайн үйлдвэрлэлд тулгуурласан эдийн засгийн чиглэлтэй бөгөөд ордын нөөц ашиглалт газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн үе шатуудад хадгалагдана. Үүгээр энэхүү ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн үндэс тодорхойлогдож байна.
2. Газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд аймгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн өнөөгийн ба ирээдүйн чиглэлийг нутаг дэвсгэрийн экологи-орон зайн багтаамжид түшиглэн 4 жилийн үелэлтэйгээр 2020 оныг хамруулав.
3. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа тус аймгийн нутаг дэвсгэрийн том масштабын суурь судалгаа явуулж экологи-орон зайн багтаамж, даацыг тодорхойлсон ба орон зай бүрийн газар ашиглалтын өнөөгийн байдлыг ойр, хэтийн чиглэлтэй уялдуулан хэмжээ, байршлыг зохистой тогтоон холбогдох масштабаар зураглан харууллаа.
4. Төлөвлөлтийн шийдлээс харвал тус аймгийн хөгжлийн гол тулгуур нь газрын хэвлийн ашиглалт ба түүнийг даган хөгжих хотжилтын хэрэгцээ хангамж нь эдийн засгийн дэд бүтцүүдийг тодорхойлж байна. Энэ үүднээс хот орчмын ХАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, нутаг дэвсгэрийн хязгаарлагдмал зайг зохистой ашиглах хувилбар нь эрчимжсэн ХАА-н үйлдвэрлэл ба түүнд зохицсон нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг энэхүү төлөвлөлтөөр шийдвэрлэсэн болно.
5. Эрдэнэт хотын ба үйлдвэрийн хөгжлийн бодлоготой уялдсан газрын харилцааны орчинг бүрдүүлэхдээ нэг талаас газар ба байгаль орчныг хамгаалах, нөгөө талаас газрын харилцаанд оролцогчдын эрх ашгийг хуулийн хүрээнд тогтвортой хамгаалах шаардлагын үүднээс газар ашиглалтын бүсчлэлийг нарийвчлан тогтоолоо.
6. Газар эзэмшилт ашиглалтын өнөөгийн байдлыг боловсронгуй болгосноор газрын эдийн засгийн харилцаанд зохих өөрчлөлт орж газрын төлбөрийн орлого нилээд хэмжээгээр нэмэгдэж байна.
7. Энэхүү газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь нутаг дэвсгэрийн зохистой ашиглалтыг шийдвэрлэснээрээ цаашид аймгийн хэмжээнд тогтвортой газар ашиглалтын үндсийг бүрдүүлсэн, газрын харилцааны ерөнхий чиглэлийг тодорхойлсон бодлогын баримт бичиг болно.

Ашигласан ном, бүтээлийн жагсаалт

Ном, бүтээл

1. Э.М. Мурзаев. “ К физикогеографическому районированию МНР” . Проблемы физической географий. Вып. 13.1948.
2. Ш.Цэгмид. Монгол орны физик газар зүй УБ-1967
3. Орос гипрозимээс 1973 онд явуулан хөрс судалгааны материал 1974
4. В. Каромышева, Д.Банзрагч кн. “Растительный и животный мир Монголий” П. 1977.
5. Улаан толгойн САА-н Бэлчээрийн зураг. г. Москва. Институт РОСГИПРОЗЕМ. 1974.
6. “Хангал голын ай савын байгалийн нөхцөл” бүлэг. ШУА-н ГЗХ-н товхимол.
7. Улаан толгойн САА-н Дотоодын газар зохион байгуулалтын төсөл. СССР. СЕЛЬХОЗПРОМЭКСПОРТ.1974.
8. Г. Цолмон “Монгол орны бэлчээр хадлангийн ангилаа”ГБХ.1993
9. Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралт “Нэн ховор ургамлын жагсаалт”1995.
10. Ч.Гончигсумлаа.Хөрс судлалын үндсүүд УБ-1995
11. Дикорастующие полезные растения флоры МНР. т. XXIII “Наука” Л.
12. Ш.Баясгалан Д.Даваадорж . Монгол орны ХАА-н уур амьсгалын лавлах.1996.
13. Г.Пүрэвцэрэн., Ж.Наранцацралт. Газрын менежментийн онолын үндэс. 2000 он
14. Г.Пүрэвцэрэн Газрын сангийн менежмент 2000 он
15. Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан 2001 он
16. Д.Доржготов.Монгол орны хөрс УБ-2003
17. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тайлан. ГХГЗЗГ. 2003
18. Орхон аймгийн цаг уурын станцын мэдээ. 2003 он
19. Бэлчээрийн биобүтээмж” МААЭШХ. ШУТ-ийн төслийн элш тайлан 2000он.УБ.
20. Улсын Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан 2003 он
21. Л.Уранбилэг “Нийслэл орчимд сүүний эрчимжсэн аж ахуй хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн агроэкологийн үнэлгээ” сэдэвт магистрын ажил 2003 он
22. Орхон аймгийн байгаль орчны төлөв байдлын тайлан. 2003 он.
23. Орхон аймгийн Ойн менежментийн төлөвлөгөөний тайлан. 2001 он.
24. Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2003 он ГХГЗЗГ, УБ

Хууль тогтоомж :

1. Газрын тухай хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он
2. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль.
3. Газрын хэвлийн тухай хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он
4. Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он
5. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого
6. Ойн тухай хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он
7. Усны тухай хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он
8. Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хууль. Ардын эрх сонин. 1994 он
9. Автозамын тухай хууль. Ардын эрх сонин. 1998 он.
10. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль. Ардын эрх сонин. 1996 он.